

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ “ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ” ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

/2018 оны жилийн эцсийн байдлаар/

2018.11.28.

Булган

НЭГ. ХҮН-НИЙГМИЙН ХӨГЖИЛ

Гэр бүлийг дэмжих, иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд анхаарч, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, иргэдийнхээ амьжиргааг сайжруулна.

Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	Арга хэмжээний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)		Хэрэгжилтийн хувь
						2018 он		
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
1	2	3	4	5	6	7	8	9
1.1. Боловсрол:								
Иргэдийн сурч боловсрох, хөгжих эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлж, суралцах, хөгжих таатай орчныг бүрдүүлэн багшийн мэргэжлийн үнэлэмж, ур чадварыг дээшлүүлж, оюунлаг, бүтээлч иргэдийг төлөвшүүлнэ.								
/1/ 1.1.1. Боловсролын салбарын удирдах ажилтан, багш сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, заах аргыг сайжруулах замаар боловсролын салбарын хүний нөөцийг бэхжүүлнэ.	1	1.1.1.1. Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын үр дүнг дэмжих, сурагчдын сурах идэвхийг өрнүүлэх зорилгоор “Амжилтын галт тэрэг” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх	2016 - 2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	1.9	Багш нарын идэвх, санаачлага, хариуцлага сайжирч, ажлын үр дүн бодитоор нэмэгдсэн байна.	2017 оны 11 дүгээр сарын 17-ны аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 135 дугаар тогтоолоор "Амжилтын галт тэрэг" дэд хөтөлбөрийг батлуулан, бүх сургууль, цэцэрлэгүүдэд сурталчлан, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллалаа. "Бүтээлч багш" шалгаруулах уралдааны болзол, журам боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Улсын төрөлжсөн олимпиадад эхний 3 байр эзэлсэн багш, сурагчид, ЭЕШ-нд 800 оноо авсан сурагч, хамгийн өндөр гүйцэтгэлтэй 1 багшийг урамшуулах журмын дагуу нийт 4 багшийг 1.5 сая төгрөг, 2 сурагчийг 400.0 мянган төгрөгөөр урамшуулсан. Хэрэгжилтийн явцын талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, аймгийн ИТХ-д хэлэлцүүлсэн. Аймгийн Засаг даргын зөвлөл болон аймгийн ИТХ-ын	70

							Тэргүүлэгчдээс гаргасан санал, анхаарах асуудлыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, сумдад чиглэл хүргүүлсэн.	
	2	1.1.1.2. Ур чадвар, ажлын амжилтаараа тэргүүлж байгаа багш, удирдах ажилтныг гадаад, дотоодын урт, дунд, богино хугацаанд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах, Боловсролын салбарын удирдах ажилтныг бэлтгэх	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	8	Мэргэжил дээшлүүлсэн багш, удирдах ажилтны тоо өссөн байна. Боловсролын салбарын удирдах ажилтны залгамж халаа бэлтгэгдсэн байна	БСУГ-ын мэргэжилтэн, ЕБС-ийн сургалтын менежер, багш нарын бүрэлдэхүүнтэй 10 хүнийг Өвөр Монголын өөртөө засах орны Хөх хот, Ордос, Бугатад туршлага судлуулсан. Боловсролын салбарын удирдах ажилтан бэлтгэх Удирдлагын академийн сургалтад нийт 21 албан хаагчдыг хамрууллаа. Булган сумын 2-р цэцэрлэгийн эрхлэгчийг Япон, 4-р цэцэрлэгийн арга зүйчийг Солонгос улсад туршлага судлах, сургалтад хамрууллаа. 2017 онд 43 төрлийн сургалтад 2388 багшийг хамруулсан бол 2018 онд 37 төрлийн сургалтад давхардсан тоогоор 3184 багш, ажилтныг хамруулсан. Боловсрол, соёл, урлагийн газраас 535 цагийн хичээлд сууж, 1315 багш, удирдлагуудад зөвлөгөө өгсөн. Мэргэжлийн багшийн сургалтад давхардсан тоогоор 2707 багш хамрагдсан байна.	70
	3	1.1.1.3. Анги удирдсан болон ахмад, залуу багш нарын зөвлөгөөнийг зохион байгуулах, “Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ”-г ХХҮГ-тай хамтран зохион байгуулах	2016 - 2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, Цэцэрлэг	-	“Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ”-г ахмадын зөвлөх үйлчилгээ хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлж, сум бүр “Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ”-ний багтай болсон байна.	1-2 дахь жилдээ ажиллаж байгаа Залуу багш нарын зөвлөгөөнийг 2017 онд зохион байгуулан, нийт 200 гаруй багшийг хамруулж, энэ үеэр 4 ахмад багшийн туршлагыг судлуулсан. 2018 онд “Анги удирдсан багш нарын зөвлөгөөн”-ийг Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр суманд бүсчлэн зохион байгуулж 20 сургуулийн 470 багшийг хамрууллаа. Ахмад багш нарын холбооноос төсөл бичиж, аймгийн ХХҮГ-аас санхүүжүүлж, Хялганат тосгонд сургалт хийснээс гадна урд бүсийн 8 сумын сургууль, цэцэрлэгийн багш нарт зөвлөн туслаж арга зүйн зөвлөгөө өглөө. Тайлбартай дасгалын аргыг сурталчлах, нэвтрүүлэх зорилгоор ахмад багш нарын зөвлөх баг ажиллаж байгаа. Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээг Булган сумын 3 дугаар сургууль, Эрдмийн өргөө цогцолбор сургуулиудад хийж хэвшүүлээд байна.	70
	4	1.1.1.4. СӨБ, ЕБС-иудыг мэргэжлийн багшаар бүрэн хангах, мэргэжлийн ур чадвар сайтай багш нарыг татан ажиллуулах ажлыг зохион	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	-	Боловсролын байгууллага мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан байна.	Булган сумын ерөнхий боловсролын 3-р сургуулийг шинээр ашиглалтад оруулж, мэргэжлийн ур чадвар сайтай багш нарыг нээлттэй сонгон шалгаруулалтаар авлаа. СӨБ-д хөдөө орон нутгаас чадварлаг багш нарыг аймгийн төвд туршлага солилцуулахаар татан ажиллуулж байна. Тухайлбал: Булган сумын 7-р цэцэрлэгт Хутаг-Өндөр	70

		байгуулах, хөрш орнуудад сургаж бэлтгэх					сумын багш Гэрэлчимэг, Булган сумын 2-р цэцэрлэгт Хялганат тосгоны багш Чандалдуламыг ажиллуулж, тэдний туршлагыг түгээн дэлгэрүүлж байна. ОХУ, ӨМӨЗО-д туршлага судлуулахын зэрэгцээ СӨБ-д 4 аймгийн багш солилцоог зохион байгуулж, "Хамтдаа хөгжье" сайн үйл ажиллагааг зохион байгуулсан. ОХУ-ын Буриад улсын багшийн коллежид дуу хөгжмийн багш мэргэжлээр 4 дэх жилдээ оюутан сургаж тус сургуулийг төгссөн 3 хүнийг сургууль болон соёлын төвүүдэд ажиллуулж байна. Сайхан, Орхон, Гурванбулаг, Хишиг-Өндөр сумд, Хялганат тосгоны сургуулиудад дутагдалтай байсан хими, биологийн мэргэжлийн багш нартай болгосон. 1, 2-р сургуулиудад химийн багш нэн шаардлагатай байгаа бөгөөд улсын хэмжээнд хими, биологийн мэргэжлийн багшийн дутагдалтай байна. Булган сумын "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн Орос хэлний багшийг Эрхүү хотод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрууллаа.	
	5	1.1.1.5. Сургууль, багш, БСУГ харилцан зөвшилцсөний үндсэн дээр сургуулийн удирдлага, багш нарыг солилцох, сэлгэн ажиллуулах, хөрш болон бусад орнуудын сургуулиудтай багш солилцох ажлыг зохион байгуулах	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	-	Шинэ арга барил, менежментээр шинэчлэн удирдах нөхцөл бүрдүүлнэ.	2018 оны 1, 2 дугаар улиралд "Хамтдаа хөгжье" арга хэмжээний хүрээнд Орхон, Дархан-Уул аймгуудад нийт 65 багш солилцоо хийсэн. Булган сумын сургуулиудын дүрслэх урлаг, дизайн технологийн багш нарыг урд бүсийн сургуулиудад туршлага судлуулж хамтарсан болон үзүүлэх хичээл заалгалаа. Байгалийн ухааны чиглэлээр Орхон аймгийн БСУГ-тай хамтран химийн 2, биологийн 2 багшийг багш солилцоонд хамруулахаар төлөвлөн 2018-2019 оны хичээлийн жилийн 3 дугаар улиралд зохион байгуулан ажиллахаар ажлын төлөвлөгөө, удирдамжийг хамтран боловсруулан ажиллаж байна. Хялганат тосгоны сургууль Улаанбаатар хотын 2 дугаар сургуультай хамтран харилцан туршлага судалсан.	70
12/ 1.1.2. Бүх шатны боловсролын сургалтын чанар, үр дүн, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	6	1.1.2.1. Сурагчдын сурлагын чанар, үр дүн, сэтгэн бодох чадвар, оюуны спортыг дэмжих зорилгоор "Оюунлаг Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	43.1	Дунд, ахлах ангийн сурагчдын сургалтын чанар нэмэгдсэн байна.	"Оюунлаг Булган" дэд хөтөлбөрийн хүрээнд Мэтгэлцээн, Ном, Шатар, Ой тогтоолт гэсэн 4 чиглэлээр хөгжүүлэх 2018 оны төлөвлөгөөг батлуулж шаардагдах хөрөнгийг шийдүүллээ. Мэтгэлцээн, Ном, Оюуны спортоор бүх сургуулиуд клуб байгуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд Мэтгэлцээн хөтөлбөрт 20 сургуулийн 292 сурагчид, Ой тогтоолтын клубт 4166 сурагчид хамрагдаж	70

						байна. Шатар дэд хэсгийн хүрээнд 1370 хүүхэд шинээр шатар тоглож сурсан ба Хялганат тосгоны сургуулийн бүх сурагчид шатрын спортоор хичээллэж байна. Мөн шатрын сургалт явуулдаг албан ёсны хөтөлбөртэй 2 цэцэрлэгт 130 хүүхэд хамрагдаж байна. Сургууль бүрт номын фонд баяжилтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, ном унших арга зүй, аргачлалаар зөвлөмж гарын авлага бэлтгэн сургалт, сурталчилгаа хийх, уншсан номынхаа талаар харилцан ярилцах, номын хямдралтай худалдаа, ном сонирхогч залуусын дунд номын клуб байгуулж “Номоор нөхөрлөө” эвент зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна. Ерөнхий боловсролын бүх сургуулиар "Оюунлаг Булган" хөтөлбөрийн 2 дахь шатны сургалт болон хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийлээ. Хөтөлбөр хэрэгжсэнээс хойш 43.125 сая төгрөг зарцууллаа. "Оюунлаг Булган" дэд хөтөлбөрийн хүрээнд "Ой тогтоолтын аварга-2018" аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд 17 сургуулийн 150 гаруй сурагч ахлах, дунд анги гэсэн 2 ангиллаар оролцон, 60 багц медалийн төлөө өрсөлдсөн.	
7	1.1.2.2. Сургууль, цэцэрлэг бүрт хүүхдийн хөгжлийн танхим ажиллуулах, хүүхэд багачуудын авьяас чадвар, бие бялдар, урлаг гоо зүйн мэдрэмж, техник сэтгэлгээг нээн хөгжүүлэх хичээлээс гадуурх сургалт, дугуйлан, секцийн үйл ажиллагааг чанартай зохион байгуулах	2016 - 2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	-	Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн 80-аас доошгүй хувь нь дугуйлан, секцийн үйл ажиллагаанд хамрагдсан байна.	Сурагчдын хэрэгцээ сонирхолд тулгуурлан цаасан урлал, шатар, мэтгэлцээн, хайчилбар, уран зураг, англи хэл, сэтгэх чадвар, гандбол, сагс, самбо, жүдо, уран өд, хайчилбар, бийрэн бичиг зэрэг 312 дугуйлан 20 сургуульд хичээллэж давхардсан тоогоор 6184 сурагчдыг хамруулж байна.	70
8	1.1.2.3. Улсын “Математикийн олимпиад”-ыг зохион байгуулах	2017	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	-	Олимпиадын бэлтгэл ажлыг хангаж, чанартай зохион	2017 онд “Монголын Математикийн 53 дугаар олимпиад”-ыг Булган аймгийн Бугат сумын уугуул МУ-ын гавьяат багш Д.Шагдарын нэрэмжит болгон амжилттай зохион байгуулж тус олимпиадад нийт 21 аймаг, 9 дүүргийн 42 баг, 162 сурагч, 66 багш, нийт	100

						байгуулах, Математик сургалтын чанар нэмэгдэж, мэргэжлийн багш нарын заах арга, ур чадвар сайжирсан байна.	228 оролцогч оролцож Булган аймаг багийн дүнгээр 12-р байранд шалгарсан.	
	9	1.1.2.4. Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг, сургалтын төв байгуулах үүсгэл санаачилгыг дэмжих	2016 - 2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	-	Иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагын оролцоо дээшилсэн хамтын ажиллагааны түвшин ахисан байна.	Булган аймгийн төр нийгмийн зүтгэлтэн, Монгол хэлний багш Ц.Бадралын нэрэмжит 8-р ангийн Монгол хэлний анги нийтийн олимпиад, Химийн багш АБТА Ё.Дарьсүрэнгийн нэрэмжит олимпиад, Бадамсэд багшийн нэрэмжит Математикийн олимпиадуудыг тус тус зохион байгуулан, сурагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд хувь хүний оролцоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ, "Булган нэг үе клуб" ТББ, Булган аймгийн "Илтгэгч мэтгэлцэгчид"- ийн холбоотой хамтран математик, байгалийн ухааны багш нарт сургалт зохион байгуулж, мэтгэлцээний сургагч багш нарыг бэлтгэлээ. Мөн Булган сумын Засаг дарга Д.Наранбаярын нэрэмжит 9-р ангийн Монгол хэлний олимпиад, гавьяат багш Ц.Гомбожав, Ш.Энхтуяа нарын нэрэмжит 3-р ангийн унших, 5-р ангийн математикийн масс олимпиадуудыг тус тус зохион байгууллаа. "Нээлттэй тархи" ТББ-тай хамтран "Оюунлаг Булган" дэд хөтөлбөрийн "Ой тогтоолт" дэд хэсгийг, "Илтгэгч, мэтгэлцэгчдын холбоо"-той хамтран "Мэтгэлцээн" дэд хэсгийг, "Шатрын холбоо"-той хамтран "Шатар" дэд хэсгийг, Номын дэлгүүрүүдтэй хамтран "Ном" дэд хэсгийг тус тус хэрэгжүүлж байна.	70
	10	1.1.2.5. Аймгийн тэргүүлэх чиглэлийн судлагдахууныг тодорхойлж, орон нутгийн онцлогийг тусгасан чиглэлийг хэрэгжүүлэх	2016 - 2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	-	Математик, Гадаад хэл, Монгол хэл, Байгалийн ухааны хичээл тус бүрээр чиглэл боловсруулж	Математик, байгалийн ухаан, гадаад хэлийг тэргүүлэх чиглэл болгон жил бүр тухайн судлагдахууны нэрэмжит болгон үйл ажиллагааг чиглүүлж байна. 2017 онд Математикийн улсын 53- р олимпиадыг зохион байгуулсан. Энэ жил Гадаад хэлийг хөгжүүлэх жил болгон багш нарыг хөгжүүлэхэд анхаарч байна. 2020 онд Физикийн улсын 33 дугаар олимпиадыг аймагтаа зохион	40

						хэрэгжүүлсэн байна.	байгуулахаар санал хүргүүлээд байна.	
	11	1.1.2.6. Орон нутгийн онцлогийг тусгасан сурах бичиг бэлтгэх, сургалтанд нэвтрүүлэх	2016 - 2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	-	Сурах бичиг хэвлэгдэж, сургалтанд нэвтэрсэн байна.	Аймаг, орон нутгийнхаа талаар сурагчдад мэдлэг олгох зорилгоор 3, 4, 5-р ангийн сурах бичгийн эх бэлтгэлийг дуусгаж хэвлэлтэд өгөхөд бэлэн боллоо.	70
/3/ 1.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийг бүх шатны боловсролд хамруулах, насан туршийн боловсролын бүтэц, үйл ажиллагааг шинэчилж, иргэдийн хэрэгцээнд нийцсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна.	12	1.1.3.1. Сургууль, цэцэрлэгт хамрагдаагүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, бүх шатны боловсролд хамруулах талаар дэмжлэг үзүүлэх	2016 - 2020	АЗДТГ, НБХ, БТСГ, БСУГ	-	Судалгаанд байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд бүрэн хамруулсан байна.	Сумдын эрүүл мэндийн төвөөс авсан хөгжлийн бэрхшээлтэй хүний судалгаанд нийт цэцэрлэг, сургуулийн насны 249 хүүхэд бүртгэгдсэнээс Сургуулийн өмнөх боловсролд-12, Ерөнхий боловсролын сургуульд-28, Мэргэжил, сургалт үйлдвэрлийн төвд-1, Насан туршийн боловсролд-5 суралцаж байна. Ар гэрийн саналаар 4 хүртэлх насны 4 хүүхэд гэртээ хүмүүжиж байгаа, бусад 199 хүүхэд нь эрүүл мэндийн шалтгаанаар суралцах боломжгүй байна. Энэ онд СӨБ-д-5, ЕБС-д-9, насан туршийн боловсролд-3 хүүхдийг нэмж хамруулсан.	70
	13	1.1.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг бэлтгэх	2016 - 2020	АЗДТГ, НБХ, БТСГ, БСУГ	-	Сум тус бүрээс Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг бэлтгэнэ.	Төрийн албан хаагчдад сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй харилцахдаа дохионы хэлийг ашиглан тэдэнтэй ойлголцоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор "Дохионы хэлний анхан шат"-ны сургалтыг зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сарын аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарт сургалт, мэдээлэл өгч байгаа болно.	40
	14	1.1.3.3. Насан туршийн боловсролын төвийг байгуулж, үйл ажиллагааг өргөтгөх, иргэдийн хэрэгцээнд нийцсэн сургалт зохион байгуулах	2016 - 2020	АЗДТГ, НБХ, БТСГ, Спортын холбоод	-	Насан туршийн боловсролын төвийг байгуулж, сум бүр салбар төвтэй болсон байна.	Насан туршийн боловсролын төвийг 2017 оны 6 дугаар сарын 1-нээс 3 хүний орон тоотойгоор байгуулан шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган БСУГ-ын дэргэд үйл ажиллагааг нь эхлүүллээ. Аймгийн хэмжээнд дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол олгож байгаа байдал, насан туршийн боловсрол олгох сургагч багш нар бэлтгэх сургалтуудыг хийж байна. 2018 оны байдлаар 93 төрлийн сургалтад давхардсан тоогоор 2056 иргэн хамрагдсан.	100
/4/ 1.1.4. Сургууль, цэцэрлэгийн сургалтын орчныг тохижуулах, хүүхдэд ээлтэй сурах орчин бүрдүүлж, “Цахим сургууль-Цахим	15	1.1.4.1. Хүүхдийн бие бялдар, оюун ухааныг хөгжүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	1368.2	Сургууль, цэцэрлэгийн 70,0-аас доошгүй хувь нь сургалтын хэрэглэгдэхүүн	2017 онд боловсрол, соёлын байгууллагуудын төсөвт 223.4 сая төгрөгийн зохицуулалт хийж болон төсвийн тодотголоор 741.0 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдсэнээр салбарын байгууллагуудын тулгамдсан асуудлыг шийдвэрлэлээ. Энэ хөрөнгөөр сургууль, цэцэрлэгүүд сургалтын хэрэглэгдэхүүн,	70

сургалт” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.		сургууль, цэцэрлэгүүдийг үе шаттайгаар хангах				, тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	тоглоом наадгай, тоног төхөөрөмж авч тулгамдсан асуудлаа шийдвэрлэж байна. Оюунлаг Булган хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын 19 сургуульд хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх гарын авлага, дүрстэй самбар, түргэн өрөлтийн аяга, мэдээллийн самбар, ном зэргийг нийлүүлж сургалтанд ашиглаж байна. Сайхан сумын сургууль, цэцэрлэг, Хутаг-Өндөр сумын Хантай, Уньт багийн бага сургуульд 1650.0 мянган төгрөгөөр сургалтын хэрэглэгдэхүүн авч өглөө. Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт 17 сургууль хамрагдаж 87.4, “STEM” хөтөлбөрт 21 сургууль хамрагдаж 106.7 сая төгрөгийн 432 багц хэрэглэгдэхүүн авсан. Мөн БСШУС-ын яамны хөрөнгө оруулалтаар 208.1 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэгдлээ.	
	16	1.1.4.2. Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрыг халуун устай болгож амьдрах орчин нөхцлийг сайжруулах	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль	424.1	Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг ээлж дараагаар шийдвэрлэсэн байна.	Орон нутгийн төсвөөс 28.0 сая төгрөг, “Өвсний үндэс” хөтөлбөрөөс 161.1 сая төгрөгийг гарган Тэшиг сумын сургуулийн дотуур байрны их засвар, ариун цэврийн байгууламжийг шийдвэрлэсэн. Хутаг-Өндөр сумын сургууль дотуур байрандаа 140.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар боловсон ОО, халуун усны асуудлыг шийдэж сурагчдын амьдрах таатай орчныг бүрдүүлсэн. Хишиг-Өндөр сумын сургууль дотуур байрандаа өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан халуун устай болсноос гадна Булган сумын “Эрдмийн өргөө” цогцолбор сургуулийн ариун цэврийн байгууламжийн асуудлыг “Булган Мээж” ОНӨХХК-тай хамтран шийдвэрлэж байна. Рашаант, Хишиг-Өндөр сумын сургуулиудыг аймгийн төсөв, Дэлхийн зөн, Мобиком корпорацитай хамтран хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж ариун цэврийн байгууламжтай болголоо. Сайхан сумын цэцэрлэгт 15.0 сая төгрөгийн эх үүсвэр шийдэж цэвэр бохир усны системтэй болголоо. 2019 онд Хишиг-Өндөр, Сэлэнгэ сумдын цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг шийдвэрлэхээр орон нутгийн төсөвт 160.0 сая төгрөг тусгасан.	70
	17	1.1.4.3. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хэрэглэгдэхүүн, багш	2016 - 2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	-	Сургууль тус бүр багш сурагчдын бүтээл, шилдэг	Дизайн технологи, дүрслэх урлагийн багш нарт зориулан Улсын Техник технологийн олимпиадын 2002 оноос хойших тестийн эмхэтгэлийн эхийг бэлтгэж, хэвлэлтэд өгөөд байна. Мөн "Тэргүүлэх"	70

		сурагчдын бүтээл, шилдэг тэргүүний арга, туршлагыг багтаасан нэгдсэн цахим сан бий болгох				тэргүүний арга, туршлагыг багтаасан нэгдсэн цахим сантай болсон байна.	зэрэгтэй 92 багшийн шилдэг арга зүйн цахим санг бүрдүүлэх зорилгоор CD-д буулган, цахим санд оруулахад бэлтгэсэн. Бага боловсролын багш нарын тэргүүн туршлага 122 хичээлийг CD-д хуулж авч “Булган аймгийн Боловсрол, соёл урлагийн газар” гэсэн фэйж хуудсанд байршуулж байна. Аймгийн бүх сургуулиудад “Ухаалаг самбар” олголоо. Анги удирдсан багш нарт холбогдох эрх зүйн акт, тэргүүн туршлага зэргийг эмхэтгэн гарын авлага хийж 500 хувийг хэвлэн өгсөн. Боловсрол, соёл урлагийн газарт ахмад болон залуу багш, сурагчдын бүтээл, шилдэг тэргүүний арга, туршлагыг багтаасан нэгдсэн цахим санг үүсгэн, ашиглаж байна. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд зориулсан онлайн зөвлөмжийн цахим хуудсыг нээн ажиллуулж байна.	
	18	1.1.4.4. Бүх сургууль, цэцэрлэгийг өндөр хурдны интернэтэд холбох, сургуулийн дотуур байруудыг камержуулах, багш нарыг цахим сургалтын арга зүйд сургах	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	16	Сургууль, цэцэрлэгийг өндөр хурдны интернэтэд бүрэн холбосон байна.	Аймгийн хэмжээнд бүх дотуур байруудыг камержуулсан. Мөн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 22 сургууль, 22 цэцэрлэгийг интернэтэд холбосон бөгөөд цахим статистикийн үйл ажиллагаа жигдрээд байна. Багш нарыг цахим сургалтад хамруулж хүүхдийн хүмүүжлийн талаар эцэг эхийн хяналтын системд мэдээлэл оруулах чадавхийг олголоо. Сургуулиудын багш нарт Боловсролын чанарын шинэчлэл төслөөс 16.0 сая төгрөгний санхүүжилтээр сургалт хийлээ.	100
/5/ 1.1.5. Боловсролын салбарын байгууллагуудын барилгын өргөтгөл барих, их засвар хийх, хатуу, зөөлөн эдлэлээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	19	1.1.5.1. Боловсролын салбарын дуусаагүй барилгуудыг ашиглалтад оруулах	2016 - 2020	БСУГ, СЗДТГ, цэцэрлэг	-	Дуусаагүй барилгууд ашиглалтанд орсон байна.	2017 онд Булган сумын 150 хүүхдийн цэцэрлэг, 2018 онд 1280 суудалтай сургуулийн 2 шинэ барилгын ажлыг дуусгаж ашиглалтад хүлээн авлаа. Тэшиг сумын сургуулийн өргөтгөлд 200.0 сая төгрөг тусгуулсан ч өмнөх төсвөөр баригдах боломжгүй учраас дахин дүгнэлт гаргах БСШУСЯ, Барилгын хөгжлийн төвийн хамтарсан ажлын хэсэг байгуулагдан дахин 600.0 сая төгрөг шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.	100
	20	1.1.5.2. Бүрэгхангай, Гурванбулаг, Сэлэнгэ, Тэшиг сумдын болон Булган сумын 3-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	12	Цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн зураг төсөв хийгдэж, барилга ашиглалтанд	Бүрэгхангай, Тэшиг сумдын цэцэрлэгийн өргөтгөлийн зураг төсвийг шинээр хийлгэн Сэлэнгэ сумын цэцэрлэгийн өргөтгөлийн зураг төсвийг шинэчилсэн. 2019 оны улсын төсөвт шинээр Бүрэгхангай сумын цэцэрлэгийн өргөтгөл 572.7 сая төгрөгийн хөрөнгийн асуудал шийдвэрлэгдсэн. Тэшиг, Сэлэнгэ сумдын цэцэрлэгийн өргөтгөлийн	70

						орсон байна.	ажлыг эхлүүлэхээр 2019 оны орон нутгийн төсөвт 653 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг тусгаад байна.	
	21	1.1.5.3. Бугат сумын сургуулийн барилгыг шинээр барих	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	980	Сургуулийн барилгын зураг төсөв хийгдэж, барилга ээлж дараалалтайгаар ашиглалтад орсон байна.	2018 оны улсын төсөвт 980.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тусгагдан гүйцэтгэгч шалгарч барилгын ажил эхлээд байна. 2019 оны улсын төсөвт 1.1 тэрбум төгрөг тусгагдсан.	70
	22	1.1.5.4. Дашинчилэн, Рашаант сумдын сургуулийн дотуур байрыг шинээр барих, Хялганат тосгоны сургуулийн дотуур байранд өргөтгөл хийх	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль	2200	Сургуулийн дотуур байрны барилгын зураг төсөв хийгдэж, барилга ээлж дараалалтайгаар ашиглалтанд орсон байна.	Дашинчилэн, Рашаант сум, Хялганат тосгоны сургуулийн дотуур байрны өргөтгөлийн зураг төсөв бүгд хийгдсэн. 2019 оны улсын төсөвт Рашаант сумын сургуулийн 150 ортой дотуур байр шинээр барих хөрөнгийн эх үүсвэр шийдэгдэж нийт 2.2 тэрбум төгрөг батлагдсан.	70
	23	1.1.5.5. Сайхан, Сэлэнгэ, Баян-Агт, Гурванбулаг, Дашинчилэн, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Орхон сумын сургуулийн барилгад их засвар хийх	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль	304	Сургуулийн засварын ажлыг хийж, ашиглалтад орсон байна.	Дашинчилэн сумын сургуулийн их засварын ажлыг 104.3 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэн хүлээн авсан. Сэлэнгэ, Орхон сумын сургууль төсвийн хөрөнгө оруулалт болон төгсөгчдийн дэмжлэгээр их засвар хийсэн. Баяннуур, Хишиг-Өндөр, Булган сумын ЭӨЦС-иудын спорт зааланд 200 сая төгрөгөөр засвар хийснээс гадна Бүрэгхангай, Баян-Агт сумын сургуулийн спорт заалны шалыг бүрэн шинэчлэсэн. Хутаг-Өндөр сумын сургуулийн 240 суудалтай өргөтгөл, Хишиг-Өндөр сумын сургуулийн их засварын зураг төсвүүдийг шинээр хийлгэж, 2019 оны улсын төсөвт Хутаг-Өндөр сумын сургуулийн 240 суудалтай өргөтгөлийн барилгын хөрөнгийн эх үүсвэр шийдэгдэн 1.5 тэрбум төгрөг батлагдаад байна.	70
	24	1.1.5.6. Бугат, Рашаант сумдын болон Булган сумын 1-р багийн цэцэрлэгийн сүрлэн барилга, 4, 6-р цэцэрлэгийн барилгад	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	76	Цэцэрлэгийн барилгын засварын ажлыг хийж, ашиглалтад орсон байна.	Рашаант сумын цэцэрлэг 2018 оны эхний хагас жилд төсвийн зохицуулалтаар засвар хийж, 2019 онд их засвар хийхээр зураг төсвийг хийлгэж байна. Булган сумын 6-р цэцэрлэгт 2017 онд ТИКА байгууллагын хөрөнгөөр 84.6 сая төгрөгөөр их засвар хийлээ. Булган сумын 1-р багт 100 ортой цэцэрлэг, 5-р багт	100

		их засвар хийх					75 ортой цэцэрлэгүүдийг барихаар холбогдох хөрөнгийн асуудлыг шийдвэрлээд байна.	
	25	1.1.5.7. Гурванбулаг, Сайхан, Бүрэгхангай сумдын сургуулийн дотуур байранд их засвар хийх	2016 - 2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	120	Сургуулийн дотуур байранд их засвар хийж, ашиглалтанд орсон байна.	2017 онд Сайхан сумын дотуур байрны гал тогооны барилгын их засвар, барилга угсралтын ажлыг орон нутгийн төсвийн 551.0 сая төгрөгөөр гүйцэтгэн хүлээлгэж өгсөн. 2018 онд Гурванбулаг сумын дотуур байранд орон нутгийн төсвийн 124.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар их засвар хийгдсэн. Бүрэгхангай сумын сургуулийн дотуур байрны өргөтгөлийн зураг төсвийг шинээр хийлгэж хөрөнгийн эх үүсвэрийг шийдүүлэхээр ажиллаж байна.	70
	26	1.1.5.8. Тэшиг сумын сургуульд спорт заал шинээр барих, Хангал, Баяннуур сумын сургуулийн спорт заалыг засварлах	2016 - 2020		-	Сургуулийн спорт заал ашиглалтанд орсон байна.	Хангал, Баяннуур сумын сургуулийн спорт заалны засварыг 2017 онд төсвийн зохицуулалт, тодотголоор хөрөнгийг шийдэж засварлах ажил хийгдэж дууссан. 2018 онд Тэшиг сумын сургуулийн спорт заалны зураг төсвийг шинээр хийлгэж байна. Баяннуур, Хишиг-Өндөр сумын болон Булган сумын ЭӨЦ сургуулийн спорт зааланд 200.0 сая төгрөгөөр засвар хийснээс гадна Баян-Агт, Бүрэгхангай сумдын сургуулийн спорт заалны шалыг шинэчилж зориулалтын хуудаасаар бүрлээ.	70
	27	1.1.5.9. Сурагчдын дотуур байр, цэцэрлэгийн бүлгүүдийн хатуу, зөөлөн эдлэлийг ээлж дараалан шинэчлэх	2016 - 2020		-	Хатуу зөөлөн эдлэлийн 80 хувийг шинэчлэнсэн байна.	Сургуулийн дотуур байр, цэцэрлэгүүдийн зөөлөн эдлэлийн нэг ээлжийг шинэчилсэн. Дашинчилэн, Рашаант, Сайхан сумдын сургуулийн дотуур байрны хатуу эдлэлийг шинэчиллээ. Хуваарийн зохицуулалт хийж ихэнх сургууль, цэцэрлэгүүд зөөлөн эдлэлээ шинэчилсэн.	100

1.2.Эрүүл мэнд:

Эрүүл мэндийн салбарын удирдлага, менежментийг сайжруулан, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг нотолгоонд суурилсан, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэчилж, материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлэн, эрүүл амьдралын дадал хэвшлийг бий болгож, иргэдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлнэ.

16/ 1.2.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тандан судалж, хяналтын тогтолцоог сайжруулан эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, урьдчилан	28	1.2.1.1. Эрүүл мэндийн боловсрол-Настны эрүүл мэнд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх	2016 - 2020	ЭМГ	10.5 /орон нутгийн төсөв/	Иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг суурь түвшингээс 10 хувиар нэмэгдүүлнэ	Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэн, эрүүл мэндийн боловсрол олгох 154 удаагийн сургалт, сурталчилгааг хөдөлгөөнт болон суурин хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 17261 иргэнийг хамруулсан. Булган, Сэлэнгэ, Могод, Хутаг-Өндөр, Тэшиг сумын Эрүүл мэндийн төв, аймгийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог зохион байгуулж, 1456	100
--	----	---	-------------------	-----	---------------------------	---	--	-----

сэргийлэх ажиллагааг хэлбэрээр байгуулан, эрүүл боловсролын дээшлүүлнэ.	үйл шинэлэг зохион иргэдийн мэндийн түвшинг						иргэдийг хамруулсан. Үзлэг оношилгоогоор хавдрын сэжигтэй 2 тохиолдлыг илрүүлсэн ба ахмад настны сэтгэн бодох, бие даах чадварын үнэлгээг хийж, хүнд хэвтрийн 18 ахмад настанд гэрийн эргэлт хийж, эмчийн зөвлөгөөг өгсөн. Урьдчилан сэргийлэх үзлэгээр 3 нэр төрлийн 1000 ширхэг гарын авлага тараасан. Өнгөрсөн хугацаанд эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны 10 нэр төрлийн 9430 ширхэг санамж, 496 ширхэг зурагт хуудас, 113 ширхэг сонины нийтлэл иргэдэд түгээсэн. 2018 онд 15-61 насны 3600 иргэд, 465 төрийн албан хаагчдаас эрүүл мэндийн боловсролын түвшин тогтоох судалгааг 2 удаа авч дүгнэлт хийсэн. Судалгааны үр дүнгээр иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийн түвшин 2016 оноос 5.4, 2017 оноос 3.9%-иар өссөн байна.	
	29	1.2.1.2. Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг нэмэгдүүлж, багийн Засаг дарга, багийн эмч нарын уялдаа холбоог сайжруулах	2016 - 2020	ЭМГ, ЭМБ-ууд	17.7	Эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын түвшинг 2016 оныхоос 15 хувиар нэмэгдүүлнэ.	Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай байгуулсан “Үр дүнгийн гэрээ”, сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, Эрүүл мэндийн газрын дарга нарын “Хамтран ажиллах гурвалсан гэрээ”-нд халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн хувийг нэмэгдүүлэх, зорилтот насны иргэдийг бүрэн хамруулах талаар заалт тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2018 оны 11 дүгээр сарын байдлаар 166641 иргэн амбулаторид үйлчлүүлснээс урьдчилан сэргийлэх үзлэгт 52735 иргэн хамрагдсан нь нийт үзлэгийн 30.8%-ийг эзэлж байна. Халдварт бус өвчлөл 40854 бүртгэгдсэн нь нийт үзлэгийн 25.0%-ийг эзэлж байна. Артерийн гипертензийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдвал зохих 16229 иргэний 11878 буюу 73.2%-ийг хамруулж, шинээр 93 тохиолдол оношлогдсон. Чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 16063 иргэнээс 11695 буюу 72.8% нь хамрагдаж, шинээр 8 тохиолдол оношлогдсон. Умайн хүзүүний өмөнгийн үзлэгт хамрагдвал зохих 4208 иргэнээс 2300 буюу 55% нь хамрагдаж, папын шинжилгээгээр эерэг гарсан 4, Хөхний өмөнгийн үзлэгт хамрагдвал зохих 12124 иргэнээс 9371 буюу 77.0%-ийг хамруулсан. “Хавдаргүй Булган” аяны ходоодны хавдрыг эрт илрүүлгийн үзлэгт 25-аас дээш насны 8904 иргэн хамруулснаас 3584 буюу 40.0% нь хеликобактертэй	70

						гарсныг тухайн Эрүүл мэндийн байгууллагын эмчийн хяналтад авч эмчлэн эрүүлжүүлэх ажлыг эхлээд байна. Эрт илрүүлгийн үзлэгийн хамралтын хувь 2016 оны мөн үетэй харьцуулахад 3%-иар нэмэгдсэн байна.	
30	1.2.1.3. “Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үндэсний стратеги”-ийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлж, анхан шатны ЭМБ-уудыг үзлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангах	2016 - 2018	ЭМГ, ЭМБ-ууд		Насанд хүрэгчдийн 20 хувийг эрт илрүүлэг үзлэгт хамруулна.	МУЗГ-ын 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн 2 дахь шатны үзлэг шинжилгээг зохион байгуулж, 11 дүгээр сарын байдлаар В, С вирусын шинжилгээнд хамрагдах иргэдийн 10441 буюу 42%-ийг хамруулсан. Үзлэгт хамрагдсан иргэдээс В вирус эерэг 667, С вирус эерэг 493 иргэдийн ийлдсийг дараагийн шатлал болох вирусын ачаалал тоолуулах шинжилгээнд илгээсэн. Вирусын ачаалал тоолуулах шинжилгээгээр С вирус идэвхжилтэй 228, идэвхжилгүй 265, В вирус идэвхжилтэй 82, идэвхжилгүй 585 иргэн байна. С вирус идэвхжилтэй 157 иргэнийг С вирусын эмийн эмчилгээнд, В вирус идэвхжилтэй 82 иргэнийг эмийн эмчилгээнд хамруулаад байна.	100
31	1.2.1.4. “Амны хөндийн эрүүл мэнд” аян зохион байгуулах	2016 - 2020	ЭМГ, ЭМБ-ууд		Амны хөндийн өвчлөлийг 2016 оны түвшингөөс 5 хувиар бууруулна.	“Амны хөндийн эрүүл мэнд”-ийн аянг ТББ-тай хамтран зохион байгуулах гэрээ байгуулан “Бадрал сан”, “Цэгц дент” шүдний эмнэлэгтэй хамтран аймгийн хэмжээнд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог 16 суманд зохион байгуулсан. Үзлэгт 7252 иргэнийг хамруулснаас, шүд цооролтын эмчилгээг 1541, ломбо 3251, чулуу түүх, өнгөлгөө эмчилгээг 163, Saforide болон фторт гелэн түрхлэг 2095, шүд авах эмчилгээг 2071, сувгийн эмчилгээ 1426, зүслэг 6, эрүү нүүрний гажиг заслын зөвлөгөөг 32, бусад эмчилгээ зөвлөгөөг 1060 иргэнд өгсөн. Нийт үзлэгт хамрагдсан иргэдийн дунд шүдний цоорлын тархалт 84.2 хувьтай байна. Цэцэрлэгийн багш нар болон эцэг эхчүүдэд “Хүүхдийн шүдийг хэрхэн хамгаалах вэ” сэдвээр сургалт зохион байгуулж, 3 нэр төрлийн 1700 гаруй гарын авлагаар хангалаа. Мөн Булган суманд хөгжлийн бэрхшээлтэй болон бага насны 171 хүүхдийг амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.	100
32	1.2.1.5. Нийгмийн эрүүл мэндийн олон	2017 -	АЗДТГ, ЭМГ		Эрүүл мэндийг дэмжигч сум,	Нийгмийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулж	100

		талт арга хэмжээг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, “Эрүүл мэндийг дэмжигч” төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах	2020			баг, байгууллага, өрх гэр бүлийн тоог 2016 оны түвшингээс 2 дахин нэмэгдүүлнэ. Эрүүл мэндийг дэмжигч байгууллагуудын холбоо"-ны үйл ажиллагаа тогтмолжино.	хэвшүүлснээр 2018 оны байдлаар аймгийн хэмжээнд улс, аймгийн эрүүл мэндийг дэмжигч байгууллага 24 ажиллаж байна. Улсын өргөмжлөлтэй “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” 3, Орон нутгийн эрүүл мэндийг дэмжигч байгууллага 178, Эрүүл мэндийг дэмжигч өрх 469, Эрүүл мэндийг дэмжигч иргэн 2050 байна. Эрүүл мэндийг дэмжигч чиглэлийн сургалтыг 22 удаа зохион байгуулсан.	
	33	1.2.1.6. “Эх хүүхдийн эрүүл мэнд” стратегийг хэрэгжүүлэх	2016 - 2020	ЭМГ, ЭМБ-ууд		Стратеги 90 хувиас дээш хэрэгжсэн байна. 1000 амьд төрөлтөд ноогдох нялхасын эндэгдлийн тохиолдлыг 2016 оны мөн үеэс 4 промилээр, амьгүй төрөлтийн тохиолдлыг 25 хувь, гэрийн төрөлтийн тохиолдлын тоог 50 хувь бууруулна.	Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар 729 эх төрж, 737 хүүхэд амьд мэндэлж, 2500 граммаас доош жинтэй 23 тохиолдол бүртгэгдсэн байна. Амьгүй төрөлт 4 тохиолдол бүртгэгдсэн нь 2016 оны мөн үетэй харьцуулахад /6/ 33.3 хувиар буурч зорилтот түвшинд хүрсэн. Гэрийн төрөлт /2/ өнгөрсөн оноос 50 хувиар буурч, 2016 оноос /1/ өссөн. Перинаталь эндэгдлийн 12 тохиолдол бүртгэгдсэн байна. Жирэмсний эрт үеийн хяналт 87.3 буюу 0.1 хувиар өссөн. Дээд шатлалд 7 эхийг шилжүүлж, оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэсэн. Эхийн амрах байраар 225 эх үйлчлүүлсэн байна. Эмч нарын зөвлөгөөнийг 24 удаа зохион байгуулж, жирэмслэлт, төрөлтийн асуудлыг шийдвэрлэсэн. 2018 онд “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн 5 зорилтын хүрээнд 22 ажил төлөвлөж, хэрэгжилт 90 хувьтай байна.	40
171 1.2.2. Халдварт өвчний тандалт сэргийлэлт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг сайжруулна	34	1.2.2.1. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийг шат дараатай зохион байгуулж, өвчлөлийн түвшинг бууруулах	2016 - 2020	ЭМГ, АНЭ		Эрт илрүүлгийн үзлэгийн хамралтыг 85%-д хүргэнэ. Эдгэрэлтийн түвшинг 2016 оныхоос 3%-иар	Сүрьеэ өвчний 36 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор буурч, 10000 хүн амд 5.8 промилл байна. Шинэ тохиолдлын ойрын хавьтал 92 хүнийг эрт илрүүлэх үзлэгт, 114 сурагчийг туберкулины сорилд хамруулахад өвчний сэжигтэй тохиолдол илрээгүй. 2018 оны 11 дүгээр сарын байдлаар 36 өвчтөн хяналтад эмчлэгдэж байгаагаас 24 нь уушигны, 12 нь уушгины бус сүрьеэ ба эдгэрэлт 85.4 хувь байна. Урьдчилан сэргийлэх	70

						нэмэгдүүлнэ.	үзлэгт нийт 1690 хүн хамрагдсанаас 2 хүн сүрьеэгээр оношлогдож хяналтад орсон. Өрхийн ЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, Булган сумын ЗДТГ, багийн ЗД нарын сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх мэдлэг чадварыг нэмэгдүүлэх сургалтыг ХӨСҮТ, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулж 65 хүнийг хамрууллаа.	
	35	1.2.2.2. Бэлгийн замаар дамжих халдвар, нэн тэмбүү бууруулахад судлалын ажлыг эрчимжүүлэх	2017 - 2020	ЭМГ		Нөхөн үржихүйн насны иргэдийн хамрагдалтыг 20%-д хүргэнэ.	2018 оны 11 дүгээр сарын байдлаар 136 БЗДХ өвчин бүртгэгдсэнээс 25 тэмбүүгийн тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5.0 промилиор буурсан. 15-49 насны 3166 иргэнийг ДОХ/БЗДХ-ын урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан. Тэмбүүгийн 10 хавьтлыг эмчлэн эрүүлжүүлсэн. Тэмбүү өвчний хавьтал илрүүлэлт 40.0% байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сайн дурын зөвлөгөө, шинжилгээний кабинетийг иргэдэд утсаар зөвлөгөөг өгөх боломжоор хангах санхүүжилтийг шийдвэрлэсэн. НҮБ-ийн Хүн Амын Сан, ЭМЯ-ны дэмжлэгтэйгээр “Миний дотны зөвлөгч” төслийг ЭМГ, АНЭ хамтран хэрэгжүүлж эхлээд байна. Төслийн хүрээнд 2018 оны 10 дугаар сард МГБССНийгэмлэгийн үндэсний сургагч багш нартай хамтран Нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн боловсрол олгох “Үе тэнгийн сургагч багш бэлтгэх” 3 хоногийн сургалтыг амжилттай зохион байгуулж, сургалтад Булган сумын ерөнхий боловсролын 1, 2, 3-р сургууль, МСҮТ, Спортын сургуулийн 8-10 дугаар ангийн нийт 25 хүүхдийг өсвөр үеийн сургагч багшаар бэлтгэлээ.	40
	36	1.2.2.3. “Нэг дэлхий-Нэг эрүүл мэнд” зарчмыг баримтлан, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэн, Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээний бэлэн байдал, нөөц хангамжийг сайжруулах	2017 - 2020	АЗДТГ, ЭМГ		2 суманд бэлэн байдлын үзүүлэх сургууль хийж, сум бүрт салбар дундын баг байгуулна.	Монгол улсын Засгийн газрын 2008 оны 305 дугаар тогтоол, Шадар сайдын 2017 оны 08 тоот “Болзошгүй гамшиг ослоос сэргийлэх, НЭМ-ийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах” журмын хэрэгжилтийг эрчимжүүлж, Аймгийн Засаг даргын 2018 оны А/113 дугаар захирамжаар Эрсдэлийн үнэлгээний баг, ЭМГ-ын даргын 2018 оны А/02 дугаар тушаалаар зоонозын халдварт өвчний голомтод ажиллах мэргэжлийн багийг 2 ээлжээр тус тус томилсон. 2018 онд бүртгэгдсэн мал, амьтны гоц халдварт шүлхий	70

							өвчний дэгдэлтэд холбогдох байгууллагуудтай хамтран, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажилласан. Гамшгаас хамгаалах команд штабын үзүүлэх сургуульд хамрагдсан.	
	37	1.2.2.4. Дамжуулагчаар дамжих халдварт өвчнөөс эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, голомттой бүс нутагт тандалт судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, өвчлөлийн талаарх эргэн мэдээллийн тогтолцоог сайжруулах	2016 - 2020	ЭМГ, АНЭ, сумын ЗДТГ		Голомттой бүс нутагт тандалт судалгаа хийгдсэн байна.	2018 онд дамжуулагчаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдлын 14 шинжилгээний сорьцыг ЗӨСҮТ-д илгээсэн. 2 тохиолдол халдвартын тасагт хэвтэн эмчлүүлсэн. Голомттой бүсийн 9 сумдын 2916 иргэнийг шинээр, 650 иргэнийг давтан дархлаажуулсан. Халдварт өвчний мэдээлэлд дүгнэлт хийж, анхан шатны нэгжид 7 хоног тутмын эргэн мэдээллийг хүргүүлж байна.	70
	38	1.2.2.5. Заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан иргэдийн дархлалын түвшинг үнэлж, дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2017 - 2018	ЭМГ		Дархлаажуулалтад хамрагдсан иргэдийн дархлалын түвшин тогтоогдоно. ЭМБ-уудын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж шинэчлэгдсэн байна.	Улаан бурхан, улаануудын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан 1-35 насны 28 иргэнээс ийлдэс ялган, дархлалын түвшин тогтоох судалгаанд хамруулсан. Судалгаагаар дархлалын түвшний титр 80-85%-тай гарсан байна. Заавал хийх дархлаажуулалтын 19 нэгжийг вакцин биобэлдмэл хадгалах МК074 маркын мөсөн ханатай хөргөгчөөр 100 хувь хангасан. Хөргөгчийн ашиглалтад хяналт тавин хамтран ажиллаж байна. 2018 оны эхний 10 сарын байдлаар тарилгатай халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.	100
18/	39	1.2.3.1. “Сум, өрхийн Эрүүл мэндийн төвийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлэх	2017 - 2020	ЭМГ		ИТХ-аар бодлогын баримт бичгийг шинэчлэн батлуулж, хэрэгжүүлсэн байна.	2017-2020 онд Эрүүл мэндийн салбарын хэмжээнд баримтлан ажиллах “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр”-т сум, өрхийн ЭМТ-ийг хөгжүүлэх асуудлуудыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70
	40	1.2.3.2. Сум, багийн	2016	АЗДТГ,		Жил бүр орон	Булган, Сэлэнгэ, Могод, Хутаг-Өндөр, Тэшиг сумдын	40

сайжруулна.		түвшинд “Аймгийн Засаг даргын нэрэмжит” нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг зохион байгуулах	- 2020	ЭМГ, АНЭ		нутгийн хүн амын 20-иос доошгүй хувийг хамруулна.	Эрүүл мэндийн төв, аймгийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан баг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог 6 чиглэлээр зохион байгуулж, 1456 иргэдийг хамруулсан. Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдрийг тохиолдуулан Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 20 байгууллагын 450 төрийн албан хаагчдыг дотор, мэдрэл, ЭХО, рентген, нүд, чих хамар хоолой, шүд, хавдар, арьс, БЗДХ-ын үзлэг, шинжилгээнд хамруулсан.	
	41	1.2.3.3. Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудад уламжлалт анагаах ухааныг түгээн дэлгэрүүлж, мэргэжилтэнүүдээр ханган, эмчилгээ, оношилгооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	2016 - 2020	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд		Эмийн бус эмчилгээний чанар сайжирна. Эмийн эмчилгээний зардал буурна. Бүх сумдыг уламжлалт анагаах ухааны эмчээр хангана.	Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудад Уламжлалт анагаах ухаан, нөхөн сэргээх чиглэлээр 8 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна. Хэвтэн эмчлүүлэгчид болон амбулаториор үйлчлүүлэгчдэд бумба, УВЧ шарлага, хэт ягаан туяагаар шарах, цахилгаан төөнүүр, зөгийн балтай татлага, иллэг массаж зэрэг эмийн бус эмчилгээг хийж үйлчилж байна.	70
	42	1.2.3.4. Сумдын Эрүүл мэндийн байгууллагуудын “Яаралтай тусламж”-ийн хэсгийг стандартын шаардлагад нийцүүлэн цогц байдлаар иж бүрэн зохион байгуулж, эрсдэлийн түвшинг бууруулах	2016 - 2020	НБХ, ЭМГ, АНЭ		Хоног болоогүй нас баралт буурна.	Аймгийн ЭМГ-ын мэргэжлийн баг хүлээн авах, яаралтай тусламжийн бэлэн байдал, холбогдох тушаал, журам, зааврын хэрэгжилтийн байдалд бүх сумдад 1-3 удаа хяналт, үнэлгээ хийж, ЭМБ-уудад зөвлөмж хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. УНТЭ-ийн Яаралтай тусламжийн тасаг, Монголын Яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран “Амилуулах, лавшруулсан тусламж” сэдэвт дадлага, сургалтыг 5 өртөөгөөр гардан үйлдлээр зохион байгуулж, 118 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан. Сумын Эрүүл мэндийн байгууллагуудын “Яаралтай тусламжийн нэгж”-ийг ЭМС-ын 2012 оны 375, 2013 оны 297 тоот тушаалыг үндэслэн зохион байгуулан, “Яаралтай тусламж үзүүлэх журам”, “Төв болон алсын дуудлагын журам”, “Өвчтөнийг эмнэлэг хооронд шилжүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Рашаант сум 4.2 сая төгрөгөөр хяналтын монитор, соруулгын аппарат, Орхон сум 3.9 сая төгрөгийн өвчтөний хяналтын	70

							монитороор хангагдсан. Хутаг-Өндөр сумын Сум дундын эмнэлэг яаралтай тусламжийн 2 өрөө бүрэн тохижуулж, олон үйлдэлт хяналтын монитор, стандартын шаардлага хангасан өвчтөний ор, тумбочка, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, дуслын автомат шахуурга, пульсоксиметр, эмийн шүүгээ, хамгаалах өмсгөлийн шүүгээ, тарилгын тэргэнцэр, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх нэг удаагийн хэрэгслүүд зэргээр хангагдаж, сумдын хэмжээнд жишиг болохуйц хүлээн авах, яаралтай тусламж үзүүлэх орчныг бүрдүүлж чадлаа.	
	43	1.2.3.5. Хувийн хэвшлийн мэндийн байгууллагуудын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх Эрүүл	2016 - 2020	НБХ, ЭМГ		Анхан шатны тусламж үйлчилгээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд ыг оролцуулна.	Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн 69 Эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба 2018 онд ариутгал халдваргүйтгэлийн чиглэлээр 1, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдаалах чиглэлээр 2, рашаан сувиллын чиглэлээр 1, шүдний чиглэлээр 1 Эрүүл мэндийн байгууллага шинээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.	100
/9/ 1.2.4. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн, эмчилгээ оношилгооны шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэдэд сэтгэлд нийцсэн үйлчилгээ үзүүлнэ.	44	1.2.4.1. Хоёрдахь шатлалын эмнэлгийн стандартын түвшинд мэргэжлийн байгууллагатай хамтран үнэлгээ хийж, нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эмч, эмнэлгийн мэргэжилтэнээр шат дараатай хангах	2016 - 2020	ЭМЯ, ЭМГ	115.6 /орон нутгийн хөгжлийн сан/	Стандартын хэрэгжилт 2016 оныхоос нэмэгдсэн байна. Нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнээр 100 хувь хангагдсан байна.	Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны MNS5095:2017 стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, стандартын хангалтыг нэмэгдүүлсэн. 2018 онд 2 дахь шатлалын үндсэн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх Чих хамар хоолой, Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ, Эмэгтэйчүүд, Гэмтэл, Дуран, Дүрс оношилгоо зэрэг нарийн мэргэжлийн 6 эмчийн орон тоог нэмэгдүүлснээр хүний нөөцийн хангалт 97.1% -тай байна. Байгууллагын Стандартын хангалт 76.8%, нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 84.0%-тай байна.	70
	45	1.2.4.2. “Яаралтай тусламжийн тасаг”-ийг стандартын түвшинд нийцүүлэн, нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шат дараатай шийдвэрлэх	2016 - 2020	НБХ, ЭМГ, АНЭ		Хоног болоогүй нас баралт буурна.	“Яаралтай тусламжийн тасаг” нь 16 орон тоо, 6 автомашинаар тусламж үйлчилгээг хүргэн, өрөө тасалгааг стандартын түвшинд нийцүүлэн тохижуулснаар стандартын хэрэгжилт 78.0%-тай байна. Энэ онд тус тасагт хүчилтөрөгч өтгөрүүлэгч 1ш, Утлагын аппарат 2ш хангаж, хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулахад анхаарч ажиллаж байна. Хоног болоогүй нас баралтын 5 тохиолдол бүртгэгдсэн нь /14.9 хувь/ 2016 оны мөн үетэй	70

						харьцуулахад (12/31.6) 7 тохиолдлоор буюу 16.9 хувиар буурсан.	
46	1.2.4.3. “Гемодиализын эмчилгээ”-г нэвтрүүлэх	2016 - 2020	НБХ, ЭМГ, АНЭ		Иргэдийн сэтгэл ханамж дээшилж, чирэгдэл багасна.	Гемодиализ эмчилгээг 2016 оны 09 дүгээр сараас NCU-18, PLUSS-55 маркын хоёр аппараттай эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар Булган аймгийн-5, Орхон аймгийн-5, Улаанбаатар хотын-3 нийт 13 хүнд бөөр орлуулах эмчилгээг 7 хоногт 5 өдөр 1 ээлжээр 854 удаагийн сеанс эмчилгээг 3416 цаг хийсэн байна. Эмчилгээнд орохын өмнөх үзлэг болон явцын хяналтыг хийж хүндрэлгүй диализ хийж байна. Хяналтын шинжилгээг сард нэг удаа 9 эмчлүүлэгчээс авч хяналтын картанд тэмдэглэн шинжилгээний дүн, гемодиализ эмчилгээний үр дүнг танилцуулж эмэн эмчилгээг тухай бүрт нь хийж байна. Амбулаториор Гемодиализын эмчийн үзлэг хийж бөөрний архаг дутагдалтай 42, бөөрний дутагдлаар хүндэрч болзошгүй хавсарсан өвчтэй 19 хүнийг илрүүлж хяналтад авч товлोलт үзлэг шинжилгээг хийж байна. 2018-2019 онд Бөөр орлуулах эмчилгээнд орж болзошгүй 3 эмчлүүлэгчийг сар бүр шинжилгээ хийж эмэн эмчилгээг зөвлөж урьдчилан сэргийлж байна. 10 дугаар сарын 19-ний байдлаар эмийн зардалд 75.4 сая төгрөг зарцуулсан байна.	100
47	1.2.4.4. “Дурангийн кабинет”-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж, Дурангийн мэс заслыг нэвтрүүлэх	2016 - 2020	НБХ, ЭМГ, АНЭ	6 /улсын төсөв/	Нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээний чанар сайжирна. Иргэдийн сэтгэл ханамж дээшилж, чирэгдэл багасна.	Өнгөрсөн 2 жилийн хугацаанд дурангийн кабинетаар 588 иргэн үйлчлүүлж, ходоодны шарх 4, хавдар 8 тохиолдол шинээр илэрсэн байна. 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мэс заслын тасаг дурангийн хагалгааны иж бүрдэл аппаратаар хангагдаж, нарийн мэргэжлийн эмчийг бэлтгэн, 2018 онд Улсын нэгдсэн төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нартай ажлын байрны сургалтыг зохион байгуулан 10 өвчтөнд дурангийн хагалгааг хийсэн.	100
48	1.2.4.5. “Цусны төв”-ийг байгуулах.	2016 - 2020	ЭМГ, АНЭ		Цусны донорыг 2%-д хүргэнэ.	ЭМСХХ-5 төслийн санхүүжилтээр “Цусны салбар төв”-ийг тохижуулан цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг ханган ажиллахад стандартын шаардлага хангасан цус цуглуулах, үйлдвэрлэх, хадгалах тээвэрлэх зориулалтын 64 нэр төрлийн 400.0 сая төгрөгийн	100

						тоног төхөөрөмжөөр хангасан. Цусны төв нь нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсанаар 101 нэгж цус цусан бүтээгдэхүүнийг эмчилгээнд хэрэглэхэд урвал хүндрэл гараагүй байна.	
49	1.2.4.6. Донорын эгнээг өргөтгөх сайн үйлсийн аянг зохион байгуулж, хэвшүүлэх.	2017 - 2020	АЗДТГ, ЭМГ, төрийн болон төрийн бус байгууллага		Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна.	2018 онд “Донорын эгнээг өргөтгөх сайн үйлсийн аян”-ыг зохион байгуулж, шинээр 3 байгууллагын нийт 22 шинэ донор элсүүлж, идэвхтэн 66 донороос ЦЦБ бэлтгэж, СДЭ, СЭМТ, тасаг нэгжүүдийг ханган ажиллаж байна. Аймгийн нийт хүн амын 5.6%-ийг донорт элсүүлсэн. Аймгийн төвийн 27 байгууллага, 16 сумын Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран донорын үйлсийг сурталчлан хамтын ажиллагааг сайжруулан ажиллалаа. Хутаг-Өндөр суманд 3 удаа, Сэлэнгэ суманд 1 удаа, Мааньтын хорих ангид 1 удаа тус тус очиж донор элсүүлэх ажлыг зохион байгуулсан. Хутаг-Өндөр сум, Мааньтын хорих анги “Донор хамт олон” боллоо. ЭМС-ын 2017 оны А/03 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор эмч сувилагч нарт “ЦЦБ-ийг сэлбэх үеийн бэлэн байдал, эмнэл зүй” сэдэвт онолын болон дадлага сургалтыг зохион байгуулж, нийт 39 эмч, 70 сувилагч мэргэжилтэн амжилттай оролцлоо.	100
50	1.2.4.7. Эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайны оношилгоог нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	2016 - 2020	НБХ, ЭМГ, АНЭ		Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын СДЭ-үүдэд алсын зайн оношилгоог нэвтрүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.	УНТЭ-ийн алсын зайн оношилгооны албатай хамтран дотрын 1, мэс заслын 1 өвчтөнд зайн оношилгоо хийгдсэн. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс болон бусад эмнэлгүүдийн зохион байгуулсан нийт 47 удаагийн сургалтад нийт 231 /давхадсан тоогоор/ эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаад байна. СДЭ, СЭМТ-үүдэд гар утсаар нарийн мэргэжлийн эмч, Зөвлөх эмч нар зөвлөгөө өгч ажиллаж байна	70
51	1.2.4.8. “Эмчилгээний хоолны газар”-ыг байгуулах	2017 - 2020	ЭМГ, АНЭ		Эмчилгээний хоол үйлдвэрлэлийн стандарт хангагдана.	АНЭ-ийн гал тогоонд 2017 онд Туркийн хамтын ажиллагааны нийгэмлэг /TİKA/-ийн хөрөнгө оруулалтаар засвар хийгдэж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаад байна. Эмчилгээний хоолны чиглэлээр 2 тогооч УНТЭ-т хоол эмчилгээний тасагт мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан. “Зохистой хооллолт”-ын өдөрлөгийг зохион байгуулж хоол боловсруулах зам, зүрх судас, элэг цөс, нойр булчирхай, чихрийн шижин, бөөрний өвчний үеийн эмчилгээний хоолны талаар ханын	100

						самбарыг байршуулсан.	
52	1.2.4.9. “Уламжлалт анагаах ухааны төв”-ийг байгуулж, уламжлалт болон сэргээн засах тусламж үйлчилгээг өргөжүүлэх	2016 - 2020	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд		Эмийн эмчилгээний зардал буурна. Нөхөн сэргээх эмчилгээний үр дүн сайжирна.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Уламжлалт эмчилгээний тасаг нь 185 эмчлүүлэгч хүлээн авч 18 төрлийн уламжлалт болон сэргээн засах эмчилгээний тусламжийг үзүүлсэн. Амбулаториор 2834 хүнд үйлчилсний 120 нь харьяаллын бус, 606 нь хөдөө орон нутгийн үйлчлүүлэгчид байна. Бариа заслын кабинетаар 13 нэр төрлийн тусламж үйлчилгээг нийт 1133, цахилгаан эмчилгээний кабинетаар 12 төрлийн аппаратаар 1629 эмчлүүлэгчид гэрэл болон цахилгаан эмчилгээний тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Тархины цус харвалтын дараах болон яс, зөөлөн эдийн гэмтлийн дараах, хагалгааны болон бэртэл гэмтлийн дараах, нурууны мэдрэлийн сүлжээний үрэвслийн сэргээн засах жороор нийт 435 иргэнд хөдөлгөөн заслын тусламж үйлчилгээг 2141 удаа үзүүлсэн байна.	70
53	1.2.4.10. “Эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх кабинет”-ийг байгуулж, эрчүүдийн дунд тохиолдож буй өвчлөл, эндэгдлийг бууруулах	2016 - 2020	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд		Эрэгтэйчүүдийн өвчлөл, эндэгдлийн түвшинг 2016 оныхоос бууруулна.	Сүүлийн 2 жилийн байдлаар аймгийн хэмжээнд бүртгэгдсэн нийт 662 нас баралтыг хүйсээр нь авч үзэхэд эрэгтэйчүүдийн нас баралт 60.0 хувийг эзэлж байна. Нас баралтын шалтгааныг өвчлөлийн байдлаар судлахад эрчүүдийн дунд цусны эргэлтийн тогтолцооны эмгэг, осол гэмтэл, хавдар /элэг/ зэрэг тэргүүлэх чиглэл байна. Монгол улсын урологийн эмч Булган аймгийн Дашинчилэн сумын уугуул Хорлоо эмчийн удирдлага доор нарийн мэргэжлийн эмчийг бэлтгэхээр гэрээ байгуулан, аймгийн нэгдсэн эмнэлгийг түшиглэн 2 удаа нийт 150 гаруй эрэгтэйчүүдийг үзлэгт хамруулан зөвлөгөө авсан. Төрийн албан хаагчдын үзлэгээр 371 эрэгтэйчүүдийг үзлэгт хамруулсан.	40
54	1.2.4.11. Лабораторийн чадавхийг сайжруулах	2017 - 2018	АЗДТГ, ЭМГ		Стандартын хэрэгжилт сайжирна.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Лабораторийн тасаг Гематологийн бүрэн автомат анализатор, Коагулаграммын START MAX анализаторуудыг үйл ажиллагаандаа хэрэглэснээр шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн шинээр ЛАКТАТ, ТРОПИНИН, ХАВДРЫН МАРКЕРУУД-ын /AFP, CA-125, PSE/ үзүүлэлтүүдийг шинжилж байна. 2018 оны эхний 10 сарын байдлаар давхардсан тоогоор 49174 үйлчлүүлэгчид 15 төрлийн 157903 шинжилгээг хийгээд байна. Биохими, иммунологийн бүрэн автомат анализаториуд хэвийн ажиллаж, “Элэг	100

							бүтэн монгол хөтөлбөр"-ийн элэгний В, С вирус илрүүлэх болон баталгаажуулах шинжилгээнүүд бүрэн хийгдэж байна.	
/10/ 1.2.5. Сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилагчийн мэргэжлийн цогц үйл ажиллагаанд орчин үеийн шинэлэг аргуудыг нэвтрүүлнэ.	55	1.2.5.1. Эрүүл мэндийн байгууллагуудад сувилгаа асаргааны шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	2016 - 2018	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд		Сувилахуйн тусламж үйлчилгээнд жил бүр 2-3 шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.	Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд зориулан Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн газрын даргын тушаалыг эмхэтгэн “Сувилгааны түүх хөтлөлтөд ашиглах эрх зүйн акт, удирдамж” номыг 100 хувь хэвлүүлсэн нь сувилгааны түүх хөтлөлтийг сайжруулахад дөхөмтэй ажил боллоо. 2017-2018 онд 14 сувилахуйн постыг компьютержүүлж дотоод сүлжээнд холбон, сувилахуйн тусламж үйлчилгээнд хөтлөгдөх 2-11 маягтыг цахимжуулсан. Эрүүл мэндийн байгууллагуудын шатлал бүрт байгууллагын онцлогт тохируулан, сувилахуйн тусламж үйлчилгээнд COPE аргыг нэвтрүүлж, ажлын байрны эрүүл, ээлтэй орчинг бүрдүүлж, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн эрүүл мэндийг дэмжин ажиллаж байна. “Дуут дохиолол” системийг 4 байгууллагад нэвтрүүлснээр яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангасан. Сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн 6 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулснаар 36 нэр төрлийн үйлдлийг хянах шалгуур хуудсыг боловсруулан, ЭМГ-ын даргын 2018 оны А/26 дугаар тушаалаар баталгаажуулсан. ЭМС, ЭМГ-ын даргын тушаалаар батлагдсан 56 хяналтын хуудсыг эмнэлгийн тусламж үйлчилгээний дотоодын хяналтад нэвтрүүлэн үр дүнг тооцон, ижил мэргэжилтний үзлэг хяналт, ажлын байранд суралцуулж дадлагажуулах, стандарт удирдамжийг мөрдүүлж хэвшүүлэх, үйл ажиллагаанд ашиглах зорилгоор журнал болгон 40 ширхэгийг хэвлүүлэн ЭМБ-уудад тараасан.	100
	56	1.2.5.2. “Туслах сувилагч”-ийг бэлтгэн, сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх, сэргээн засах, уламжлалт сувилгааг өргөжүүлэх	2017 - 2020	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд		Туслах сувилагчийн тоог 50 хувиар нэмэгдүүлнэ. Хөнгөвчлөх эмчилгээний удирдамжийн хэрэгжилтийг 90 хувьд хүргэнэ.	Аймгийн Эрүүл мэндийн салбарт 2016-2020 онд баримтлан ажиллах “Хүний нөөцийг хөгжүүлэх бодлого”-ыг хэрэгжүүлэн орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэх зорилтын хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэгт тогтвор суурьшилтай ажилласан 3 үйлчлэгчийг АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургуульд сувилагчаар, 9 Эрүүл мэндийн байгууллагын 13 үйлчлэгчийг туслах сувилагчийн сургалтад элсүүлсэн. Сэлэнгэ сумын	100

							Эрүүл мэндийн төв нь туслах сувилагчийг IX/01-ээс орон тоогоор нь ажиллуулж эхэлсэн. Сэргээн засах эмчилгээг 31 төрлөөр, 6973 хүнд үзүүлж, хорт хавдар өвчний улмаас хяналтад байгаа 461 өвчтөний 257 нь амбулаториор, стационарт 258 нь хэвтэн эмчлүүлэн хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан байна. Гэрээр 386 хүнд сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэн тэмдэглэл хөтөлсөн.	
	57	1.2.5.3. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа сувилгаа, зөвлөгөө өгөх “Өдрийн эмчилгээний төв”-ийг байгуулах	2016 - 2020	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд		“Өдрийн эмчилгээний төв”-тэй болсон байна.	Амбулаторийн тасагт “Өдрийн эмчилгээний өрөө”-г байгуулан ажиллаж нийт 144 өвчтөнд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. Үүнд: Дотрын кабинет 56, Мэдрэлийн кабинет 66 өвчтөнд, Хүүхдийн кабинет 22 хүүхдэд өдрийн Өвчний түүх нээсэн эмчилгээ үйлчилгээ үзүүлсэн. Хүүхдийн тасагт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа сувилгаа, зөвлөгөө өгөх өрөө”-г тохижуулан ажиллуулж байна.	70
/11/ 1.2.6. Эм зүйн шинжлэх ухааны шинэ аргуудыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны эмчилгээнд нэвтрүүлнэ	58	1.2.6.1. Эрүүл мэндийн байгууллагуудад эм зүйн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөн, эм зүйн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2016 - 2020	ЭМГ, ЭМБ, ЭХБ		Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 90 хувьд хүрсэн байна.	Хүн амд эм зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, ЗШЭ-ийн эмийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Баяннуур, Дашинчилэн, Баян-Агт, Хангал сумдад хувийн хэвшлийн эмийн санг шинээр нээн ажиллуулж, эм зүйн тусламж үйлчилгээг өргөжүүлсэн. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг “Нэгдсэн худалдан авалт” болон “Ерөнхий гэрээ”-гээр худалдан авснаар Эрүүл мэндийн байгууллагуудын эмийн хангамж хүртээмж нэмэгдэж 86 хувьд хүрсэн ба өмнөх онтой харьцуулахад 1 хувиар нэмэгдсэн. Эмийн мэргэжилтнүүдэд 2 удаагийн сургалт зохион байгуулан 62 мэргэжилнийг хамруулсан. Эмийн сангуудад цахим жорын программын шинэчлэл хийж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан.	100
	59	1.2.6.2. Эм зүйн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн “Уламжлалт анагаах ухааны эмчилгээний эмийн сан”-г шинээр байгуулах	2016 - 2020	ЭМГ, ЭМБ, ЭХБ		Эм зүйн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 20 эмийн сан уламжлалт анагаах ухааны эмийг 6 нэр төрлөөр худалдан борлуулж байна.	70
	60	1.2.6.3. Орон нутагт хувийн хэвшлийн эмийн сангуудыг	2017 - 2020	НБХ, ЭМГ		Эм зүйн тусламж үйлчилгээний	“Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг орон нутагт хэрэгжүүлэн хүн амд эм зүйн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх зорилгоор	100

		шинээр байгуулахад дэмжлэг үзүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох				нэр төрөл нэмэгдэнэ.	Баяннуур, Дашинчилэн, Баян-Агт, Хангал, Тэшиг сумдад 5 хувийн хэвшлийн эмийн санг шинээр ажиллуулах тусгай зөвшөөрлийг олгосон. Булган суманд “БЭРШ ФАРМ” ХХК-ны 24 цагийн үйлчилгээтэй хувийн хэвшлийн эмийн санг шинээр нээн ажиллуулж, эмийн үнэ, чанараар өрсөлдөх боломжийг бүрдүүлсэн	
/12/ 1.2.7. Эмнэлгийн мэргэжилтэнүүдийг мэргэшүүлэх, давтан сургах хүний нөөцийн хөгжлийн аймгийн бодлогыг тодорхойлж, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэн, залгамж халааг бэлтгэнэ	61	1.2.7.1. “Булган аймгийн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого”-ыг хэрэгжүүлэх	2017 - 2020	АЗДТГ, ЭМГ		Эмч, эмнэлгийн мэргэжилтний хангалтыг 95.0 хувьд хүргэнэ.	Булган аймгийн “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2017-2020 онд хөгжүүлэх бодлого”-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Эрүүл мэндийн газрын даргаар батлуулан хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 85%-тай байна. Төлөвлөгөөнд тусгаснаар энэ оны эхний улирлын байдлаар төрийн сангийн санхүүжилтээр 2017-2018 оны хичээлийн жилд төрөлжсөн нарийн мэргэжлээр салбарын 18 эмч, мэргэжилтэнтэй гэрээ байгуулж, сургалтад элсүүлэн, сургагдаж байна. Эмнэлгийн 5 их эмчийг ажлын байрны солилцох сургалтад хамруулан сэлгэн ажиллуулсан.	100
	62	1.2.7.2. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн төгсөлтийн дараахь сургалтын чиглэлээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх	2017 - 2020	АЗДТГ, ЭМГ, ЭМБ-ууд		Жилд 1-ээс доошгүй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж, дадлагажуулна.	Аймгийн хэмжээнд нэн тулгамдаж буй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Сингапур, Хятад, ОХУ, Япон зэрэг өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах, ажлын байрны дадлага, танилцах сургалтуудад 8 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдаад байна.	100
/13/ 1.2.8. Эрүүл мэндийн байгууллагуудын орчин нөхцлийг сайжруулан, мэдээллийн технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	63	1.2.8.1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасаг, Баян-Агт, Баяннуур, Дашинчилэн, Хялганат, Гурванбулаг сумын ЭМТ-ийн барилгад их засвар хийх	2016 - 2020	АЗДТГ, ЭМГ	140 /улсын төсөв/	Иргэдэд ээлтэй орчин бүрдэж, сэтгэл ханамж нэмэгдэнэ	Гурванбулаг сумын ЭМТ, Хутаг-Өндөр СДЭ-ийн Хантай багийн бага эмчийн салбар, Эрүүл мэндийн газрын конторын барилгын их засварын ажлыг улсын төсвийн 140.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн.	100
	64	1.2.8.2. Булган суманд 30 ортой халдварт Сүрьеэгийн тасаг, Орхон, Могод сумын Эрүүл мэндийн төвийн 10 ортой эмнэлгийн барилгыг шинээр барих.	2017 - 2020	АЗДТГ, ГХБХБГ, ЭМГ	475 улсын төсөв/	Стандартын шаардлага хангасан эмнэлгийн барилгын тоо нэмэгдэнэ.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдварт Сүрьеэгийн тасгийн шинэ барилгын ажилд нийт 2.1 тэрбум төгрөг батлагдсанаас 2018 онд 475.0 сая төгрөг батлагдаж, барилгын суурь ажил эхлээд байна. Үлдэгдэл 1643.0 сая төгрөгийн санхүүжилт 2019 онд батлагдсан.	70

	65	1.2.8.3. Эрүүл мэндийн байгууллагуудыг стандартын шаардлагад нийцсэн орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шат дараатай шийдвэрлэх	2017 - 2020	АЗДТГ, ЭМГ		Эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ.	Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн байгууллагуудад улсын төсөв, Орон нутгийн хөгжлийн сан болон бусад гадаад дотоодын хандивлагч байгууллагуудаас хөрөнгө оруулалтаар хог хаягдал бутлах төхөөрөмж, ургийн зүрхний бичлэгийн аппарат, зүрхний эхо, сурфактант эмчилгээний эх, нярайн тоног төхөөрөмж, тариур бутлагч аппарат, зэрэг бусад оношилгоо эмчилгээний эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангагдсан.	70
	66	1.2.8.4. Бугат, Сэлэнгэ, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Могод, Хялганат, аймгийн Нэгдсэн эмнэлгийг яаралтай түргэн тусламжийн автомашинаар үе шаттай хангах		АЗДТГ, ЭМГ		Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлтийг 100 хувьд хүргэнэ.	ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Баяннуур сумын ЭМТ-ийг түргэн тусламжийн автомашинаар хангалаа.	100

1.3 Нийтийн биеийн тамир, спорт

Үндэсний спортын өв, соёл, эрүүл амьдралын дадал хэвшлийг дэлгэрүүлж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, спортыг бүх нийтийн үйл хэрэг болгоно.

<i>114/</i> 1.3.1. Тамирчдын хөгжих, уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлэхэд анхаарч, амжилт гаргах, алдаршуулахад бодлогоор дэмжиж ажиллана.	67	1.3.1.1. Тамирчдын уралдаан тэмцээн, шагнал урамшуулал болон спортыг дэмжигч Аж ахуйн нэгж, холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ БТСГ, СЗДТГ	Улсын төсвөөс 33 515 980 ОНТөсө в 33 821 170	ААШТ-ийг спортын 18 төрлөөр, НБТ-ын 12 арга хэмжээг зохион байгуулна.	Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 11 төрлөөр зохион байгуулж нийт 3504 тамирчид хамрагдсан. Улсын аварга шалгаруулах 30 удаагийн тэмцээнд спортын 21 төрлөөр оролцож 167 медаль, Олон улс, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд спортын 7 төрлөөр 24 медаль, олон хот бүс, нэрэмжит тэмцээнд спортын 12 төрлөөр 58 медаль, нийт 249 медаль тус тус хүртсэн амжилттай байна. Нийтийг хамарсан 15 удаагийн уралдаан тэмцээнийг төлөвлөснөөс одоогийн байдлаар 12 арга хэмжээнд нийт 2378 иргэд хамрагдаад байна. Олон улс, Ази тив, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд аймаг орон нутгаа төлөөлөн оролцож байгаа тамирчдад аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, БТСГазрын уралдаан тэмцээний зардал, тухайн спортын холбоод болон хандив тусламжаар санхүүгийн дэмжлэг үзүүлэн уралдаан тэмцээнд оролцуулж байна. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 6.1 сая төгрөг, Улсын аварга шалгаруулах тэмцээнд 21.8 сая төгрөг,	100
---	----	---	-----------	------------------------	--	---	---	-----

							нийтийг хамарсан арга хэмжээнд 5.6 сая төгрөг, нийт 33.5 төгрөг зарцуулсан. Сумдад спортын төрлүүдийг сурталчлан, хүүхэд залуучуудын спортоор хичээллэх сонирхлыг нь дэмжих зорилгоор аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 7 суманд хамтран зохион байгууллаа.	
68	1.3.1.2. Хүүхдийн, Ахмадын, Үндэсний спортын, Бүх ард түмний спортын наадмуудыг зохион байгуулах, улсын тэмцээнд тамирчдыг оролцуулахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ БТСГ, СЗДТГ	Орон нутгийн төсөв 9.0 төгрөг	Үндэсний спортын наадмыг спортыг өвлийн-2, зуны10 төрлөөр зохион байгуулна.	Үндэсний спортын VI их наадмын Өвлийн спортын төрөл мөсний шагай, мөсний сурын харвааг аймгийн хэмжээнд 02 дугаар сард зохион байгуулж, шалгарсан тамирчид улсын аварга шалгаруулах шигшээ тэмцээнд амжилттай оролцсон. Зуны төрлийг спортын 10 төрлөөр /Үндэсний сурын харваа, Буриад сурын харваа, Уламжлалт сурын харваа, Урианхай сурын харваа, Үндэсний бөх, шагайн харваа, ширээний шагай, хурдан морины уралдаан, Жороо морины уралдаан, Уран уургач, бугуйлч, эмнэг булгиулагч/ төрлүүдээр зохион байгууллаа. Монголын Үндэсний спортын VI их наадмын шигшээ тэмцээн 2018 оны 08 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд Хүй долоон худагт зохион байгуулагдаж нийт 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэг, нийт 30 багийн тамирчид оролцсоноос Булган аймгаас нийт 56 тамирчид дараах спортын төрлүүдээр амжилттай оролцлоо. Үүнд: /Үндэсний бөх, Шагайн харваа, Сурын харваа, Ширээний шагай, уран уургач, эмнэг булгиулагч, жороо морь/ Шагайн харвааны тэмцээнд Хүрэл медаль, мөсний сурын харваан тэмцээнд Булган аймгаас нийт 27 харваачид оролцож МУ-ын спортын мастер 1, спортын дэд мастерын болзлыг 2 харваач хангасан байна. Үндэсний бөхөөр мөнгөн медаль, Залуу бөхчүүдийн барилдаанд IV байранд тус тус шалгарсан байна. Ширээний шагайн насанд хүрэгчдийн ганцаарчилсан төрөлд V байр, Өсвөр үеийн ганцаарчилсан төрөлд мөнгөн медаль хүртэж тус наадмаас Булган аймгийн баг тамирчид багийн дүнгээр XI байр эзэлсэн. Үндэсний сурын харваанд спортын мастерын болзлыг 2 харваач хангасан. Шагайн харваагаар МУ-ын мэргэн цолыг 6 харваач хүртэж, нийт 12 медаль хүртлээ. Монголын мастеруудын IV наадам Булган аймгийн Булган суманд 2018 оны 08 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд шатар, кросс гүйлт, граунд гольф, софт волейбол, ширээний теннис, дартсын төрлүүдээр зохион	100	

							байгуулагдаж тэмцээнд нийт 11 аймаг, Улаанбаатар хотын 14 дүүрэг, клубын нийт 25 байгууллагын давхардсан тоогоор 699 тамирчид оролцлоо.	
	69	1.3.1.3. Үндэсний бөх, хурдан морь, сур, шагайн спортыг дэмжиж, улсын алдар цолтой хүмүүсийн нэрэмжит тэмцээнийг уламжлал болгон тогтмолжуулах, сурталчлах ажлыг үе шаттайгаар хийх	2016-2020	АЗДТГ, НБХ БТСГ, Спортын холбоод	ОНТөсө в, хөтөлбөр, Спорт холбоодын хөрөнгө оруулалт 1056950	Алдартнуудаа сурталчилж үндэсний спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна.	Үндэсний спортын төрлүүдээр аймгийн хэмжээнд секц дугуйланг хичээллүүлэхийн зэрэгцээ Булган аймгаас төрөн гарсан алдар цолтой бөхчүүд болон тамирчдаа алдаршуулан сурталчлах зорилгоор нэрэмжит арга хэмжээнүүдийг уламжлал болгон зохион явуулж хэвшсэн. Монгол улсын арслан Б.Жамъяндоржийн нэрэмжит өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах үндэсний бөхийн барилдааныг Гурванбулаг суманд 09-р сард хамтран зохион байгуулж, тус барилдаанд 13 сум, байгууллагын 154 өсвөрийн бөхчүүд 6 насны ангиллаар өрсөлдлөө. МУ-ын хүчит заан Д.Амгаагийн нэрэмжит үндэсний бөхийн барилдааныг Дашинчилэн суманд зохион байгуулж, барилдаанд 28 бөх тойргоор барилдаж тус барилдааныг жил бүр зохион байгуулахаар шийдвэрлэлээ. Хөдөөгийн хүчтэн "Сорилго барилдаан"-д 30 бөх барилдаж шалгарсан бөхчүүд "Хөдөөгийн хүчтэн-2018" төвийн бүсийн барилдаанд Өвөрхангай аймгийн Хархорин суманд оролцож Тэргүүн байр эзэлж Улсын аварга шалгаруулах барилдаанд оролцох эрх авлаа. Аймгийн хэмжээнд "Монгол нум сум" дэд хөтөлбөрийг 2017 оноос хэрэгжүүлэн эхэлснээс хойш сонирхон хичээллэгсдийн тоо нэмэгдэж, сумдад үндэсний баяр наадмаар Үндэсний сурын харвааг зохион байгуулж хэвшсэнээс гадна сургуулиудад үндэсний спортын талаар сурталчлан тэмцээн уралдаанд идэвхтэй оролцож байна. Шагайн харвааг хөгжүүлэх тал дээр анхааран холбооны үйл ажиллагааг дэмжин тусалж ажиллахын зэрэгцээ БТСГазарт шагайн харвааны заалыг тохижуулан тогтмол бэлтгэл сургуулилалт хийсний үр дүнд Үндэсний спортын VI их наадамд Булган аймгийн баг тамирчид хүрэл медаль хүртлээ. 2018 оны Шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж 160 гаруй харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдсөн. ЕБС-ийн сурагчдын дунд Шагайн харвааны секц дугуйланг хичээллүүлэн сургалт сурталчилгааны ажлыг явуулж байна. Мөн аймгийн шагайн холбоотой хамтран ААШТэмцээн, Хангинахын шугуйн шагайн тойром, нэрэмжит тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулж	100

							байна.	
	70	1.3.1.4. Ерөнхий боловсролын сургуулиудад Олимпийн сургалт, сурталчилгааны танхимуудыг байгуулан, үзүүлэн таниулах материалаар үе шаттай хангах	2016-2020	АЗДТГ, НБХ БТСГ, ЕБС, “Москва” олимпийн зөвлөл	Өөрсдийн нөөц бололцоогоор сургууль тус бүр 723 000 төгрөг нийт 5 784 000	Хүүхдүүдийн спорт Олимпизмийн мэдлэг зохих түвшинд дээшилсэн байна.	Аймгийн хэмжээнд “Москва” олимп судлалын төв тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна. Сум болон сургуулиудад Олимпийн танхимын үйл ажиллагааг идэвхжүүлж, хүүхэд багачуудад Олимпизмийн үзлийг сурталчлан ажиллах чиглэл хүргүүлсний дагуу Булган сумын ЭӨЦС, СДС, 1-р сургууль, БТСГ, Гурванбулаг, Рашаант, Орхон сумд, Хялганат тосгон өвөл, зуны Олимпийн самбаруудыг шинээр авч олимпийн танхимаа тохижуулан өргөжүүлсэн байна. "Олимпизм ба бие бялдрын хүмүүжил" сэдэвт уралдааныг аймгийн хэмжээнд 2017.12.20-2018.05.20-ны хооронд зохион байгуулж Булган аймгийн "Москва" олимпийн зөвлөл, БТСГ, БСУГ-ын дарга нар хамтран ажиллах гэрээ байгуулан уралдааныг дүгнэж I байранд Хангал сумын Хялганат тосгоны “Сайханы Хульж” олимпийн танхим шалгарч материалыг МҮОХ-д хүргүүлсэн. Хангал сумын Хялганат тосгоны ЕБС-ийн Олимпийн танхим 2017 оны ажлын үзүүлэлт, өрөө танхимын тохижилт, сургалт сурталчилгааны ажлаараа МҮОХ-ны “Бөртэ чоно” шагналаар шагнагдсан байна. 2018 оны 3 дугаар улирлаас БТСГазарт Олимпийн танхим өрөө тасалгааг шинэчлэн зохион байгуулж, үйл ажиллагаагаа сурталчлан ажиллаж байна.	100
/15/ 1.3.2. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх таатай орчин нөхцлийг бүрдүүлнэ.	71	1.3.2.1. Аймаг, сумын төвүүдийн гудамж, нийтийн эзэмшлийн талбайд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд залуучуудад зориулсан ногоон байгууламж бүхий гүйлт, дугуйн зам, спорт тоглоом, мөсөн гулгуурын талбай байгуулах ажлыг эхлүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, Булган СЗДТГ ГХБХБГ БТСГ	Улсын төсөв 3 896 100 төгрөг	Өвлийн спортын тэмцээн, нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулсан байх Ард иргэдийн нийтийн биеийн тамираар чөлөөтэй хичээллэх боломж бүрдсэн	Хүүхэд, залуучууд, иргэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэмцээн уралдааныг зохион байгуулах тал дээр анхаарч жил бүр өвлийн улиралд Төв цэнгэлдэх хүрээлэнд 400 метрийн мөсөн гулгуурын талбайг байгуулан олон нийтийг хамарсан үйл ажиллагааг явуулж байна. Мөн 14 сум ногоон байгууламж бүхий спорт тоглоомын гадна талбайг шинээр байгуулан, хуучин талбайг засварлаж хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Булган сумын ахмад Волейболчдын тэмцээнийг 3 дугаар сургуульд зохион байгуулж 7 багийн 60 гаруй ахмад тамирчид оролцлоо. Мөн ахмадуудыг идэвхтэй хөдөлгөөнд хамруулан “Биеэ тэтгэн чийрэгжүүлэх” хийн дасгалаар хичээллэх өрөө танхимыг гарган өгч дэмжин ажиллаж байна. Ахмад мастеруудын спортын УАШТэмцээнийг амжилтай зохион байгуулан явууллаа. Төв цэнгэлдэх хүрээлэнд хөл бөмбөгийн	70

						байна.	талбай болон 4 замтай 400 метрийн гүйлтийн асфальтан замтай болсноор нийтийг хамарсан уралдаан тэмцээн тогтмол зохион байгуулагдаж байна.	
	72	1.3.2.2. Хүн амыг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх, эрүүл амьдралын дадал, хэвшилд сургах чиглэл бүхий нийтийн биеийн тамирын сайн дурын танхим, клуб, хамтлагуудыг дэмжиж ажиллах	2016-2020	АЗДТГ, НБХ, БТСГ, Агентлагийн удирдлага, СЗДТГ	-	Албан байгууллагын ажиллагсдын идэвх санаачлага нэмэгдэж эрүүл амьдралын дадал, хэв маяг хэвшсэн байна.	Аймгийн хэмжээнд сум, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд биеийн тамир, спортын хамтлаг байгуулах дүрэм журмыг хүргүүлэн хамтлаг, клубын судалгааг гаргаж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг БТСГазарт 02 дугаар сард хүргүүлсэн. Судалгаагаар аймгийн хэмжээнд спортын хамтлаг 36, клуб 5, товчоо 1, нийт 42 хамтлаг байгуулагдан биеийн тамир, спортыг сурталчлан, ажиллагсдын эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаа, тэмцээн уралдаан, сорил судалгааг авч хамтран ажиллаж байна. Нийтийн биеийн тамир, спортыг бүх нийтийн хүртээл болгон, багийн болон ажилгүй иргэдийг татан оролцуулах зорилгоор анх удаа Монгол улсын Ерөнхий сайдын нэрэмжит “Иргэдийн спортын их наадам”-ын анхан шатны тэмцээнийг аймгийн хэмжээнд 14 сум 1 тосгонд спортын 5-н төрлөөр зохион байгуулж, 2901 иргэн, шигшээ тэмцээнд 12 сумын 656 иргэн оролцож наадамд нийт 3557 иргэнийг хамрууллаа. Анхан шатны тэмцээнд ажилгүй 720 иргэн, шигшээ тэмцээнд 169 иргэн, нийт 889 ажилгүй иргэн оролцсон байна. Иргэдийн спортын их наадам нь орон нутгийн иргэдийн спортод хандах хандлага, идэвхийг нэмэгдүүлж, спортоор хичээллэх дур сонирхлыг төрүүлж нийтийн биеийн тамирыг дэмжсэн томоохон ажил боллоо.	100
/16/ 1.3.3. Спортын тодорхой төрлүүдийг /үндэсний сур, цана, тэшүүр, бөхийн төрлүүд, волейбол, хөнгөн атлетик, бокс, буудлага, таеквандо, сагсан бөмбөг г.м/ түлхүү хөгжүүлнэ.	73	1.3.3.1. Үндэсний наадгай сур харвааг хөгжүүлэх зорилгоор “Монгол нум сум” хөтөлбөр хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, БТСГ, БСУГ	Орон нутгийн хөгжлийн сан 11 550 000 Сурын холбоо 22 350 000 Нийт 33 900 000	Эрийн гурван наадмын нэг үндэсний наадгай сурын харвааг хөгжүүлж, хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна.	“Монгол нум сум” дэд хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор 2017 онд 400, 2018 онд 538 сонирхон хичээллэгч үндэсний сурын харваагаар хичээллэж байна. 2018 онд Соёл амралтын хүрээлэнд “Үндэсний сурын харваа”-ны стандартын талбай ашиглалтад орж тэмцээн уралдаан, сургалт амжилттай явагдаж байна. Монголын үндэсний сурын холбооноос хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт Булган аймгийн Үндэсний сурын холбоо хамрагдаж 14 суманд ажиллах төлөвлөгөө гарган сумдад сургалт хийж Нум 4 ш, сум 20 ш, агсуурга 2 ш, эрхийвч 5 ш, хасаа 1 ком, гарын авлага 4 ш нийт 22350000 төгрөгийн хэрэглэл материалаар хангалаа. Мөн	100

						аймгийн хэмжээнд сурын холбоотой хамтран өвлийн улиралд зааланд Олимпын төрөл байт харвааг хөгжүүлэх зорилгоор хэрэглэл материалыг авч бэлэн болгож үндэсний сурын харвааны сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Үндэсний спортын VI их наадмын хүрээнд “Хангинахын шугуйн шагайн тойром”-ыг Сурын харваа, Шагайн харваан төрлөөр Хутаг-Өндөр сумын “Гуртын хөтөл”-д зохион байгууллаа. Тэмцээнийг Үндэсний сур, Буриад сур, Уламжлалт сур, Урианхай сурын харваан төрлүүдээр зохион байгуулж, Спортын мастер 3, спортын дэд мастер 1, Урианхай сурын спортын мастер 1, спортын дэд мастер 1, Аймгийн мэргэн 5, Сумын мэргэн 7, нийт 6 багийн 48 харваачид оролцлоо.	
74	1.3.3.2. Шагай харвааг хөгжүүлэхийн зэрэгцээ түгээн дэлгэрүүлэх холбоо, багуудыг дэмжиж ажиллах	2016-2020	АЗДТГ, НБХ, БТСГ, БСУГ	ОНТөсөв 12 130 000	Шагай харвааг хөгжүүлж, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлж, Хангинахын шугуйн шагайн тойрмын хамрах хүрээг тэлж улмаар жуулчдын анхаарлыг татсан эвент арга хэмжээ болгосон байна	Монголын үндэсний спортын VI их наадмын хүрээнд өвлийн спортын төрөл мөсний шагай, мөсний сурын харвааг аймгийн хэмжээнд 02 дугаар сард зохион байгуулж, шалгарсан тамирчид шигшээ тэмцээнд амжилттай оролцлоо. Булган аймгийн шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээн Булган суманд 2018 оны 05 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулагдаж нийт 20 багийн 160 харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. Аймгийн Шагайн холбоо, БОАЖГазартай хамтран “Хангинахын шугуйн шагайн тойром”-ыг Хутаг-Өндөр сумын Гуртын хөтөлд 5 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, Булган, Архангай, Дархан-Уул, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн 35 багийн 307 харваачид багийн харваа, цуваа харвааны төрлөөр оролцлоо. Үндэсний спортын VI их наадмын хүрээнд Ширээний шагайн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Булган суманд зохион байгуулж 14 багийн 60 гаруй тамирчид ширээний шагай, морь уралдуудах, шүүрэх, няслах зэрэг төрлүүдээр оролцож, тус тэмцээнээс шалгарсан баг тамирчид шигшээ тэмцээнд оролцлоо. Аймгийн хэмжээнд Хялганат тосгон, Булган, Хутаг-Өндөр, Сайхан сумдад шагайн клубүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулж шагайн спортыг сумын хэмжээнд сурталчлан ажиллаж байна. Үндэсний спортын VI их наадмыг зохион байгуулахад аймгийн Засаг даргын нөөцөөс 9.0 сая төгрөгийг зарцууллаа. Шагайн харвааг хөгжүүлэх тал дээр анхааран холбооны үйл ажиллагааг дэмжин тусалж ажиллахын зэрэгцээ	100

						БТСГазарт шагайн харвааны заалыг тохижуулан тогтмол бэлтгэл сургуулилалт хийсний үр дүнд Үндэсний спортын VI их наадамд Булган аймгийн баг тамирчид хүрэл медаль хүртлээ. 2018 оны Шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж 160 гаруй харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдсөн. Аймгийн гоц мэргэн Д.Галбадрах ЕБС-ийн сурагчдын дунд Шагайн харвааны секц дугуйланг хичээллүүлэн сургалт сурталчилгааны ажлыг явуулж байна. Мөн үндэсний сурын нээлтийн харваа буюу цайт сурын харваа, Хаалтын харваа буюу Отго харвааг жил бүр аймгийн хэмжээнд уламжлал болгон зохион явуулж хэвшээд байна. 2018 оны 04 дүгээр сард аймгийн хэмжээнд “Цайт сурын харваа” буюу хаврын анхны нээлтийн үндэсний сурын харвааг насанд хүрэгчдийн дунд зохион байгуулж нийт 33 харваач цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Отго харваа-2018” үндэсний сурын харвааны тэмцээнийг өсвөр үе, насанд хүрэгчид гэсэн насны ангиллаар зохион явуулж Орхон, Хангал, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Бугат, Баян-Агт, Дашинчилэн, Булган сумд, Хялганат тосгоны 79 харваач цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. Тэмцээнд аймгийн мэргэн, спортын мастер 4 /Д.Галбадрах, Д.Мөнхдорж, М.Лхагвасүрэн, Б.Баярцэцэг/, аймгийн мэргэн, спортын дэд мастер 2 /Л.Энхзул, С.Шижир/, аймгийн мэргэн 1 /Б.Цэнгэлмаа/, аймгийн гарамгай харваач 1 /М.Мөнхбаатар/ оролцсон байна. Тэмцээнд өсвөрийн харваач нийт 43 /хөвгүүд 24, охид 19/, насанд хүрэгчид нийт 36 /эрэгтэй 23, эмэгтэй 13/ оролцож нас тус бүрт эхний 5 байрыг шалгарууллаа.	
75	1.3.3.3. Цана, тэшүүр, бөхийн төрлүүд /самбо, жудо, чөлөөт, үндэсний бөх г.м / гар бөмбөг, сагсан бөмбөг, бокс, буудлага, хөнгөн атлетик, таеквандо, ширээний теннис зэрэг спортыг түлхүү хөгжүүлэх чиглэлээр дэмжих	2016-2020	АЗДТГ, НБХ, БТСГ, Спортын холбоод	ОНТөсөв, Төсөл, Хөтөлбөр 28 500 000	Орон нутгийн брэнд төрлүүд болон хөгжсөн байна.	Өсвөрийн шигшээ багийг спортын 8 төрлөөр шинээр байгуулахаар тамирчин, дасгалжуулагч нарын мэдээлэл, төсөв хөрөнгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 11 төрлөөр зохион байгуулж 3504 тамирчид хамрагдан, шалгарсан тамирчдыг шигшээ тэмцээн, улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд дэмжин оролцуулж Азийн аварга, Олон улс, улс, бүс, олон хотын тэмцээн уралдаанд спортын холбоодтой хамтран ажиллаж тамирчид дараах амжилтуудыг үзүүлсэн байна. Үүнд:	

							Цанын өсвөр үеийн УАШТ-нд I баг багаараа II байр, II баг багаараа III байр, тэшүүрийн ӨҮУАШТ-нд 1-р баг I байр, 2-р баг II байр, хөнгөн атлетикийн ӨУАШТ-нд багаараа III байр, Хөдөөгийн хүчтэн төвийн бүсийн үндэсний бөхийн барилдаанд багаараа I байр, Кик боксын УАШТ-нд III байр, Пауэрлифтингийн ӨҮУАШТ-нд багаараа I байр, гандболын бага насны УАШТ-нд III байрыг тус тус эзэлсэн амжилттай байна. Аймгийн хэмжээнд ГБХЗХГ, ОБГ-ын зааланд бокс, волейболын шигшээ баг тамирчдын бэлтгэл сургуулилтаа хийх орчин нөхцөлийг бүрдүүлэн хамтран ажиллаж байна. Мөн сүүлийн жилүүдэд шинэ тутам хөгжиж байгаа пауэрлифтинг, гандболоор сонирхон хичээллэгсдийн тоо нэмэгдэж УАШТ-нд амжилттай оролцож байна. “Булган марафон” бүх нийтийн гүйлтийн тэмцээнийг 2 жил амжилттай зохион байгуулж, 2018 оноос тус тэмцээнийг нээлттэй зохион байгуулснаар бусад аймгаас оролцох тамирчдын тоо нэмэгдэж, улсын чанартай тэмцээн болон өргөжиж байна. 10 дугаар сарын 27-ноос 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд Булган аймагт Монгол улсын Ардын багш, Монгол улсын Гавьяат дасгалжуулагч, Академич, Профессор, Олон Улсын Хэмжээний Мастер Д.Банди агсаны нэрэмжит 2018 оны Бага насны боксчдын Улсын аварга шалгаруулах “Олимпийн Гараа” тэмцээнийг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулж 39 багийн 363 өсвөрийн боксчид оролцлоо.	100
/17/ 1.3.4. Спортын салбарын материаллаг баазыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	76	1.3.4.1. Спортын шинэ ордны дээвэр, халаалтын иж бүрэн засварыг хийж гүйцэтгэх	2016-2020	БСШУС Я АЗДТГ, НБХ, БТСГ	Улсын төсвөөс 523 000 000 төгрөг	Улсын комисс хүлээн авсан акт гаргуулсан байна.	Спорт ордны их засварын зардлыг шийдүүлэх талаар БСШУСЯаманд уламжлан 2017 оны төсвийн тодотголоор оруулж засварын зардлын 70 хувийг шийдүүлж, 2018 онд засварын ажлыг Орхон аймгийн “Борхууд” компаниар 100 хувь гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авч спортын арга хэмжээнүүд явагдаж байна.	100
	77	1.3.4.2. Хялганат тосгоны спорт заалыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг хэвийн явуулах боломжоор хангах	2016-2020	АЗДТГ, НБХ, СЗДТГ	-	Хялганат тосгоны ард иргэд нийтийн биеийн тамираар хичээллэх таатай орчин	Хангал сумын Хялганат тосгоны спортын цогцолборын барилгыг 2017 оны 12 дугаар сард ашиглалтад хүлээн авч үйл ажиллагааг явуулж байна. Тус цогцолборыг аймгийн ИТХТ-ийн 2018 оны 42 дугаар тогтоолоор Биеийн тамир, спортын газрын харьяанд шилжүүлж, 2018 оны төсвийн тодотголыг ИТХТ-р хэлэлцүүлэхээр болоод байна.	100

						нөхцөлтэй болсон байна.		
	78	1.3.4.3. Спортын ордны Б заалны их засварыг хийх	2016-2020	АЗДТГ, НБХ, СЗДТ	Улсын төсвөөс 9 139 190	Орчин, нөхцөл сайжирсан байна.	Спортын “Б” заалны засварын ажил 2017 онд бүрэн хийгдэж дууссан бөгөөд ажилчдын хүчээр заалны бүх цонхыг вакум болгосон. Урсгал засварт нийт 9139190 төгрөгийг зарцуулаад байна.	100
	79	1.3.4.4. Спортын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үе шаттай нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, СЗДТ	Хандив тусламж- 30 200 000 төгрөг Засаг дарын нөөцөөс 3 600 000 төгрөг	Спортын секцүүдийн үйл ажиллагаа сайжирч, хичээллэгсдийн тоо өсч, спортод гаргах амжилт ахисан байна.	Монголын сагсан бөмбөгийн холбооноос 30 000 000 төгрөгийн үнэ бүхий сагсан бөмбөгийн иж бүрэн шийдийг суурилуулсан. Таеквондогийн хичээллэгчдэд хандиваар өмсгөл хувцас-20ш /тобо/, цана тэшүүрийн өвлийн гадуур хувцас /комбинзон/, зэрэг спортын төрлүүдэд тоног төхөөрөмж, хэрэглэл материалыг авч тамирчдын хичээллэх орчин нөхцөлийг сайжруулсан.	70

1.4 Соёл, урлаг

Үндэсний өв уламжлал, орчин үеийн дэвшилтэт соёлыг шингээсэн иргэдийг төлөвшүүлж, урлаг, гоо зүйн боловсролыг дээшлүүлэн, соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин өргөжүүлнэ.

/118/ 1.4.1. Соёл урлагийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, соёлын үйлчилгээг шинэ шатанд гаргаж, Соёл урлагийн ажилтнуудыг сургах, давтан сургах ажлыг ээлж дараатай зохион байгуулах, мэргэжлийн урлагийн байгууллагуудын мэргэжилтэй боловсон хүчнийг нэмэгдүүлнэ.	80	1.4.1.1. Аймгийн “Соёл, урлагийн бодлого”-ыг боловсруулж, хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ	-	Соёл, урлагийн бодлого хэрэгжиж орон нутгийн түвшинд соёлын чиг хандлага тодорхойлогдож, соёл урлагийн үйлчилгээ шинэ шатанд хүрсэн байна	Соёл урлагийн байгууллагуудын боловсон хүчний хангалт 2016 онд 47 хувьтай байсан бол 2018 оны байдлаар 53 хувь болсон үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд 2016-2020 онуудад ардын уламжлалт урлагийг хөгжүүлэх, соёл урлагийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлийг баримтлан ажиллаж байна. Мөн мэргэжилтэй боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэх чиглэл барьж ОХУ-ын Улан-Үдэ хотын урлагийн сургуульд хүүхдүүд сургаж 2018 онд 35 хүүхэд суралцаж байна. Тус сургуульд суралцсан хүүхдүүдийн эхний төгсөлт энэ оны хавар сургуулиа дүүргэж 2 мэргэжилтэй боловсон хүчин Булган сумын соёлын ордноос ажлын гараагаа эхлүүлээд байна. Булган сумын соёлын ордны хөгжмийн багш Алимаа энэ онд нийтийн цэнгээнт бүжгийн багшийн сургалтад, аймгийн ХЖТ-ын бүжигчин Ш.Билгүүн БСШУСЯ, СУИС, Бүжигчдийн холбооноос хамтран зохион байгуулсан бүжиг дэглээч мэргэжил дээшлүүлэх сургалтад, гэрэлтүүлэгч	70
--	----	---	-----------	------------------	---	---	--	----

						Энхтулга УДЭТ-т мэргэшүүлэх, техникийн ажилтан Хүрэлсүх лед дэлгэц, компьютер графикийн сургалтад тус тус хамрагдаж мэргэшсэн байна. Номын сангийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтад Төв номын сангийн ажилтан Мөнгөнтүяа, Отгончимэг, Энхбилэг, Баян-Агт, Дашинчилэн, Сайхан, Бугат сумдын соёлын төвийн номын санчид, Хутаг-Өндөр, Сайхан сумд, Хялганат тосгоны сургуулийн номын санчид хамрагдаад байна. СУИС-ийн Соёлын дээд сургуульд аймгийн Төв номын сангийн 3 ажилтан, Хутаг-Өндөр, Сайхан сумдын сургуулийн номын санчид номын санчийн мэргэжил эзэмшихээр, Бугат сумын соёлын төвийн эрхлэгч соёлын менежерийн чиглэлээр тус тус суралцаж байна. Аймгийн ХЖТ-ын уран бүтээлчид “Сонгодог урлаг-2018” улсын уралдаанд оролцож хөгжмийн багш МУСТА П.Эрдэнэбулган “Шилдэг хөгжмийн зохиолч”, бүжигчин Г.Мөнхтуул, Ж.Алтангэрэл нар “Шилдэг туслах” дүрүүдээр шалгарч бүжигчин Ж.Алтангэрэл МУСТА, Бүжигчин Ш.Билгүүн БСШУСЯамны “Жуух бичиг”-ээр тус тус шагнагдан салбарын хэмжээнд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлээд байна.	
81	1.4.1.2. Сумдын соёл, урлагийн өдрүүдийг тогтмол зохион байгуулж, урлаг соёлын үйлчилгээ, эд өлгийн зүйл, сум орон нутгийн онцлогийг харуулсан үзэсгэлэн гаргах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ Сумдын ЗДТГ	ОНТөсө в 2 500 000	Сум, орон нутгийн бусдаасаа ялгарах онцлогийг харуулж, орон нутгаа сурталчлах, сумдын соёлын брэнд бүтээгдэхүүн ийг тодорхойлно.	Ардын Хатанбаатар Магсаржавын мэндэлсний 140 жилийн ойг тохиолдуулан 2018 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Хутаг-Өндөр сумын ЕБС-ийн 820 хүүхдийн “Баатар вангийн хүүхдүүд” урлагийн тоглолтыг Булган сумын төв талбайд зохион байгууллаа. Тус тоглолтын үеэр сургуулийн багш сурагчдын бийрэн бичлэгийн үзэсгэлэнг олон нийтэд толилуулж, анги хамт олноороо ардын бүжиг бүжиглэх, дуулах зэрэг үзүүлбэрийг үзүүлсэн нь хүүхэд нэг бүрийн авъяас чадварыг нээн хөгжүүлсэн ажил байлаа. Мөн Хутаг-Өндөр сум аймгийн Музейтэй хамтран Ардын Хатанбаатар Магсаржавын эдэлж хэрэглэж байсан үзмэр эд өлгийн зүйлээр 2 удаа үзэсгэлэн гаргаж нийтэд толилуулсан. 2018 оны 8 дугаар сард Улаанбаатар хотын Хүй долоон худагт болсон “Нүүдэлчин Монгол” соёлын өвийн анхдугаар наадамд 16 сум, 1 тосгоныхоо соёлын онцлогийг харуулсан ардын урлаг, тоглоом наадгайгаар амжилттай оролцоод байна.	70

	82	1.4.1.3. Аймгийн “Ардын урлагийн наадам”-ыг 2 жил тутам зохион байгуулж, шилдэг уран бүтээлүүдийг олон нийтийн хүртээл болгох	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ	-	Булган нутгийн уран бүтээлчдийн бүтээл олон нийтэд танигдсан байна.	Аймгийн “Ардын урлагийн наадам”-ыг 2017 онд зохион байгуулж, шилдэг уран бүтээлүүдийг олон нийтийн хүртээл болгосон. Тус наадмаас шалгарсан ардын авъяастнууд 2018 оны 8 дугаар сард “Нүүдэлчин Монгол” наадамд амжилттай оролцсон бөгөөд тус наадмыг 2019 онд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	100
	83	1.4.1.4. Амьд хөгжмийг сурталчлах, дэлгэрүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, Булган СЗДТГ, Булган сумын Соёлын ордон	-	Амьд хөгжмөөр хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулиуд бишгүүр хөгжмийн боловсролыг хүүхэд бүхэнд эзэмшүүлэхээр сургалт үйл ажиллагааг явуулж хэвшээд байна. Булган сумын Соёлын ордон нь амьд хөгжмийн сургалтыг 7 хоногт 3 өдрөөр тогтмол хичээллүүлж 2018 оны байдлаар 27 хүүхэд, 10 гаруй насанд хүрэгчид хамрагдаж байна. Амьд хөгжмийг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд оюутны 4 хамтлаг, бага болоу дунд ангийн 2 хамтлаг, насанд хүрэгчдийн 2 хамтлаг тус тус байгуулагдаж Тэшиг, Баян-Агт сумдад амьд хөгжмийн тоглолтоо зохион байгууллаа.	100
	84	1.4.1.5. Гадаад улсын Элчин сайдын яамдтай хамтран, тухайн орны урлаг, соёл, кино өдрүүд зохион байгуулах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ Булган СЗДТГ, Булган сумын Соёлын ордон	-	Соёлын үйлчилгээний төрөл, чанар нэмэгдэнэ.	Аймгийн Хөгжимт жүжгийн театр, Номын сан, Булган сумын соёлын ордны ажилтнууд 2018 оны 09 дүгээр сард ОХУ-ын Буриад улсын Улан-Үдэ хотын дуурийн театр, номын сан, соёлын сургуулиудад туршлага судалсан. “Ялалтын баяр”-т зориулсан “День победы” тоглолтыг ОХУ-ын Буриад улсын Улаан-Үдэ хот, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудаар аялан тоглож олны хүртээл болгосон ба ОХУ-ын Буриад улсын Улан-Үдэ хотын соёлын сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд тус сургуульд сурч буй оюутан, багш нарын хамтарсан “Трубадор ба түүний нөхөд” дуулалт жүжгийг орос хэл дээр тавьж үзэгчдийн хүртээл болгосон.	70
/19/ 1.4.2. Соёлын байгууллагуудын материаллаг баазыг сайжруулах, зарим сумдын Соёлын төвүүдийг шинээр барих, их засвар хийх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шат дараатай нэмэгдүүлнэ.	85	1.4.2.1. ХЖТ, аймгийн Төв номын сангийн шинэ барилгын асуудлыг шийдвэрлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ	-	Аймгийн Хөгжимт жүжгийн театр, Номын сан орчин үеийн стандартад нийцсэн барилгатай болж,	Номын сангийн өргөтгөлийн барилгын зураг төсвийг 2013 онд хийлгүүлж бэлэн болгосон боловч хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй. Зураг төсвийн хугацаа дуусч 2017 онд зургийг шинэчилсэн. Аймгийн Хөгжимт жүжгийн театрын шинэ барилгыг барих асуудлаар холбогдох яамдад саналаа удаа дараа хүргүүлж, зураг төсөв хийлгэх хөрөнгийг 2019 оны төсвийн төсөлд тусгуулахаар санал хүргүүлээд байна.	40

						үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж, үйлчилгээнд чанарын ахиц гарсан байна.		
	86	1.4.2.2. Аймгийн музейн барилгад өргөтгөл, шинэчлэл хийж, Баруун замын тусгай ангийн штаб-музейн барилга, Ардын Хатанбаатар С.Магсаржавын дуулгат бунхныг засварлаж, тохижуулах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн музей	ОНТөсө в 105.4 сая	Музейн үйл ажиллагаа явуулахад таатай орчин бүрдэж үйлчлүүлэгчдийн тоо эрс нэмэгдсэн байна.	Аймгийн 80 жилийн ойг угтаж Музейн үзмэр дэглэлтийг шинэчлэх ажлыг хийхэд барилгын дээвэр, хана, таазанд засвар хийх шаардлагатай болсон тул орон нутгийн 105.4 сая төгрөгөөр үзмэр дэглэлт, засварыг хийсэн. Ардын Хатанбаатар Магсаржавын дуулгат бунханд байгууллагын хөрөнгөөр будаг болон хаалга цонх хийсэн.	70
	87	1.4.2.3. Баяннуур сумын “Шороон бумбагар”-ын бунхант булш, ханын зургийг хамгаалах сэргээн засварлах, Баян-Агт сумын Шивээт-Улааны түүхийн дурсгалт газрыг аялал жуулчлалын төв болгох	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ Аймгийн музей	-	Түүх соёлын үнэт олдворыг олон нийтэд таниулж, орон нутгаа сурталчилсан байна.	Майхан уулын “Шороон бумбагар” археологийн дурсгалыг хадгалж хамгаалах, тогтвортой менежмент бий болгоход боловсон хүчнийг чадавхжуулах, олон нийтийн ухамсарыг нэмэгдүүлэх төслийг ЮНЕСКО/МОНАКОГ-ийн итгэлцлийн сангийн дэмжлэгтэйгээр Туркийн ТИКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар эрчим хүчний шугам татсан, сэргээн засварлах ажил үргэлжилж байна. Баяннуур сумын Майхан уулын “Шороон бумбагар”-ын бунхант булш, ханын зургийг хамгаалах, сэргээн засварлах ажил БСШУСЯ, Соёлын өвийн төвийн удирдлага дор хийгдэж байна.	70
	88	1.4.2.4. Хялганат тосгон, Баяннуур, Могод, Гурванбулаг, Хангал, Бугат, Хутаг-Өндөр сумдын соёлын төвд их засвар хийх	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ	247.1 сая	Соёл, урлагийн үйлчилгээг таатай орчинд хүргэж, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна	2017 онд Могод сумын Соёлын төвийн барилгын их засварыг улсын төсвийн 140.0, орон нутгийн 67.4, нийт 207.4 сая төгрөгийн өртгөөр Улаанбаатар хотын “Элэг бүс” ХХК-иар гүйцэтгүүлж, ашиглалтад хүлээн авсан. Баяннуур, Гурванбулаг сумдын соёлын төвийн дээврийн засварыг Боловсрол, соёл урлагийн газар болон орон нутгийн төсвөөс 23.7 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж хийлгэлээ. Хутаг-Өндөр сумын соёлын төвийн халаалтын системийг 16.0 сая төгрөгөөр шинэчилсэн хэдий ч Хутаг-Өндөр суманд болсон үерийн гамшгийн улмаас шал нь хөндийрч, доороосоо мөөгөнцөрдөж яаралтай засвар үйлчилгээ хийх шаардлагатай болоод байна.	100

	89	1.4.2.5. ХЖТ, Номын сан, Соёлын төвүүдийг камержуулах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, АТНС	-	Аюулгүй орчинг бүрдүүлсэн байна.	Аймгийн Хөгжимт жүжгийн театр болон аймгийн Төв номын сангийн уншлагын танхимыг 2017 онд камержуулсан. Сумдын соёлын төвүүдийг 2019 онд камержуулахаар 40.0 сая төгрөгийн төсвийг ирэх оны төсөвт суулгахаар тооцоолоод байна.	40
	90	1.4.2.6. Соёлын төвүүдийг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр үе шаттайгаар хангах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, СЗДТГ	Хандив 8.0 сая	Сумдын соёл, урлагийн үйлчилгээ чанаржиж, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна.	"B sound" продакшны хандиваар Хутаг-Өндөр суманд өсгөгч 1 ш, тайзны гэрэлтүүлэг 3 ш, дипузер 2 ш, Могод суманд дипузер 2 ш, гэрэлтүүлэг 3 ш, нийт 8.0 сая төгрөгийн техник шинэчлэл хийлээ. Бүх соёлын төвийн хөгжим, техник хэрэгслийг шинэчлэхээр 110.0 сая төгрөгийг 2019 оны орон нутгийн төсөвт тусгуулахаар саналаа хүргүүлээд байна. "Уртын дуу-Морин хуур" дэд хөтөлбөрийн хүрээнд 2018 онд аймгийн Хөгжимт жүжгийн театрт 7.9 сая төгрөгийн үндэсний хөгжмийн зэмсэг авсан.	70
	91	1.4.2.7. Сумын номын сангуудад интернэт үйлчилгээг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, СЗДТГ	-	Үйлчилгээний таатай орчин бүрдсэн байна.	Сумын номын сангуудад интернет үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг бүрэн хийсэн хэдий ч, зарим сумдад интернэтийн хурдыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Бүх сумдад интернэтийн төлбөрийг орон нутгийн төсөвт нь тусгуулан ажиллаж байна.	100
120/ 1.4.3. Үндэсний уламжлал, өв соёлыг дэлгэрүүлж, музейн үзмэрийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх, түүх соёлын үл хөдлөх дурсгалын зүйлсийг хамгаалах, үзмэрийг гадаад, дотоодод сурталчлах ажиллагааг үйл зохион байгуулна.	92	1.4.3.1. Түүхийн дурсгалт газар, хөшөө дурсгалууд, хиргисүүр, булш бунханы хадгалалт, хамгаалалт, тохижилтыг стандартын дагуу хийж гүйцэтгэн, байнгын арчилгаатай болгох	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн музей	Байгаль хамгаалах сан 6.0 сая	Түүхийн дурсгалт газар, хөшөө дурсгалууд, хиргисүүр, булш бунханы хадгалалт, хамгаалалт сайжирсан байна.	Сумдад жилд 2-оос доошгүй Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг хашиж хамгаалах шаардлага, чиглэл хүргүүлэн ажиллаж байна. 2018 онд аймгийн Музей нь Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран 6.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр Дашинчилэн сумын Хар бухын балгас, Булган сумын Диваажингийн сүм, Зүүн түрүүний хүн чулуун хөшөө, Сэлэнгэ сум Далх банди хүн чулуун хөшөө, Баян-Агт Халтрын буган чулуун хөшөө, Хутаг-Өндөр Бий булгийн балгас, Бугат сум Бичигтийн хад зэрэг түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудад тэмдэг тэмдэглэгээ, хашаа, гэрэлтүүлэг хийсэн.	100
	93	1.4.3.2. “Уртын дуу, Морин хуур” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Уран нугаралт”-ыг сурталчлан, дэлгэрүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, СЗДТГ	ОНТөсөв 24 829 000	“Уртын дуу, Морин хуур” хөтөлбөр амжилттай хэрэгжиж хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна. Уран	“Уртын дуу-Морин хуур” дэд хөтөлбөрийн хүрээнд сумдад 21 сургагч багш бэлтгэгдсэн. Орхон, Хангал, Сайхан сумдууд сумандаа 2 дахь шатны сургалтыг зохион байгуулсан. Одоогоор уртын дууны сургалтад 120, Морин хуурын сургалтад 400 суралцагч тогтмол хамрагдаж байна. Сумдын морин хуурын сургагч багш нарын ур чадварыг дээшлүүлэх, аймгийн 80 жилийн ойн нээлт, хүндэтгэлийн концерт зэрэгт тоглогдох бүтээлүүдийг сургах зорилгоор төр төсвийн	100

						нугаралтаар хичээллэгсэд тэй болсон байна.	байгууллагын албан хаагчдад шат дараалсан сургалтыг зохион байгуулж ажилласан. Аймгийн 80 жилийн ойн нээлтийн үйл ажиллагаанд 80 морин хуурч, 80 уртын дуучин оролцсон. Улсын хэмжээнд 2 жил тутамд 1 удаа болох “Нүүдэлчин Монгол” наадамд уртын дууны төрлөөр Хангал сумын уртын дуучин Банзрагч оролцож алтан медаль хүртэн МУ-ын СТА цол тэмдгээр шагнууллаа. Мөн аймгийн Хөгжимт жүжгийн театрт уртын дууны дугуйлан 7 хоногийн 3 өдөр тогтмол хичээллэж эхлээд байна. Булган сумын Соёлын ордны дэргэд уран нугаралтын дугуйлан хичээллэж 2018 онд 31 хүүхэд тогтмол хамрагдаж байна. Уран нугаралтын дугуйлангийн сурагчид 2 дахь жилдээ хичээллэж байгаа бөгөөд 5 хамтлаг үүсэн амжилттай хичээллэж байна. Уран нугаралтын сурагчид 2018 онд “Авьяаслаг Монголчууд” шоуны 3 дахь шатны шалгаруулалтад амжилттай оролцож, “Булган хотын хавар”, “Булган хангайн хүүхдүүд” урлагийн наадамд тус тус тэргүүн байр эзэллээ.	
	94	1.4.3.3. Сумдын орон нутаг судлалын танхим, ЕБС-ийн түүхийн танхимын үзмэр, эд өлгийн зүйлийг тоолж баталгаажуулах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн Музей	-	Нэгдсэн санд бүртгэсэн байна.	Сумдын орон нутаг судлалын танхим, ЕБС-ийн түүхийн танхимын үзмэр, эд өлгийн зүйлийг тоолж баталгаажуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан, шаардагдах зардлын тооцоог 2017 онд төлөвлөсөн. Тооллогын ажлыг 2018 оны 11 дүгээр сарын 10-аас 2019 оны 03 дугаар сарын 10-ны хооронд багтаан хийх чиглэл БСШУСЯамнаас ирж, ажлын хэсгийг байгуулан, тооллого зохион байгуулах сургалтад хамрагдахад бэлтгээд байна.	70
	95	1.4.3.4. Аймгийн нутаг дэвсгэрт оршдог улс, аймгийн хамгаалалттай 36 дурсгалыг гадаад, дотоодод сурталчилсан ном, товхимол, газрын зураг, музейн танилцуулга /Монгол, Орос, Англи хэлээр/ хэвлэж сурталчлах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн Музей	-	Түүх соёлоо олон улсад сурталчлах таатай боломж бүрдсэн байна.	Аймгийн нутаг дэвсгэрт оршдог улс, аймгийн хамгаалалттай 36 дурсгалыг гадаад, дотоодод сурталчилсан ном, товхимол, газрын зураг, музейн танилцуулгыг монгол, орос, англи хэлэнд орчуулан хэвлэхээр эхийг бэлэн болгосон.	70
/21/ 1.4.4. Номын фонд	96	1.4.4.1. Бүх нийтээр	2016-	АЗДТГ,	-	Ард иргэдийг	Явуулын номын сан Хангал, Тэшиг, Могод,	100

баяжилтыг нэмэгдүүлж, сумдын номын сангуудын орчин нөхцлийг сайжруулан үйл ажиллагааг өргөжүүлнэ.		ном унших хөдөлгөөн өрнүүлэн, “Нүүдлийн номын сан”-гийн үйлчилгээг эрчимжүүлэх хөдөөгийн багт хувиараа номын сан байгуулах иргэдийг дэмжих	2020	НБХ, БСУГ АТНС		номтой нөхөрлүүлэх ажил эрчимжиж ном уншигчдын тоо нэмэгдсэн байна.	Гурванбулаг, Дашинчилэн, Бүрэгхангай сумдад 120 номоор, 13 суманд номын худалдаа, сум, сургуулийн номын сангуудад мэргэжил арга зүйгээр зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Аймгийн төвд "Аз хур" номын дэлгүүртэй хамтарч номын худалдааг 2018 оны 5 дугаар сард Цогтхунтайжийн талбайд зохион байгуулсан. Номын баярыг 9 дүгээр сард зохион байгуулж зохиолч Б.Шүүдэрцэцэг уншигчидтай уулзалт хийлээ. “Номч гэр бүл”, тэргүүний уншигч анги хамт олон, сурагч шалгаруулах, гэр бүлээрээ ном унших цаг, Номын хандивын үйл ажиллагааг тус тус зохион байгууллаа. ГБХЗХГ-тай хамтран байргүй байсан “Салбар номын сан”-ийн үйл ажиллагааг жигдрүүлж ойролцоох сургууль, байгууллагуудад номын сангийн үйлчилгээ хүргэж байна. ШШГГ онцгой дэглэмтэй хорих анги, ГХБХБГ, Булган сумын 3 дугаар сургууль, Цагдаагийн Газар, ЭӨЦС, 1, 2, 3, 4, 6 дугаар цэцэрлэгүүдэд зөөврийн номын санг ажиллууллаа. Мөн 13 сумын сургуулийн сурагчид, Булган сумын 1 дүгээр сургуулийн төгсөх ангийн сурагчдад “Электрон болон цаасан каталог хэрэглэх нь”, “Нийтийн номын сангуудаар үйлчлүүлэх нь”, “Сурахын төлөө”, “Дэлхийд алдартай номын сангууд” сэдвээр сургалт мэдээлэл хийж ажилласан байна.	
	97	1.4.4.2. Аймаг, сумдын номын сангийн фонд баяжилтыг үе шаттайгаар хангах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, СЗДТГ	ОНТөсө в 6 480 820	Уншигчдын тоо болон номын фонд баяжилтыг нэмэгдүүлсэн байна.	Мөн Булган сумын төвөөс 11 хүн 92 ширхэг ном бэлэглээд байна. 2018 оны 11 дүгээр сарын байдлаар 3164 уншигч, 8931 иргэдэд 13788 ном олгож үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн энэ онд 6 480 820 төгрөгийн фонд баяжилт хийгдлээ.	100

1.5 Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгаалал:

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нийгмийн халамж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгоход бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

122/ 1.5.1. Аймгийн нийгэм, эдийн засгийн бодлоготой уялдуулан шинэ залуу боловсон хүчнийг дэмжих,	98	1.5.1.1. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, ажил	2016-2020	АЗДТГ, НБХ, ХХҮГ, БСУГ, СЗДТГ	-	Мэдээллийн сан үүсгэн, салбар дундын хамтын	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр төсвийн байгууллага, хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгжийн судалгаа, эдгээр байгууллагад байгаа ажлын байр болон ажиллагсдын судалгааг гарган мэдээллийн сантай болсон. Аймгийн хэмжээнд үйл	100
--	----	--	-----------	-------------------------------	---	---	--	-----

төгсөгчдийг ажлын байраар хангасан хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.		олгогч, МСҮТ, их дээд сургууль төгсөгчдийн судалгааг гарган, нэгтгэн мэдээллийн сан үүсгэх				ажиллагаанд ашигласан байна.	ажиллагаа явуулж буй төр, төсвийн 122 байгууллагад 3131, 583 хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагад 1157 ажилтан албан хаагчид ажиллаж байна. МСҮТ-үүд 2016-2017 оны хичээлийн жилд 247 суралцагч төгссөнөөс 137 төгсөгч ажлын байраар хангагдсан байна. Үүнээс 90 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна.	
	99	1.5.1.2. Ажилгүй болон эмзэг бүлгийн иргэдийг МСҮТ, бусад бизнесийн төвүүдтэй хамтран, мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлээр сургах, ажилд зуучлах	2016-2020	ХХҮГ, МСҮТ, БСУГ, СЗДТГ	ХЭДС 11.0 сая	Ажил, мэргэжилгүй иргэдийн 80 гаруй хувийг тус чиглэлд хамруулан төгсөгчдийн 50-аас дээш хувийг ажлын байраар хангасан байна.	2016 оноос эхлэн НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага ойн тогтвортой менежментэд нүүрс төрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх нь төслийн хүрээнд 34 ойн нөхөрлөлийн гишүүдийг ойд арчилгаа хийх богино хугацааны сургалтыг 3 дахь удаа хамтран зохион байгуулж байна. Ажил олгогч эздийн холбоогоор дамжуулан төгсөгчдийг ажилд зуучлуулах ажлыг өрнүүлэн төгсөгчдөө ажлын байранд зуучлан ажиллаж байна. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 4 төслийг 11.0 сая төгрөгөөр дэмжин санхүүжилтийг олгоод байна. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох түр сургалтын захиалга 10 сумаас ирүүлсэн. Сумдаас ирүүлсэн захиалгыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн Сэлэнгэ суманд “Зөгийчин” бэлтгэх сургалтыг 18 иргэнд, Булган суманд “Тогооч”-ийн сургалтыг 9 иргэнд “Цэцэрлэгийн туслах багш”-ийн сургалтыг 13 иргэнд явуулж мэргэжил олголоо. Тус сургалтад хамрагдсан 40 иргэний 26 иргэн нь өөрөө өөртөө болон ажлын байранд зуучилж ажиллалаа. 11-р сарын 01-ний өдрөөс “Булган АЗЗА” ХХК-ны захиалгаар Булган, Дашинчилэн сумын 17 иргэнд “Хүнд машин механизмийн опретор” бэлтгэх сургалтыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	70
	100	1.5.1.3. МСҮТ-д суралцагсдын үйлдвэр дээрх дадлага хийх боломжийг нэмэгдүүлэх, сургалтын тоног төхөөрөмжийг	2016-2020	ХХҮГ, МСҮТ, БСУГ, СЗДТГ	Улс, ОНТөсө в, ХЭДС	Дадлага хийх орчин нөхцөлийг сайжруулж, 2 МСҮТ-ийн зарим техник тоног	ХАА-н МСҮТөв нь суралцагчдынхаа сургалт үйлдвэрлэлийн дадлагыг чанаржуулах тэднийг чадавхжуулах үүднээс сургууль дээрх дадлагын баазууд болох 2 хүлэмж, 0.3 га жимсний талбай, 0.5 га хүнсний ногооны талбай, бага оврын сүүний үйлдвэр дээрээ тулгуурлан зохион байгуулж байна. “ОЙСКА МОНГОЛ ТББ”-ын багш Н.Дарьсүрэн,	70

		шинэчлэх, багш нарыг давтан сургах, сургалтын хөтөлбөрийг сайжруулах				төхөөрөмжийг шинэчилсэн байна.	Х.Нэргүй нар Япон улсын Ниши-Нихон сургалтын төвд 45-аас 1 жилийн хугацаатай суралцаж Япон арга технологид суралцаад амжилттай төгсөж ирсэн. Үйлдвэр дээрх сургалт, мэргэжлийн болон давтан сургалтад нийт 78 иргэнийг хамруулахаар төлөвлөснөөс Булган сумын томоохон аж ахуйн нэгжүүд болох “Булган кашмер” ХХК, “Булган Мээж” ХХК, “Долоон бар” ХХК зэрэг 16 байгууллагад нийт давхардсан тоогоор 45 оюутан сурагчийг хамруулсан байна.	
	101	1.5.1.4. Шинээр байнгын болон түр ажлын байр бий болгосон ажил олгогчдыг дэмжих, хамтран ажиллах	2016-2020	ХХҮГ, МСҮТ, БСУГ, СЗДТГ	ХЭДС 105,0 сая	Жилд 10-аас доошгүй ажил олгогчийг дэмжин урамшуулал олгосон байна. Төгсөгчдийн 70-аас доошгүй хувь нь ажлын байраар хангагдсан байна.	Энэ онд хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн санд 6-аас дээш сараар ажил идэвхтэй хайж буй иргэнийг ажлын байраар хангасан “Өрнөх учралт” ХХК-тай ажил олгогчид олгох урамшууллын гэрээ байгуулан ажиллаж байна. МСҮТ-ийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр явагдаж буй Европын холбоо ТМБССД-2 төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй “Сурагчдын хоршоо”-г идэвхжүүлж цаашид дэмжин хамтран ажиллах чиглэлээр ажлын байртай болгоход чиглэнэ. Энэ онд ХЭДС-ийн “Жижиг зээл” олгох арга хэмжээнд /2017 оны зээлийн үлдэгдэл/ Булган, Сайхан, Хутаг-өндөр сумдын 6 аж ахуйн нэгжид 105.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна. 2018 онд аймгийн хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 600.0 сая төгрөгийн санхүүгийн эх үүсвэр хуваарилагдан ирсэн ба төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн хурлаар 753.5 сая төгрөгийн 57 төслийг судлуулахаар банк руу хүргүүлсэн. Өнөөдрийн байдлаар 3 төсөлд 50.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 7 иргэнийг байнгын ажлын байраар хангах гэрээг байгуулан ажиллаж байна.	70
/23/ 1.5.2. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоо, нөхөрлөл, өрхийн болон фермерийн аж ахуй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар ажлын байр бий болгон ажилгүйдлийг бууруулна.	102	1.5.2.1. Жил бүр 1500-аас доошгүй ажлын байр бий болгох	2016-2020	ХХҮГ, МСҮТ, СЗДТГ	Улс, ОНТөсөв, ХЭДС	6000-аас доошгүй ажлын байрыг бий болгож, хүн амын ажилгүйдлийг бууруулсан байна.	2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 2049 шинэ ажлын байр бий болсон байна. Үүнээс: 925 байнгын, 260 улирлын, 764 түр ажлын байр бий болсон байна. Нийт шинээр бий болж байгаа ажлын байрны 0.4 хувийг худалдаа үйлчилгээний салбар, 0.9 хувийг хөдөө аж ахуйн салбар, 21.4 хувийг барилгын салбар, 34.3 хувийг энгийн ажил мэргэжил шаардсан салбар 43.5 хувийг бусад салбар тус тус эзэлж байна	100
	103	1.5.2.2. Хоршоо,	2016-	ХХҮГ,	ХЭДС	Хоршоо,	“Шинэ хөдөө” төслийн хүрээнд 150 өрхөд үхрийн	100

		нөхөрлөл, фермерийн аж ахуй эрхлэх, хуримтлалын бүлэг байгуулахад дэмжлэг үзүүлэх	2020	ХХААГ, СЗДТГ, бусад төсөл хөтөлбөрийн байгуулл агууд	120,0 сая	нөхөрлөл, фермерийн аж ахуй эрхлэх, хуримтлалын бүлгүүдийн тоо, өрхийн амжиргаа, өрхийн орлого нэмэгдсэн байна.	нүдний суулгац олгож өрхийн орлого нэмэгдүүлэх дэмжлэг үзүүлсэн. Фермер эрхлэгчдийг дэмжих зорилгоор сургалт, семинар зохион байгуулах, судалгаа шинжилгээ хийх, төсөл хөтөлбөр боловсруулах чиглэлээр хамтран ажиллах гэрээг "Фермер хөгжлийн сан"-тай байгуулав. Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээг Хангал, Тэшиг, Сэлэнгэ, Дашинчилэн сумдад хэрэгжүүлэхээр төлөвлөн амьжиргааг дэмжих өрхөөр сонгогдсон болон ажил идэвхтэй хайж байгаа 40 иргэнийг бүлгийн зохион байгуулалтад оруулан 4.5 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж байна. ХЭДС-ийн "Жижиг зээл олгох" арга хэмжээний хүрээнд Сайхан сумын иргэн Г.Цэрэнгийн Үхрийн фермерийн аж ахуйн төслийг 20.0 сая төгрөгөөр дэмжсэн бол Хутаг-Өндөр, Рашаант сумдын 2 хоршооны төслийг 40.0 сая, Үхэр, гахайн фермер байгуулах 6 төслийг 60.0 сая төгрөгөөр дэмжүүлэхээр төслүүдийг банкуудад хүргүүлсэн. "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд "Хүлэмжийн аж ахуй", "Зөгийн аж ахуй", "Тахианы аж ахуй" эрхлэх чиглэлээр 5.5 сая төгрөг, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих" хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд "Шувууны аж ахуй", хүлэмжийн аж ахуй эрхлэх чиглэлээр 3 төслийг 4.5 сая төгрөгөөр тус тус дэмжин ажиллалаа.	
104		1.5.2.3. Орон нутгийн нөөц бололцоо, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн түр болон улирлын ажлын байраар хангах, ажилгүй болон ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажиллуулах, ажилд зуучлах	2016-2020	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ, бусад төсөл хөтөлбөрийн байгуулл агууд	ХЭДС 60,1 сая	Ажилгүй иргэдийн 50-аас доошгүй хувийг нийтийг хамарсан ажилд оролцуулж өрхийн орлогыг нэмэгдүүлсэн байна.	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээнд 56 төслийг 94.4 сая төгрөгөөр дэмжин 573 иргэнийг түр ажлын байраар хангахаас 38 төсөл арга хэмжээ хэрэгжиж дуусан байна. Эдгээр төсөл арга хэмжээнд 334 иргэн хамрагдан түр ажлын байртай болж цалин хөлсөнд 60.1 сая төгрөг зарцуулсан байна. Аймгийн 80 жилийн ойн бүтээн байгуулалтын хүрээнд зарласан тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүд орон нутгийн ажил олоход хүндрэлтэй болон эмзэг бүлгийн 53 иргэнийг түр ажлын байранд зуучлан ажиллуулж байна. 2018 онд нийт 1246 иргэнийг ажлын байранд зуучилснаас байнгын ажлын байр 664, улирлын ажлын байр 182, түр ажлын байранд 400 ажилгүй иргэн хамрагдсан байна.	100

105	1.5.2.4. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ, бусад төсөл хөтөлбөрийн байгууллагууд	ХЭДС 317,0 сая	Жижиг бизнес эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэн инкубатор төвийн тоог нэмэгдүүлсэн байна.	Жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэдэд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн жижиг зээл олгох арга хэмжээнд /2017 оны Жижиг зээлийн үлдэгдэл/ хамруулан 2018 онд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гаас Жижиг зээл олгох арга хэмжээнд 8 аж ахуйн нэгжид түүхий эд материал, тоног төхөөрөмж авахад зориулж 135.0 сая, хувиараа хөдөлмөр эрхлэгч 1 иргэнд 10.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Нийт олгогдсон зээлийн хүрээнд 10 ажлын байрыг хадгалж, шинээр 15 ажлын байрыг бий болгоод байна. “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-үүдийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд хувиараа хөдөлмөр эрхэлж буй 98 иргэнд 172.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон.	100
106	1.5.2.5. Нийгмийн зорилтот бүлгийн иргэдийг ногоон ажлын байраар хангах ажлыг зохион байгуулж, байгаль орчны чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрт хамруулах	2016-2020	ХХҮГ, ХХААГ, БОАЖГ, СЗДТГ, бусад төсөл хөтөлбөрийн байгууллагууд	ХЭДС 14,5 сая	Ойн нөхөрлөлийн тоо нэмэгдэж, орлого багатай өрхийн гишүүд ногоон ажлын байраар хангагдсан байна.	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээний хүрээнд Ногоон орчин бий болгох нөхөн сэргээх чиглэлээр 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж 93 түр ажлын байр бий болгон ажиллаж, иргэдийн ажлын хөлсөнд 14.5 сая төгрөг зарцуулсан байна. Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээг Хангал, Тэшиг, Сэлэнгэ, Дашинчилэн сумдуудад хэрэгжүүлэхээр төлөвлөн амьжиргааг дэмжих өрхөөр сонгогдсон болон ажил идэвхтэй хайж байгаа 40 иргэнийг бүлгийн зохион байгуулалтад оруулан 4.5 га талбайд төмс, хүнсний ногоо тариалуулж 40 улирлын ажлын байрыг бий болгосон. Эдгээр иргэд 29.5 тонн төмс, хүнсний ногоо хураан авсан байна	100
107	1.5.2.6. Баг бүрт 1.0-2.0 сая төгрөгний “Бичил зээл”-ийн эргэлтийн санг нэмэгдүүлэх, өрхийн бичил бизнесийг дэмжих	2016-2020	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ	“Бичил зээл”-ийн эргэлтийн сан буюу ОНХС 99,7 сая	Багийн иргэдийн амьжиргаа дээшилж, өөрийн гэсэн эргэлтийн хөрөнгөтэй болсон байна.	Аймгийн хэмжээнд нийт 230.8 сая төгрөгийн бичил зээлийн эргэлтийн сан бүрдсэнээс өнөөдрийн байдлаар 197 иргэнд 99.7 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлээд байна. Үүнээс 32.8 сая төгрөгийн зээл хугацаа хоцорч, төлөгдөөгүй байна. Зээлийн 70-80 хувь гэрээрээ өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэдэд дэмжлэг болгох чиглэлээр олгогдоод байна.	40

	108	1.5.2.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хуулийн дагуу урамшуулах	2016-2020	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ	ХЭДС, 2.8 сая	ХБИ-ийн орлого нэмэгдэж тэдний 40-50 хувь нь ажлын байраар хангагдсан байна.	2017 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангасан Сайхан сумын “Аргун номт” ХХК, Могод сумын “Эрхт түшиг” ХХК-тай ажил олгогчид олгох урамшууллын гэрээ байгуулсан. Гэрээний дагуу ХБИ-ийг тогтвортой ажлын байраар хангасан “Аргун номт” ХХК-д ажил олгогчийн урамшуулал 2.8 сая төгрөгийг олгосон. 2018 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангасан Сайхан сумын “Насандэлгэрэх” ХХК, Булган сумын “Оргил мээж” ТТБ-тай ажил олгогчид олгох урамшууллын гэрээг байгуулан ажиллаж байна.	70
	109	1.5.2.8. Иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор тэдний хийсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж, худалдан борлуулах цэгийг байгуулах	2016-2020	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ	Улс, ОНТөсөв, ХЭДС,	Бүтээгдэхүүнийг худалдан борлуулах цэг бий болж, үйл ажиллагаа нь эрчимжсэн байна.	Төсөл хөтөлбөрүүдэд хамрагдан санхүүгийн дэмжлэг авсан болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн хийсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, худалдан борлуулах зорилгоор “Булганд үйлдвэрлэв” борлуулалтын цэгийг Дэвшилт ХХК-ны байранд нээн ажиллуулж давхардсан тоогоор хувиараа өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 79 иргэний бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулж байна. Мөн аймгийн хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, нутгийн брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах борлуулах зорилгоор 7-р сарын 27-29-ний өдрүүдэд, 10-р сарын 12-14-ний өдрүүдэд тус тус үзэсгэлэн худалдааг зохион байгуулж ажилласан.	100
	110	1.5.2.9. “40-өөс дээш болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	2016-2020	ХХҮГ, СЗДТГ, ААХолбоо	ХЭДС 14.14 сая	Хөдөлмөр эрхлэх чадвартай ахмад настуудыг хамруулж, 30-аас доошгүй хувийг түр ажлын байраар ханган өрхийн амжиргааг нь дэмжсэн байна.	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд 24 аж ахуйн нэгж байгууллагуудаас 75 ахмад мэргэжилтнийг ажиллуулах захиалга ирснээс 21 аж ахуйн нэгж байгууллагын 58 захиалгыг ажлын хэсгийн хурлаар дэмжин 58 ахмад мэргэжилтнүүдтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Зөвлөгөө өгч буй ахмадуудыг салбараар нь ангилвал эрүүл мэндийн чиглэлээр 24, боловсролын салбарт 15, Хөдөө аж ахуйн салбарт 6, Төрийн захиргааны чиглэлээр 13 ахмад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж байна. Зөвлөн туслах үйлчилгээг амжилттай хэрэгжүүлсэн 8 ахмад мэргэжилтэнд 2.4 сая төгрөгийн урамшууллыг олгосон. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хувиараа хөдөлмөр эрхэлж буй	100

							10 ахмадын төслийг 12.0 сая төгрөгөөр тус тус дэмжсэн.	
	111	1.5.2.10. Ажлын байрны мэдээллийг олон нийтэд хүргэх, “Хөдөлмөрийн яармаг”-ийг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах	2016-2020	ХХҮГ, СЗДТГ	Улс, ОНТөсөв, ХЭДС,	Ажилгүй иргэдийн 70-аас доошгүй хувийг ажлын байранд зуучлан бүсчилсэн хэлбэрээр “Хөдөлмөрийн яармаг”-ийг жил бүр зохион байгуулж хэвшсэн байна.	"Цагаан сар-Булган түншлэл 80" үзэсгэлэн худалдаа 2 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, зорилтот бүлгийн 5 иргэн уг үзэсгэлэн худалдаанд бүтээлээрээ амжилттай оролцлоо. Аймгийн хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах зорилгоор 7-р сарын 27-29-ний өдрүүдэд, 10-р сарын 12-14-ний өдрүүдэд “Намрын ногоон өдрүүд-Булганд үйлдвэрлэв” үзэсгэлэн яармаг худалдааг зохион байгууллаа. Тус үзэсгэлэн худалдаанд 11 сумын 112 нэр төрлийн бүтээл оролцож 16.0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.	100
	112	1.5.2.11. Сум бүрт орлого багатай 10-аас доошгүй малчин өрхийг жил бүр “Малжуулах төсөлд” хамруулах, малгүй иргэдийг туслах аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах	2016-2020	ХХҮГ, СЗДТГ	ХЭДС 214.0 сая	Малчин өрхийг малжуулан, ажлын байраар хангасан байна.	“Мерси кор” ОУБ-тай хамтран мах боловсруулах, бэлтгэх чиглэлээр 5.0 сая төгрөгийн эргэн төлөгдөхгүй олгох Залуучуудын шилдэг төслийн уралдаант бизнес санаагаа хөгжүүлэх сургалтыг зохион байгуулан 6 сумын 25 иргэн оролцож Сэлэнгэ сумын Э.Ням-Осорын “Үхрийн ангилж савласан мах” төсөл шалгарлаа. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдахаар аймгийн 16 сум 1 тосгоноос 76 малчин өрх төсөл ирүүлснээс 47 малчин өрхөд 214.0 сая төгрөгийн 3995 толгой мал авч хүлээлгэн өглөө. /хонь 2489, ямаа 1309, үхэр 171, адуу 26/ Мөн 2017 оноос хэрэгжүүлж эхэлсэн аймгийн цөөн малтай малчин өрхийг малжуулах арга хэмжээнд 25 өрхөд 130.0 сая төгрөгөөр мал хүлээлцэх ажлыг зохион байгуулж хонь 1516, ямаа 776, үхэр 68, нийт 2360 толгой малыг хүлээлцэж 72 өрхийн 144 иргэнийг байнгын ажлын байраар хангасан байна.	70
124/ 1.5.3. Хөдөлмөрийн харилцааны хэрэгжилтийг ханган ажиллаж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэн нийгмийн түншлэлийг хөгжүүлнэ.	113	1.5.3.1. Ажил олгогчийг дэмжих чиглэлээр хамтран ажиллаж, уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулах	2016-2020	АЗДТГ, ХХҮГ, ХХААГ, АОЭХ, СЗДТГ	Улс, ОНТөсөв, Төсөл хөтөлбөр, Хандив	10-аас доошгүй аж ахуйн нэгж байгууллага, 20-оос доошгүй иргэнийг тус чиглэлд	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраар дамжуулан ажилтан авдаг болгох зорилгоор “Ажил олгогчдод хүргэх зөвлөмж”-ийг гарган нийт 240 байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Түүнчлэн орон нутгийн “Сайхан Монгол” телевизийн “зар” хэсэг дэх ажлын байрны зарын урсгалыг ХХҮГ 1 жилийн хугацаагаар худалдан авснаар ажил олгогч ажилтан авах зараа заавал ХХҮГ-аар дамжуулан өгдөг болсон	40

						хамруулсан байна.	амжилттай ажил, арга хэмжээ зохион байгуулаад байна.	
	114	1.5.3.2. Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт хэлэлцээрийн хэрэгжилтийг сайжруулж, салбар хороодын үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэмжлэг туслалцаа үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХҮГ, ХХААГ, ЭМНДХ, АОЭХ, СЗДТГ	ОНТөсө в 1,5 сая	3 талт салбар хороонд тодорхой хэмжээний төсөв хөрөнгө батлагдаж, үйл ажиллагаа нь бэхжсэн байна.	Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх ажлын хүрээнд “Аймгийн Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр 2017-2018”-ийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор амйгийн ЗД, АОЭХ, ҮЭХ-оос 01 тоот хамтарсан албан даалгаврыг гарган ажиллаж байна. 2018 онд Сэлэнгэ, Могод, Хангал, Тэшиг, Сайхан, Баян-Агт, Баяннуур, Бугат, Дашинчилэн зэрэг сумд хэлэлцээрээ байгуулан ажиллаж байна. 3 талт хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 2018 онд 1.5 сая төгрөгийг төсөвлөн сургалт, мэдээлэл, туршлага судлах аяллыг зохион байгууллаа. ХАБЭА-н сарын аяны хүрээнд 3 талын төлөөлөл хамтран аймгийн ХАБЭА-н болон цалин хөлсний үзлэгийг амжилттай зохион байгуулаад байна. Үзлэгт нийт 186 байгууллага, аж ахуйн нэгж хамрагдсан. Мөн 2018 оны 10-р сард хөнгөн үйлдвэрийн салбар дахь ХАБЭА-н үзлэгийг гурван талын төлөөлөл хамтран явуулав. Үзлэгийн дүнг нэгтгэн 11-р сард холбогдох газруудад хүргүүлэх болно.	100
	115	1.5.3.3. Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавихад төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах, хөдөлмөр эрхлэх болон бусад чиглэлээр байгуулагдсан аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ИНБ-ын төлөөлөл оролцуулан, хамтран ажиллах	2016-2020	АЗДТГ, ХХҮГ, ХХААГ, АОЭХ, СЗДТГ	ОНТөсө в 1,0 сая	Зөвлөлүүдийн бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулан хамтран шийдвэр гаргана.	Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн салбар зөвлөл, ХАБЭА-н аймгийн салбар зөвлөл, Бүтээмжийн салбар зөвлөл зэрэг нийгмийн түншлэлийн хүрээнд гурван талын төлөөллийг оролцуулан хамтран ажиллаж байна. Мөн жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар зөвлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах аймгийн салбар зөвлөл зэрэг томоохон салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн ТББ-ын төлөөллийг оролцуулан хамтран ажиллаж байна. ХАБЭА-н сарын аяны хүрээнд аймгийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулахад Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний хорооны гишүүдийг ижил тэнцүү оролцуулах, аймгийн ХАБЭА-н “Мэргэжлийн баг”-ийг томилоход 3 талын төлөөллийг оролцуулан үзлэг, шалгалтын ажлыг зохион байгуулах, сарын аяны үйл ажиллагаанд хамтран ажиллах, сургалт, мэдээлэл, хэлэлцүүлэгт оролцох зэрэг ажлыг 3 талын төлөөлөл хэрэгжүүлэн ажиллаж байна.	100

	116	1.5.3.4. “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аймгийн дэд хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, үзлэг шалгалтыг жил бүр зохион байгуулах, дүгнэх	2016-2020	АЗДТГ, НБХ, ХХҮГ, ЭМГ, МХГ, ЭМНДХ, АҮЭХ, АОЭХ, СЗДТГ	ОНТөсө в 2,1 сая	Үйлдэрлэлийн болон ажлын байран дахь осол гэмтлийн тоо буурч эрүүл аюулгүй ажлын байрны тоо нэмэгдэнэ.	2018 онд ХАБЭА-н үзлэгийг 186 төр, төсвийн байгууллага, төрийн өмчит компани болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад зохион байгуулж байгаа бөгөөд шалгалтыг аймгийн Засаг даргын захирамжаар баталсан “Мэргэжлийн баг”-ийн 16 гишүүд болон сумдын ХАБЭА-н зөвлөл хамтран зохион байгуулав. Сарын аяныг “Залуучуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2018” нэрийн дор 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 05 дугаар сарын 02-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Сарын аяны хүрээнд нийт 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 3.1 сая төгрөгийг төсөвлөн хувцас хэрэгслийн үзэсгэлэн гаргах, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, “Залуучуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2018” сэдэвт ХАБЭА-н Илтгэлийн уралдаан, “Нэн түрүүнд ХАБЭА” сэдэвт “Дэвжээ” тэмцээн, Сарын аяны хүрээнд идэвхтэй ажилласан шилдэг байгууллагыг шалгаруулах зэрэг томоохон арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Сум, байгууллагууд орон тооны бус зөвлөл байгуулах, ажилтан томилох ажил өмнөх онуудтай харьцуулахад нэмэгдсэн сайн талтай байна. Ажил олгогч ажилтны ХАБЭА-н талаарх ойлголт, хандлага дээшилж, эрүүл аюулгүй ажиллах орчинг бий болгохоор анхаарал хандуулан ажиллаж байна гэж дүгнэж байна.	100
	117	1.5.3.5. Байгууллага, аж ахуйн нэгжүүдэд “Бүтээмжийн хөдөлгөөн” өрнүүлж, шинэ санал, санаачлагыг дэмжиж ажиллах	2016-2020	АЗДТГ, НБХ, ХХҮГ, АОЭХ, СЗДТГ	ОНТөсө в	Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажлын байрны эмх цэгц сайжирч, бүтээмж нэмэгдсэн байна.	Бүтээмжийн талаарх сургалтыг нийт 11 байгууллага, 9 сумын 1065 ажилтан, албан хаагчдыг хамруулан “Хөдөлмөрийн бүтээмж, түүнийг хэрэгжүүлэх тулгуур асуудлууд”, “Кайзен саналын систем”, “Бүтээмж чанарын дугуйлан”, “Бүтээмж-Инноваци”, “Байгууллагын инновацийн үйл ажиллагаа”, “Суралцагч байгууллага” зэрэг сэдвийг хамруулан шат дараалан сургалтыг зохион байгуулж байна. 2018 онд 3-р сургууль, Эрүүл мэндийн газар, Булган сумын 1, 2, 3, 4, 6, 7-р цэцэрлэг, Хангал, Булган сумын Соёлын төв, Гурванбулаг сум, ХАА-н МСҮТ зэрэг сум, байгууллагууд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг ирүүлээд байна. Эдгээр байгууллагууд бага зардлаар ажлын байрны орчинг сайжруулах, ажлын бүтээмж дээшлүүлэх чиглэлээр олон санал, санаачлага гарган ажиллаж байна. Бүтээмж тооцох аргачлалыг хувийн хэвшлийн 2 байгууллагад	70

							нэвтрүүлэхээр бэлтгэл ажил хангагдаж байна.	
	118	1.5.3.6. Аймгийн “Цалин хөлсний үзлэг”, ХАБЭА-н болон бусад үзлэг, шалгалт, зөвлөн туслах үйл ажиллагаа, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах	2016-2020	АЗДТГ, НБХ, ХХҮГ, ЭМГ, МХГ, НДХ, АҮЭХ, АОЭХ, СЗДТГ	ОНТөсө в	Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгож хэвшин, ажлын байрны эмх цэгц сайжирч ажиллах орчин эрүүл аюулгүй болсон байна.	Аймгийн Засаг даргын А/181 тоот захирамжаар баталсан аймгийн ХАБЭА-н “Мэргэжлийн баг” болон сумдын ХАБЭА-н зөвлөл цалин хөлсний үзлэгийг 2018.04.10-23 өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Үзлэгийг 186 төр, төсвийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагад явууллаа. Үзлэг, шалгалтыг ХАБЭА-н асуудалтай холбоотой 15 асуулгаар дүгнэснээс аймгийн хэмжээнд үзлэгт хамрагдсан байгууллагуудын дундаж үнэлгээ 63.2 хувьтай байна. Үзлэгийн дүнгээр ажиллагсдын дундаж цалин 500000-600000 төгрөг, төрийн өмчит компаниуд нэмэгдэл хөлс олгох тал дээр хангалттай сайн, төрийн байгууллагууд нэмэгдлийг сайн олгодог, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс олгож байгаа газар 0.03 хувь нь байна. Ажиллагсдын ажлын цаг ихэвчлэн 8 цаг байна.	100
Нийгмийн халамж, хамгаалал, хүүхэд гэр бүл:								
/25/ 1.5.4. Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн халамж, асрамжийн үйлчилгээг өргөжүүлэн, тэдэнд зориулсан үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	119	1.5.4.1. ХХҮГ-ын харьяа сувиллын яслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, шаардлагатай зарим техник, тоног төхөөрөмжөөр хангах	2016-2020	АЗДТГ, НБХ, ХХҮГ, СЗДТГ	ОНТөсө в, Нийгмийн халамжийн сан 2,9 сая	Сувиллын яслийн үйлчилгээг өргөжүүлэн, зуны сургалт явуулах боломжийг бий болгосон байна. Яслийн зарим ангиудыг тоглоомоор хангасан байна.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Сувиллын яслид 2017-2018 оны хичээлийн жилд зорилтот бүлгийн 128 хүүхэд хүмүүжсэн байна. Хүүхдийн нас, биеийн хөгжлийн онцлогт тохируулан чийрэгжилтийн ажлын төлөвлөгөөг боловсруулан хүүхэд нэг бүрт хүрч ажилласан. Хүүхдийн сурч хүмүүжих орчин нөхцөлийг сайжруулах, яслийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Хүүхдийн ертөнцөд өнгө нэмье” уриан доор тоглоомжуулах сайн үйлсийн аян өрнүүллээ. Аяны хүрээнд 13 байгууллага нэгдэж 205 төрлийн тоглоом цуглаж, хүүхдийн хүмүүжих орчин нөхцөл сайжирсан үр дүнтэй ажлыг зохион байгуулсан. Сувиллын яслийн хэмжээнд ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангах зорилгоор ажилтан, албан хаагч нарын гадуур хувцас хийх төмөр шүүгээ, 1 ангид 32 инчийн телевиз, 2 ангийн унтлагын өрөөнд тус бүр нэг нэг хивс, гал тогоонд хоол тэжээлийн хадгалалтын горимд нийцэх хөргөгчийг төсвийн хөрөнгөөс 2137600 төгрөгөөр авч тохижуулсан. Мөн	70

							хүүхдийн тоглоомын хүрэлцээг нэмэгдүүлэхээр 2 ангид 800000 төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг том оврын тоглоом /төөлүүрэн хорхой/, 40 ширхэг гарын булчин хөгжүүлэх бөмбөгийг авч тохижуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.	
	120	1.5.4.2. Асран хамгаалагчгүй, ганц бие өндөр настан, орон гэргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг орон байраар хангах, төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах, амралт сувилалд хэвтэн эмчлүүлэхэд туслалцаа үзүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, ХХҮГ, СЗДТГ	ОНТөсөв, Нийгмийн халамжийн сан 216,1 сая	Жилд 3-аас доошгүй иргэнийг нийгмийн асрамжийн төрөлжсөн үйлчилгээнд хамруулсан байна.	2018 онд “Ахмад настны тухай хууль”-ийн дагуу 750 ахмад настанд 127.7 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн байна. Онцгой тохиолдлын болон амьжиргаа дэмжих тэтгэмжид 1289 иргэн хамрагдсанаас 1259 буюу 97.7 хувь нь байнгын асаргаа шаардлагатай иргэнд олгох тэтгэмжид хамрагдсан байна. Нийгмийн халамжийн хуулийн дагуу 2018 оны 3 дугаар улирлын байдлаар рашаан сувилалд сувилуулсан 15 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 2.7 сая төгрөгийн хөнгөлөлт, 171 ахмад настанд 29.8 сая төгрөгийн хөнгөлөлтийг тус тус үзүүлсэн. Ахмадын зориулалттай амралтад амарсан 283 иргэнд 55.9 сая төгрөгийн хөнгөлөлтийг хуулийн дагуу цаг хугацаанд нь олгосон. Булган сумын 1 ахмад настныг төрөлжсөн асрамжийн газарт зуучлахаар холбогдох материалыг бүрдүүлэн хүргүүлсэн болно.	70
	121	1.5.4.3. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын чиглэлээр эрх нь зөрчигдсөн иргэдийг хамгаалах “Хүчирхийллээс хамгаалах түр байр”-ны зардлыг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэх	2016-2020	НБХ, ГБХЗХХ, СЗДТГ	ОНТөсөв 13,0 сая АЗД-ын нөөц	Байрны урсгал зардлын асуудлыг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэн иргэд ая тухтай үйлчлүүлэх орчин нөхцлийг сайжруулсан байна.	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 06/07 тогтоолоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын 35 дугаар зүйлд заасан түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, 38.1.1-д заасан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор түр хамгаалах байрны нийгмийн ажилтан-1, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхимд ажиллах сэтгэл зүйч-1, нийт 2 ажилтны цалин болох 13.0 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн. Түр хамгаалах байрны дэргэд “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв”-ийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нээж, хохирогчдод сэтгэл зүйн тогтворжуулах зөвлөгөөг өгч нийгмийн ажил үйлчилгээний төрлийг нэмэгдүүлсэн. Зөвлөгөө өгөх танхимд мэргэжлийн сэтгэл зүйч ажиллаж, давхардсан тоогоор 89 хүнд 130 цагийн сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг хүргээд байна. Тус танхимаар үйлчлүүлсэн иргэдийг хяналтад авах, утсаар зөвлөгөө өгөх, чөлөөт ярилцлага хийх гэх мэтчилэн олон хэлбэрийг сонгон иргэдэд үйлчилж байна. Аймгийн ШШГА, аймгийн Иргэний хэргийн анхан шатны	100

						шүүхийн Эвлэрүүлэн зуучлагч нартай 2018 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах, гэр бүлийн маргаантай гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.	
122	1.5.4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд зориулсан чөлөөт цагаа өнгөрөөх нийгэмшүүлэх, сэргээн засах эмчилгээ сувилгааны зориулалтаар “Хөгжлийн төв” байгуулах	2016-2020	ХХҮГ, АХБИХо лбоо, СЗДТГ	ГБХЗХГ -ын төсөв 1,3 сая	“Хөгжлийн төв”-ийг байгуулж, 20-оос доошгүй байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдийг хамруулсан өдөр өнжүүлэх ажиллаж, ХБИ-ийн 60-аас доошгүй хувь нь тус төвөөр үйлчлүүлж хэвшсэн байна.	ДЗМОУБ-ын БХНХХ-өөс Хүний хөгжлийн төвийг хүлээн авч Хүүхэд залуучуудын хөгжлийн ордон болгон үйл ажиллагааг тогтмол явуулж байна. 2018 оны улсын төсөвт тус ордны тогтмол зардлыг шийдвэрлүүлж, байрны дотоод засварыг өөрсдийн нөөцөд тусгуурлан 1.3 сая төгрөгөөр сэргээн сайжруулсан. Байрны гадна засварын 57.8 сая төгрөгийн зураг төсвийн ажлыг хийлгэж, 2019 оны улсын төсөвт тусгуулаад байна. Өнөөдрийн байдлаар тус ордонд аймгийн төв номын сангийн салбар, Залуучуудын хөгжлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Итгэл” өдөр өнжүүлэх төв, аймгийн Залуучуудын холбоо, залуу гэр бүлийн “Амьдрах ухаан” -ы танхим, Ахмадын хийн дасгалын клуб тогтмол үйл ажиллагаа явуулж, хүүхэд хөгжүүлэх Бокс, Төгөлдөр хуурын дугуйлангууд хичээллэж байна. Булган суманд үйл ажиллагаа явуулж буй Оргил-Мээж холбоо нь ашгийн бус байгууллага бөгөөд ОНОТХҮ үзүүлэх тусгай эрхийг 2 жилийн хугацаатайгаар авсан ба хөгжлийн бэрхшээлтэй 12 хүүхдэд өдрийн үйлчилгээ үзүүлж байна. Хөгжлийн төвөөр үйлчлүүлэх, үйлчилгээ авах хүүхдүүдийн асран хамгаалагч нартай 2 удаа уулзалт зохион байгуулж, үйл ажиллагааны талаар танилцуулж мэдээлэл хийсэн.	70
123	1.5.4.5. Ахмадуудад зориулсан эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн цогц үйлчилгээний геронтологийн нэгжийг байгуулах	2016-2020	ХХҮГ, ААХолбоо, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, СЗДТГ	Улс, ОНТөсөв	“Геронтологийн нэгж”-ийг байгуулж, аймгийн ахмад наснуудын 80-аас дээш хувийг хамруулан үйлчилгээ үзүүлсэн байна.	Ахмадуудад зориулсан эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн цогц үйлчилгээний геронтологийн нэгжийг байгуулах зорилт тавьж газрын асуудлыг шийдвэрлэн “Ахмадын өргөө” нэртэй цогцолбор төвийг барьж байгуулахаар шавыг тавьж зураг төсөв хийлгэж барилгын ажлыг эхлүүлэхээр 2019 оны орон нутгийн төсөвт 300.0 сая төгрөгийг шийдвэрлэхээр тусгаад байна. Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэгтэй хамтран ХХҮГ-ын харъяа Ахмадын амралтад амарч буй 8 ээлжийн буюу 225 ахмадыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан. Улсын геронтологийн төвөөс орон нутагт ирж үзлэг оношилгоо хийсэн ба	70

							183 ахмадыг тус үзлэгт хамруулж онош тогтоолгосон. 2018 онд мөн тус газраас Булган суманд ажиллаж буй Ахмадын амралтанд амарч байгаа 1 ээлжийн 28 ахмадыг үзлэгт хамруулсан.	
	124	1.5.4.6. Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулж, амралт сувиллын хүчин чадлыг нэмэгдүүлэн засвар үйлчилгээг хийж, шаардлагатай зарим тоног төхөөрөмжөөр хангах	2016-2020	ХХҮГ, ААХолбоо, СЗДТГ	ОНТөсөв, Нийгмийн халамжийн сан 9,8 сая	Ахмадын амралт сувилалын орны тоог 40-50 хувиар нэмэгдүүлж, сэргээн засах техник тоног төхөөрөмжөөр 70-аас дээш хувиар хангасан байна.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харъяа ахмадын амралт нь жил бүр 20-25 ээлж хүлээн авч нэг ээлжинд 30 хүртэлх хүн хүлээн авах хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулж байсан бол амрагчдын эрэлт хэрэгцээ жилээс жилд өсөж байгаатай холбоотойгоор 2018 онд хүчин чадлаа нэмэгдүүлж 1 ээлжинд 40 хүн хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Амрагчдын амрах тав тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчлэн, нэмэгдүүлэх зэрэг ажилд нийт 9.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 2017 онд “Ахмадад ээлтэй байгууллага”-аар шалгарсан амжилттай ажиллаж байна. Ахмадын амралт нь 2018 онд 22 ээлжинд 587 амрагч хүлээн авахаар хуваарь батлуулан ажиллаж байна. Малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан 4 дүгээр сарын 18-аас эхлэн амралтын үйл ажиллагааг эхлүүлж, 9 дүгээр сарын байдлаар 15 ээлжийн амрагчийг хүлээн авч 78.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна.	70
	125	1.5.4.7. Ахмад настны нийгмийн хамгааллын хуулийн хэрэгжилтийг ханган, албан газар аж ахуйн нэгж байгууллага бүр ахмадын сан байгуулах, харьяалалгүй байгаа ахмад настнуудыг албан байгууллага аж ахуйн нэгжүүдэд харьяалуулах ажлыг шат дараатайгаар зохион байгуулах	2016-2020	ХХҮГ, Холбогдох аж ахуйн нэгж байгууллагууд, ААХолбоо, СЗДТГ	Тухайн байгууллагын төсвийн 0,3 хүртэлх хувь 18,8 сая АЗД-ын нөөцөөс 5,3 сая	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын 80-аас дээш хувь нь “Ахмадын сан”-тай болж ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор зарцуулж	Манай аймгийн хэмжээнд нийт 800 гаруй харьяалалгүй ахмад настан байдаг бөгөөд эдгээр ахмадын 70-аас доошгүй хувийг аль нэг байгууллагад харьяалуулах ажлыг зохион байгуулж холбогдох байгууллагуудад албан тоотыг хүргүүлэн ажиллаж байна. 2018 оны Нөхөрсөг нохой жилийн сар шинийн баярыг угтаж харьяалалгүй ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Булган сумын ЗДТГ, ХХҮГ, Ахмадын хороотой хамтран нийт 400 гаруй ахмадад гарын бэлэг гардуулж 5.3 сая төгрөг зарцуулсан байна. Олон улсын Ахмадын баярыг угтаж “Ахмадаа сонсьё” уриан дор аймгийн хэмжээнд сарын аян өрнүүлж амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Аяны хүрээнд 6 төрлийн арга хэмжээг сум орон нутагт зохион байгуулж давхардсан тоогоор 4441 ахмадад хүрч ажилласан байна. Тус арга хэмжээг зохион байгуулахад 95 ААН, байгууллага оролцож нийт үйл ажиллагаанд 46.1 сая төгрөг зарцуулсан. Монгол	70

						хэвшсэн байна. Аймгийн хэмээнд харьяалалгүй байгаа нийт 400 гаруй ахмад настны 70-аас дээш хувийг албан байгууллагад харьяалуулсан байна.	Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор ахмадын сан байгуулах журам шинэчлэгдэн батлагдсан. Үүний хүрээнд 137 ААНБ-д сургалт зохион байгуулсан. 2018 оны 9 дүгээр сарын байдлаар 42 байгууллага сан байгуулж 18.8 сая төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна.	
	126	1.5.4.8. “Хүүхэд залуучуудын хөгжлийн төв”-ийг байгуулан, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн ажиллах	2016-2020	АЗДТГ, НБХ, ГБХЗХГ, СЗДТГ	ОНТөсөв	“Залуучуудын хөгжлийн төв”-тэй болсон байна. Тус төвийн урсгал зардлыг шийдвэрлэн тогтмол хэвийн үйл ажиллагаатай болсон байна.	ДЗМОУБ-ын БХНХХ-өөс Хүний хөгжлийн төвийг хүлээн авч Хүүхэд залуучуудын хөгжлийн ордон болгон үйл ажиллагааг тогтмол явуулж байна. 2018 оны улсын төсөвт тус ордны тогтмол зардлыг шийдвэрлүүлж, байрны дотоод засварыг өөрсдийн нөөцөд тусгуурлан 1.3 сая төгрөгөөр сэргээн сайжруулсан. Байрны гадна засварын 57.8 сая төгрөгийн зураг төсвийн ажлыг хийлгэж, ХНХЯ-нд хүргүүлээд байна. Өнөөдрийн байдлаар тус ордонд аймгийн Төв номын сангийн салбар, Залуучуудын хөгжлийн төв, хүүхдийн өдөр өнжүүлэх төв, аймгийн Залуучуудын холбоо, залуу гэр бүлийн “Амьдрах ухаан”-ы танхим, Ахмадын хийн дасгалын клуб тогтмол үйл ажиллагаа явуулж, хүүхэд хөгжүүлэх Шатар, Бүжиг, Уран өд, Бийр татлаган бичлэг, Бокс, Төгөлдөр хуур, Математик, Монгол хэлний нийт 8 дугуйлангууд хичээллэж, 320 гаруй хүүхэд, залуучууд цагийн хуваарийн дагуу тогтмол үйл ажиллагаанд хамрагдаж байна. Залуучуудын хөгжлийн төвийн жилийн ажлын төлөвлөгөөг гаргаж, газрын даргаар батлуулан хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Иргэдэд хууль сурталчлах өдөрлөг, “Хуулиа мөрдье”, “Ирээдүйн эзэд” аян, “Ургаа мэдвэл улсаа мэднэ” нэгдсэн сургалт, амьдрах ухааны сургалтууд, малчин залуучуудын “Адуучин” тэмцээн, залуу малчдын уулзалт, ардын ёс заншлын тэмцээн, Тэмүүлэл залуучуудын чуулганыг тус тус зохион байгуулж 12500 гаруй өсвөр үе, залуучуудад хүрч ажилласан нь Булган аймгийн 15-34 насны нийт залуучуудын 51	100

							хувийг хамруулсан байна.	
/26/ 1.5.5. Нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээг өргөжүүлж, мэдээллийн нэгдсэн системийг боловсронгуй болгон иргэдэд хүндрэл чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчлэх нөхцлийг бүрдүүлнэ.	127	1.5.5.1. Зорилтот бүлгийн иргэдэд хуулийн дагуу нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээнүүдэд хамруулж, цаг хугацаанд нь хөнгөн шуурхай үйлчлэх	2016-2020	АЗДТГ, ХХҮХГ, ЭМНДХ, СЗДТГ	Нийгмийн халамжийн сан-5581,3 сая Нийгмийн даатгалын сан	Иргэдэд тэтгэвэр, тэтгэмжийг хөнгөн шуурхай олгож хэвшсэн байна.	Зорилтот бүлгийн 1513 иргэний эрүүл мэндийн даатгалыг төрөөс даатгуулах арга хэмжээ авч баталгаажилтыг хийж ажилласан байна. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй иргэний тодорхойлолтыг хөнгөн шуурхай олгож хэвшсэн. Нийгмийн халамжийн сангаас сар бүрийн 15-ны дотор тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн олголтыг хийж хэвшсэн. 3 дугаар улирлын байдлаар 23450 иргэнд 5581.3 сая төгрөгийн олголт хийгдэж өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар өссөн дүнтэй байгаа нь нийгмийн халамжийн багц хуулинд өөрчлөлт орж тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ өссөнтэй холбоотой гэж үзэж байна.	100
	128	1.5.5.2. Малчид болон албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлж, сургалт, мэдээллийн ажлыг тогтмолжуулах	2016-2020	ЭМНДХ, СЗДТГ	ОНХС, Нийгмийн даатгалын сан	Сайн дурын даатгуулагчийн тоог аймгийн эдийн засгийн идэвхтэй хүн амын 20 хувьд хүргэх, малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг 30-35 хувьд хүргэх, ЭМД-д даатгуулагчийн тоог суурин хүн амын 90 хувьд хүргэх	2018 онд 4235 сайн дурын даатгуулагчдаас 916.5 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлсэн. Үүнээс: Малчин 2571 даатгуулагч хамрагдсанаас шинээр 600 малчин хамрагдсан байна. Малчдад зориулсан төрөл бүрийн сургалтад тус хэлтсээс 16 суманд хүрч ажилласан бөгөөд тэдэнд зориулсан гарын авлага боршурыг НДЕГ-аас авч хүргүүлсэн байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдагсад дараах төрөлтэй байдаг ЭМД-ын сан бүрдүүлэхэд оролцдог юм. Өндөр нас, группын тэтгэвэртэй иргэдийн ЭМД-ыг мөн адил төрөөс хариуцан төлж байгаа өөрөө шимтгэлээ төлөгч иргэдэд, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, малчин, 19-өөс дээш насны оюутан суралцагсад байдаг. Оюутан суралцагч нарт Даатгуулагчдын сарын аян, нээлттэй хаалганы өдрүүдээр сургалт сурталчилгааг тогтмол явуулж хэвшсэн.	70
	129	1.5.5.3. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдыг нийгмийн даатгалд бүрэн	2016-2020	ЭМНДХ, СЗДТГ	Нийгмийн даатгалын сан	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуу	2018 оны 3-р улирлын байдлаар албан журмын даатгалд 8133 даатгуулагчийг хамруулж аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын 79.5 хувийг нийгмийн даатгалд хамруулан ажиллалаа.	70

		хамруулах				дын ажиллагсады н 90-ээс доошгүй хувийг нийгмийн даатгалд хамруулах		
127/ 1.5.6 Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан санал, санаачлагуудыг дэмжих	130	1.5.6.1. “Хүүхдэд ээлтэй орон нутаг”-ийн хүрээнд гаргасан санал санаачлагуудыг дэмжин ажиллах	2016-2020	НБХ, ГБХЗХХ, СЗДТГ	Улс, ОНТөсөв, Төсөл хөтөлбөр	Хүүхдэд ээлтэй ажлын хандлага арга барил, ажил үйлчилгээ төлөвшин хөгжсөн байна.	Жил бүр хүүхдийн асуудал сонсох өдрийг хүүхдийн оролцооны байгууллагуудын чуулга уулзалт “Хүүхдийн парламент”-тай хамтатган зохион байгуулж, хүүхдийн төлөө зөвлөлийн дарга, гишүүдэд танилцуулан холбогдох шийдвэрийг гарган ажиллаж байна. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын талаар шинээр гарсан хууль тогтоомж түүний дотор Хүүхдийн эрхийн хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг аймгийн Засаг дарга, ХТЗ-ийн дарга болон байгууллагын удирдлагын баталсан удирдамж, хуваарийн дагуу цувралаар зохион байгуулж давхардсан тоогоор аймгийн 16 сумын хэмжээнд 2016-2018 онд нийт 94755 хүүхэд, насанд хүрэгчдийг хамруулсан байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын хууль, Залуучуудын хөгжлийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангах зорилгоор “ОРОЛЦЬЁ, ХӨГЖЬЕ, МАНЛАЙЛЪЯ” нэгдсэн арга хэмжээг газрын даргын баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу 4 бүсэд 16 сумын хамтарсан багийн нийт 113 гишүүнийг хамруулан чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан.	70
	131	1.5.6.2. Гэр бүлийн гишүүд, хүүхэд өсвөр үеийнхэнд гэр бүлийн боловсрол олгох, ахмад, залуучууд, хүүхдийн “Алтан хэлхээ” цугларалтыг зохион байгуулах	2016-2020	НБХ, ГБХЗХХ, СЗДТГ	Улс, ОНТөсөв, Төсөл хөтөлбөр	Гэр бүлийн гишүүд, хүүхэд өсвөр үеийн гэр бүлийн боловсрол дээшилж, харилцаа хандлага төлөвшиж, 3	Залуу гэр бүлийн үнэ цэнэ, харилцаа хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 2017 онд залуу гэр бүлүүдэд зориулсан 6 удаагийн масс сургалтад 1241 гэр бүлийн гишүүдийг хамруулсан. 2018 онд зорилтот гэр бүлд хандсан гэр бүлийн боловсрол олгох 5 цуврал хичээлд сонгогдсон байгууллагуудын 18 өрхийг хамруулж 1 сарын хугацаанд зохион байгуулсан. Гэр бүлийн гишүүд, хүүхэд өсвөр үеийнхэнд гэр бүлийн боловсрол олгох, ахмад, залуучууд, хүүхдүүдийн “Алтан хэлхээ” цугларалтыг 2018 онд хүүхдийн байгууллага үүсч хөгжсөн өдөр буюу 05 дугаар сарын	100

						үеийн залгамж чанар нэмэгдэж, гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол буурсан байна.	08-ны өдөр зохион байгуулж, хүүхдийн байгууллагын үе үеийн ахмадуудын төлөөлөл, хүүхдийн парламентийн хүүхдүүд, байгууллагын ажилчид нийт 52 хүн оролцсон байна. Уулзалтаар Гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд 3 үеийн үүрэг оролцоо сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж, байгууллагын үйл ажиллагааг оролцогчдод танилцуулж, 3 үеийн санал сэтгэгдлийг сонсож ажиллалаа.	
	132	1.5.6.3. Хүүхдийн “Жаргалант” зуслангийн хэсэгчилсэн зураг, төсвийн хүрээнд зарим бүтээн байгуулалтын ажлыг хийж, зусланд “Хүүхэд солилцоо”-ны хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллах	2016-2020	НБХ, ГБХЗХХ, СЗДТГ	Улс, ОНТөсө в	Бүтээн байгуулалтын зарим арга хэмжээг хэрэгжүүлэн, зусланд хүүхэд амрах нөхцөл боломж бүрдэж, хүүхэд солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	Жаргалант зуслангийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинэ зуслан барих асуудлыг ХНХЯам, ГБХЗХҮГазар, UNECEF төсөлтэй хамтран шийдвэрлэхээр судлагдаж байна. Зорилтот бүлгийн болон сурлага, урлагийн шилдэг манлайлагч нийт 9 сумын 12 сурагч хүүхдийг Олон улсын хүүхдийн Найрамдал зусланд амруулж, хүүхэд хөгжлийн хөтөлбөрт арга хэмжээнд хамрууллаа.	40
	133	1.5.6.4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын барилгын их засварыг хийж, орчин нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	НБХ, ГБХЗХХ, СЗДТГ	ОНТөсө в 45,8 сая	Барилгад засвар хийж, зарим техник, тоног төхөөрөмжөөр хангасан байна.	2018 онд “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын кино танхимийн тоног төхөөрөмж нийлүүлэх” нээлттэй тендер зарлаж “Онъ тэнгэрийн бичиг” ХХК-тай бараа материал нийлүүлэх гэрээ байгуулсны дагуу 45.8 сая төгрөгийн худалдан авалт хийгдсэн. Энэхүү худалдан авалтын хүрээнд 100 ширхэг үзэгчдийн зориулалтын суудал, пульта, чанга яригч, чадлын өсгөгч, зайны микрофон, компьютер зэрэг техник хэрэгслээр бүрэн хангагдаж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	100
	134	1.5.6.5. Аймгийн Хүүхэд залуучуудын соёл, амралтын хүрээлэн/ парк/-гийн тохижилтын ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу шат дараатайгаар	2016-2020	НБХ, ГБХЗХХ, ОНӨСА ЦХ, СЗДТГ	ОНТөсө в-180,0 сая БХС-аас 60,0 сая	Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг шат дараатайгаар хийж гүйцэтгэсэн байна.	Хүүхэд залуучуудын соёл, амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажилд 2018 онд ОНХС-аас 180.0 сая төгрөг, БХС-аас 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөн тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 1-р багцын явган зам, гэрэлтүүлгийн ажилд “Ай И Би” ХХК, 2-р багцын автомашин зогсоолын ажилд “Баян-Өндөр Булаг” ХХК, нийтийн ариун цэврийн байгууламж барих	100

		хийж гүйцэтгэх /2-р шатны үйл ажиллагааны хэсэгчилсэн зураг төсөв хийх/					тендерт “Цонхот” ХХК тус тус шалгарч тохижилтын ажлыг хийж гүйцэтгэлээ.	
/28/ 1.5.7 Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.	135	1.5.7.1. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, оролцоог нэмэгдүүлж, аймаг, орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах		АИТХ, АЗДТГ, НБХ, ГБХЗХГ, СЗДТГ, АЭХолб оо	-	Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхээс 10-аас дээш хувиар нэмэгдэж, бусад чиглэлд эмэгтэйчүүдийн манлайлал оролцоо өсөн нэмэгдсэн байна.	Манай аймаг 2017 оны жилийн эцсийн байдлаар 62026 хүн амтайгаас 31475 нь буюу 50.7 хувь нь эрэгтэй, 49.3 нь эмэгтэй байна. Үүнээс хөдөлмөрийн насны 36258 хүний 49.7 хувь нь эмэгтэйчүүд, ажилгүй иргэдийн 48.7 хувь буюу 491 нь эмэгтэйчүүд байгаа нь нийт ажилгүйчүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 2016 оны мөн үеэс 18.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн ИТХ-ын нийт төлөөлөгчдийн 18.2 хувь нь эмэгтэй 81.8 хувь нь эрэгтэйчүүд байна. Төрийн албанд нийт 4541 төрийн албан хаагч ажилладгаас 2877 нь буюу 63.3 хувь нь эмэгтэй, 36.6 хувь нь эрэгтэй байна. Үүнээс шийдвэр гаргах түвшинд нийт 315 албан хаагч ажилладгаас 157 нь буюу 49.8 хувь нь эмэгтэй албан хаагч ажиллаж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.3 хувиар өссөн байна. Энэ нь сүүлийн үед улс төр, нийгмийн харилцаанд эмэгтэйчүүдийн идэвх оролцоо улам бүр нэмэгдэж, эмэгтэйчүүдийн улс төрийн мэдлэг өргөжин тэлсэнтэй холбоотой юм. Харин төрийн захиргааны удирдах албан тушаалтны хувьд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 42.6 хувь байгаа нь хуульд заасан хэмжээнээс 2.6 хувиар илүү байна.	100
	136	1.5.7.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг ханган, жил бүр жендэрт суурилсан, жендэрийн мэдрэмжтэй судалгаа хийж, салбар дундын мэдээллийн санг бий болгох		АЗДТГ, НБХ, ГБХЗХГ, СЗДТГ, АЭХолб оо	Улс, ОНТөсө в	Суурь судалгааг бүрэн хийж салбар дундын мэдээллийн санг үүсгэн эмхэтгэл гаргаж, /гарын авлага/ төрийн албан хаагчдын болон бусад чиглэлээр	Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтны хүрээнд эрүүл мэнд, боловсролын салбарт эмэгтэйчүүдийн эзлэх хувь хуульд зааснаас 13.2 хувиар өндөр байгаа нь тухайн салбарын онцлог бөгөөд энэ харьцаа 2013 онд 33.3 хувиар өндөр байсан боловч хөтөлбөр хэрэгжсэний үр дүнд даруй 20.0 гаруй хувиар буурсан байна. Өнөөгийн энэ байдалд дүгнэлт хийж улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог хангахад тохиолдож байгаа бэрхшээлийг арилгах, гэр бүлийн хөгжлийг дэмжих, шийдвэр гаргах болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг эн тэргүүнд тавьж байна.	100

						ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.		
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ								
<u>2.1 Эдийн засаг:</u>								
Эдийн засгийн өсөлтийг дэмжин, технологийн дэвшилд суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлж, баялгийг бүтээн орлогыг нэмэгдүүлж, сэтгэл хангалуун аз жаргалтай амьдралыг хамтдаа бүтээнэ.								
/29/ 2.1.1 Бизнесийн таатай орчинг бүрдүүлж, үйлдвэрлэлийг хөгжүүлж дотоодын нийт бүтээгдэхүүнийг жил бүр нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.	137	2.1.1.1. Эдийн засгийн хөгжлийн 2016-2020 оны үндсэн зорилтуудыг хэрэгжүүлж, аймгийн нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээг 25 хувиар нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, Сумын ЗДТГ		Хүн амын амьжиргааны түвшин дээшилж, нэг хүнд ноогдох ДНБ-ийг 5.7 сая төгрөгт хүргэнэ.	2017 оны жилийн эцсээр 286.8 тэрбум төгрөгийн ДНБ үйлдвэрлэж, нэг хүнд ноогдох ДНБ 4.7 сая төгрөг болсон. 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ДНБ 291.5 тэрбум төгрөг болж, өмнөх жилээс 4.7 тэрбум төгрөгөөр өсөхөөр байна.	100
<u>2.2 Хүнс, хөдөө аж ахуй:</u>								
Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болгон, байгаль, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон, дэвшилтэт технологид суурилсан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бэлчээр, тариалангийн талбайг нөхөн сэргээх, малын үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх ажлыг шинэ шатанд гаргана.								
Мал аж ахуй:								
/30/ 2.2.1. Малын үржлийн ажил, үйлчилгээ, малын чанарыг сайжруулах замаар эдийн засгийн өсөлтийг хангана.	138	2.2.1.1. “Сэлэнгэ” үүлдрийн үхрийг сонгон үржүүлэх бүс нутагт үржлийн төв байгуулж, “Сэлэнгэ” үүлдрийн үхрийн удмын санг хамгаалж, өсгөн үржүүлж, ашиг шимийг нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Улсын төсөв 12.0 сая.төг	Сэлэнгэ суманд үржлийн төв байгуулж, Сэлэнгэ үүлдрийн үхрийн махны гарц 50-60 кг-аар нэмэгдсэн байна.	2018 онд “Сэлэнгэ үүлдрийн үхрийг өсгөн үржүүлэх” дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ИТХ-аар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна. “Сэлэнгэ үүлдрийн үхрийн үржлийн төв” байгуулахаар судалгааны ажил хийгдэж байна. “Шинэ хөдөө” төслийн хүрээнд “Сэлэнгэ” үүлдрийн үхэр үржүүлэх бүс нутаг болох Тэшиг, Хутаг-Өндөр, Хангал, Бугат сумдад 100 “Сэлэнгэ” үүлдрийн бух, Сэлэнгэ суманд 25 “Герефорд” үүлдрийн бухыг тус тус хүлээлгэн өглөө. Уг төслийн хүрээнд ирэх жил Сэлэнгэ үүлдрийн үхэрт зохиомол хээлтүүлэг хийхээр зохиомол хээлтүүлгийн иж бүрэн багаж 2 ширхэгийг, Герефорд үүлдрийн бухнаас 6000 тун үр авч хадгалсан. Мерси Кор ОУБ-аас 36 298 200 төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хутаг-Өндөр суманд “Герефорд” үүлдрийн 10 ш бух үржлийн чиглэлээр өгсөн.	100
	139	2.2.1.2. “Хангай” үүлдрийн хонины удмын	2016-2020	АЗДТГ, ХХААГ,	ОНТөсө в	Орхон, Бүрэгхангай	Аймгийн Засаг даргын Хөрөнгө гаргах тухай 2018 оны А/318 дугаар захирамжаар “Хангай” үүлдрийн	70

		санг хамгаалж, өсгөн үржүүлж, ашиг шимийг нэмэгдүүлэх		СЗД	10.962.800	сумдад өсгөн үржүүлж, ноосны гарц 300-500 гр-аар нэмэгдсэн байна.	хонийг үржүүлж эхэлсний 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө, шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж хэрэгжилтийг хангаж ажилласан. “Хангай” үүлдрийн хонийг Сэлэнгэ сумын 4-р багт шилжүүлэн битүү дулаан байр барьж өвөлжүүлж байна. Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумаас хээлтүүлэгч сонгон авч хээлтүүлэгт ашиглаж байна. Орхон суманд “Хангай” үүлдрийн хонь үржүүлж эхэлсний 60 жилийн ойн “Дурсамж” уулзалтыг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд аймгийн Засаг даргын орлогч О.Гантулга, ХХААГ-ын дарга Ч.Амгалан, МУ-ын Хөдөлмөрийн баатар, Монголын МАА-н академийн “Хүндэт профессор” малчин Л.Полоо, МУ-ын Төрийн соёрхолт, зөвлөх мал зүйч Г.Алтангэрэл, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт малын эмч Ч.Алтангэрэл, Улсын аварга малчин Д.Авирмэд зэрэг нийт 80 гаруй мэргэжилтэн, малчид оролцлоо.	
	140	2.2.1.3. Бог малын үржлийн ажлыг мэргэжлийн байгууллагад шилжүүлж, стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчээр хангах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Төсөл 240.0 сая.төг	Бог малын үүлдэр угсаа, чанар сайжирч, стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчээр хангагдсан байна.	Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах, нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор “Шинэ хөдөө” төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумаас “Эрчмийн хар” үүлдрийн 245 ухна, Ренчинлхүмбэ, Цагааннуур сумдаас “Дархад” үүлдрийн 122 хуцыг бруцеллёз, бог малын мялзан, шүлхий өвчний шинжилгээнд хамруулан Хутаг-Өндөр суманд тус тус хүлээлгэн өглөө. Цөм сүрэг бүхий малчин өрхөөс өсвөр хээлтүүлэгч бойжуулах зорилгоор Бүрэгхангай сумын 2-р багийн хуц, ухны суурь, Дашинчилэн сумын 2, 3-р багийн 11 малчин өрхийн сууриар орж, үзлэг хийж, ирэх жил өсвөр хээлтүүлэгч бойжуулах талаар малчидтай санал солилцсон. Дашинчилэн сумын 2-р багийн “Цахт” гэдэг газар үржүүлж байгаа 8 малчин өрхийн 10.0 мянган хонинд эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нарийвчлан хийхээр орон нутгийн ахмад, дунд, залуу үеийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахаар болсон.	100
	141	2.2.1.4. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослуулж,	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Төсөл 500.0 сая	5-аас доошгүй үхэр, хонины аж ахуй байгуулагдаж, малчин өрхийн	Мал аж ахуйн талаар баримтлах аймгийн бодлогыг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. “Шинэ хөдөө” төслийн хүрээнд “Сэлэнгэ” үүлдрийн үхэр үржүүлэх бүс нутаг болох Тэшиг, Хутаг-Өндөр, Хангал, Бугат	70

		үхэр, хонины аж ахуйг махны чиглэлээр хөгжүүлж, мах экспортлох				орлого нэмэгдэнэ.	сумдад 100 “Сэлэнгэ” үүлдрийн бух, Сэлэнгэ суманд 25 “Герефорд” үүлдрийн бух, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумаас “Эрчимийн хар” үүлдрийн 245 ухна, Ренчинлхүмбэ, Цагааннуур сумдаас “Дархад” үүлдрийн 122 хуцыг бруцеллээ, бог малын мялзан, шүлхий өвчний шинжилгээнд хамруулан Хутаг- Өндөр суманд тус тус хүлээлгэн өгсөн. Цөм сүрэг бүхий малчин өрхөөс өсвөр хээлтүүлэгч бойжуулах зорилгоор Бүрэгхангай сумын 2-р багийн хуц, ухны суурь, Дашинчилэн сумын 2, 3-р багийн 11 малчин өрхийн сууриар орж, үзлэг хийж, ирэх жил өсвөр хээлтүүлэгч бойжуулах талаар малчидтай санал солилцсон.	
	142	2.2.1.5. Эрчимжсэн мал аж ахуй болон гахай, шувуу, зөгийн аж ахуй эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжих	2016- 2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн тоо өсөж, 8-аас доошгүй иргэн, аж ахуй нэгж хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна.	Булган аймагт 2018 онд зөгий үржүүлэгчдийн холбоо байгуулагдаж, “Зөгий” дэд хөтөлбөрийг боловсруулж, сумдад хэлэлцүүлэг зохион байгуулагдаж байна. Монголын зөгийчдийн холбоо Хутаг-Өндөр, Тэшиг, Бүрэгхангай, Булган, Хишиг-Өндөр, Могод сумдад зөгий үржүүлэх боломжтой балт ургамлын нөөцтэй гэсэн судалгаа гаргасан тул дээрх сумдад зөгий үржүүлэхийг дэмжих хэрэгтэй гэсэн зөвлөмжийг ирүүлсэн. Сэлэнгэ суманд Япон улсын хөрөнгө оруулалттай Oiska ТББ-аас 2 жилийн хугацаатай “Зөгийн аж ахуйг дэмжих” төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд орон нутгийн зөгийн аж ахуй эрхлэгчид болон сумдын удирдлагууд Япон улсад 2 удаа туршлага судлан, зөгийн бүтээгдэхүүнээ дэлхийн зах, зээлд гаргахаар гэрээ хэлэлцээр байгуулсан нь шинэлэг ажил боллоо. Төслийн хүрээнд 70 иргэнийг зөгийчний сертификаттай сургалтанд хамруулж, зөгийн бэлчээрийн ойн санд 3000 мод тарьж, 500 ширхэг цагаан цээнэ цэцэг нутагшуулж 10 өрхөд 10 бүл зөгий олгогдсон. Цаашид аймгийн “Зөгий” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг зөгийн үйл ажиллагаатай хослон эрхэлж эрчимжүүлснээр, загвар нөхөрлөлийг бий болгох зорилт тавин ажиллаж байна. Гахайн өрхийн аж ахуйн чиглэлээр 28 өрхийн 280 толгой гахай, тахиа, шувууны чиглэлээр 40 өрхийн 368 толгой тахиа үржүүлж байна.	70
	143	2.2.1.6. Эрчимжсэн мал	2016-	АЗДТГ,		Өндөр ашиг	Монголын фермерийн холбоотой хамтран тус аймагт	70

		аж ахуй эрхэлж буй фермерүүдийг эзэмшлийн газартай болгож, мал аж ахуй, газар тариаланг хослон хөгжүүлэх	2020	ХХААГ, СЗД		шимтэй малын нийт сүрэгт эзлэх тоо хэмжээ өсч, нэг малаас авах ашиг шимийн үзүүлэлт нэмэгдэнэ.	үйл ажиллагаа явуулж байгаа мах болон сүүний чиглэлийн 4 аж ахуйг иж бүрнээр нь дэмжихээр санал солилцлоо. Бүгд Найрамдах Солонгос Улсын Жоннам мужийн захиргаа, Гадаад харилцааны албаны хүмүүстэй уулзаж санал бодлоо солилцож, шинэ техник, технологи инноваци нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах саналаа хүргүүлсэн. Сум хөгжүүлэх сангаас 4 иргэнд үхрийн фермерийн аж ахуй байгуулахад 36.0 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн байна. “Мерси кор” ОУБ, “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран мах үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахуй нэгжүүд оролцсон цуврал 4 удаагийн давтамжтай өдрийн сургалтыг зохион байгуулж 117 хүн хамрагдсан.	
	144	2.2.1.7. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тэжээл үйлдвэрлэгчдийг нэг болон олон наст ургамлын үр, бага оврын техник тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Нэгжээс авах ургацын хэмжээ нэмэгдэж, техник тоног төхөөрөмжийн хангамж сайжирна.	Малын тэжээлийн ургамлыг 910 га талбайд тариалсан. Мөн 3500 га талбай тэжээлийн ургамалд шилжиж 4918 тн ногоон тэжээл хураан авсан. “Мерси кор” ОУБ-аас Хангал сумын “Амуун далай” ХХК-д тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, хаман боогч худалдан авахад нь 20.0 сая, Хутаг-Өндөр сумын “Очирван” ХХК-д 12.0 сая, “Хутаг-Эко” ХХК-д 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр тэжээл үйлдвэрлэн орон нутгийн малчдад борлуулалт хийлээ. ХХААХҮЯ-аас хөнгөлттэй нөхцөлөөр олгогдсон Дашинчилэн сумын “Муку” ХХК-ны бага оврын тэжээлийн үйлдвэр нь орон нутгийн хэмжээнд тэжээл үйлдвэрлэж орон нутгийн иргэдийг хангаж байна.	100
	145	2.2.1.8. Мал аж ахуйн мэргэжилтнүүдийг бэлтгэх, давтан сургах ажлыг тодорхой бодлого төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Мал аж ахуйн мэргэжилтнүүд ийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар дээшилнэ.	Аймгийн МАА-н мэргэжилтний зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, аймгийн Засаг даргын орлогч О.Гантулга, ХОХБТХ-ийн мэргэжилтэн Ц.Энхмаа, ХХААГ-ын дарга, албаны дарга, мэргэжилтнүүд, сумдын удирдлага МЭҮТ-ийн мэргэжилтэн, МЭҮН-ийн малын эмч нар оролцож, салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар ярилцсан. Сумдын малчид, төлчдийн зөвлөгөөнд салбарын мэргэжилтнүүд оролцож, мэдээлэл өгч ажиллалаа. Мал аж ахуйн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх хүрээнд ХААИС-тай хамтран ажиллаж, шинээр төгссөн төгсөгчдийг ажлын байраар хангахад анхаарч	100

						ажиллаж байна. Малын эмч мэргэжилтэй төгсөгчдийг хувийн мал эмнэлэг нээж ажиллуулахад эхний жил стандарт шаардахгүйгээр дэмжлэг үзүүлж, зөвлөгөө заавар өгч ажиллуулж байна. Мөн Булган аймгийн ХАА-н МСҮТ-тэй хамтран ажиллаж, мал эмнэлгийн санитарч бэлтгэх, 1 жилийн ангийг нээсэн. ХАА-н салбарын мэргэжилтнүүдийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, чадавхижуулах хүрээнд энэ онд 5 мэргэжилтэн сургалтанд хамрагдсан. Сумдын МЭҮ-ийн тасгийн малын эмч нарт хонины цэцэг өвчний талаар 2 хоногийн сургалтыг 5 дугаар сард зохион байгуулсан. БНХАУ-д “Экологийн өрсөлдөх чадвар” олон улсын чуулган уулзалт, мал аж ахуй мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтанд сумдын МЭҮТ-ийн 2 мэргэжилтэн 30 хоног хамрагдаж сертификат авлаа. УХЭШХүрээлэн, МХГ-тай хамтран зохион байгуулсан “Бэлчээр хамгааллын сургалт”-д 11 сумын удирдлага, МЭҮТ-ийн мэргэжилтэн, БОУ Байцаагч, газрын даамал, багийн Засаг дарга, малчид 100 гаруй хүн оролцлоо. “Зах зээл бэлчээрийн удирдлага”-ын төслийн хүрээнд бэлчээр, ус хариуцсан мэргэжилтэн 2 удаа сургалтанд оролцов. МУСҮТ-тэй хамтран сумдын МАА-н мэргэжилтнүүдийг МУСҮТ-н цогцолбор аж ахуйн үйл ажиллагаатай танилцах, үр хөврөл шилжүүлэн суулгах, зохиомол хээлтүүлэг хийх туршлага судлах сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл хангаж байна.	
146	2.2.1.9. Бүх суманд малчдын сургалтын төв байгуулж, түүгээр дамжуулан танхимын, талбайн, өрхийн сургалтуудыг явуулах, тэргүүний сайн малчдын туршлагыг эзэмшүүлэх, дагалдуулах замаар мал маллагааны уламжлалт болон дэвшилтэт арга ажиллагаанд сургаж, мэргэшүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Зах зээлийн нөхцөлд аж ахуйгаа үр дүнтэй эрхлэн хөтлөх мэдлэг чадвартай болсон байна	Булган аймгийн Дашинчилэн, Могод, Сэлэнгэ, Хутаг-Өндөр сумдад малчдын бүсчилсэн зөвлөгөөнийг 2018 оны 6-р сарын 5-9-ний өдрүүдэд зохион байгуулж, аймгийн Засаг даргын орлогч О.Гантулга, ЗДТГ, ХХААГ-ын мэргэжилтнүүд, сумын удирдлагууд, малчид, МЭҮТ-ийн мэргэжилтнүүд нийт 812 хүн оролцов. Уг арга хэмжээнд ХХААХҮЯ-ны МААБХЗГ-ын мэргэжилтэн Н.Бямбадорж, МЭҮГ-ын мэргэжилтэн Д.Эрхэмбаяр нар “Малын генетик нөөцийн тухай хууль”, “Малын эрүүл мэндийн тухай хууль”-ийн танилцуулга хийсэн. Мөн Хишиг-Өндөр сумын малчдын зөвлөгөөнд 70, Гурванбулаг сумын зөвлөгөөнд 150, Сайхан, Орхон сумын малчдын зөвлөгөөнд 160 малчин нийт 1300 малчид оролцож, малчдад шинээр батлагдсан хуулиудын танилцуулга	100

						хийгдэн, “Бэлчээрээ хамгаалах зөвлөмж”-ийг хэлэлцэн баталж, малчдын урам зоригийг сэргээсэн үр дүнтэй арга хэмжээ боллоо. Зөвлөгөөний үеэр Сэлэнгэ суманд Шилмэл мал, сүү цагаан идээний үзэсгэлэн худалдаа, малын зохиомол хээлтүүлгийн үзүүлэх сургалт, Хутаг-Өндөр суманд үхрийн эрчимжсэн аж ахуй, мах, сүүний үйлдвэртэй танилцах зэрэг арга хэмжээнүүд амжилттай зохион байгуулагдсан. Орхон суманд “Хангай” үүлдрийн хонь үржүүлж эхэлсний 60 жилийн ойн “Дурсамж” уулзалтыг зохион байгууллаа.	
/31/ 2.2.2. Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар бэлчээрийн даацыг нэмэгдүүлнэ.	147	2.2.2.1. Бэлчээрийн ургамалд хор хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтан, шавжтай тэмцэх үйл ажиллагааг байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга технологи ашиглан өргөжүүлж, олон улсад туршигдаж, үр дүнгээ өгсөн арга туршлагыг нэвтрүүлж, бэлчээрийг үе шаттайгаар нөхөн сэргээх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Улсын төсөв 80.0 сая,төг	80.0 мянган га-аас доошгүй бэлчээрийн талбайд ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. 2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 50.0 мянган га талбайд бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх ажлын 180424/04-117 тоот гэрээг ХХААХҮЯ-тай байгуулсны дагуу аймгийн Засаг даргын 2018 оны А/253 дугаар захирамжаар Баяннуур, Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг, Могод, Орхон, Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Сайхан, Баян-Агт, Булган сумдад 80.0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар ургамал хамгааллын арга хэмжээг гүйцэтгэсэн. Ургамал хамгаалал хорио цээрийн улсын байцаагчийн дүгнэлтээр хортон мэрэгчидтэй тэмцэх ажил аймгийн түвшинд 83.0 хувь буюу “Сайн” хэрэгжүүлсэн гэж дүгнэгдсэн. УХЭШХүрээлэн, МХГ-тай хамтран "Бэлчээр хамгааллын сургалт" зохион байгуулж 11 сумын удирдлага, МЭҮТ-ийн мэргэжилтэн, БОУБайцаагч, газрын даамал, багийн Засаг дарга малчид 100 гаруй хүн оролцлоо. Мөн Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Ногоон алт-малын эрүүл мэнд” төсөлд Дашинчилэн, Могод, Хишиг-Өндөр, Орхон, Сайхан сум хамрагдаж, бэлчээрийг зүй зохистой ашиглах, малчдын дунд бэлчээр ашиглагчдын хэсэг байгуулах, малчдын дундын сангийн хуримтлал бий болгох чиглэлээр сургалтуудыг зохион байгуулж эхлээд байна. “Мерси-Кор” ОУБ-аас Хангал, Хутаг-Өндөр, Баяннуур сумдад “Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалт”-ыг зохион байгуулж, 50 гаруй мэргэжилтэн, малчид хамрагдсан. “Хөгнө Мээж” ТББ-тай хамтран бэлчээрийн менежментийг сайжруулах сургалтыг 13 сумын 53 багт зохион байгуулж, баг бүрийн бэлчээрийн төлөв байдлын зураглалыг хэвлүүлэн	70

							самбар гарган хүлээлгэн өгсөн. Мөн Бүгд найрамдах Хятад Ард улс, Монгол улсын шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны гэрээний дагуу “Доройтсон бэлчээрийг зайнаас тандах аргаар судалж, сайжруулах туршилт судалгаа” төсөл Рашаант, Дашинчилэн, Гурванбулаг сумдад хэрэгжиж эхэллээ.	
	148	2.2.2.2. Бэлчээрийн даац, төлөв байдлын судалгаанд тулгуурлан, эдийн засгийн оновчтой хөшүүргийг ашиглан малын тоо, төрөл, сүргийн зохистой бүтцийг тогтоох	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	500,0 сая	Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэн хөтлөх үйл ажиллагаа сайжирна.	Бэлчээрийн төлөв байдлын судалгааны үр дүнд сум тус бүрээр бэлчээрийн даацыг тодорхойлж, уг даацад тохирох малын тоо толгойг сум тус бүрээр гаргасан. Үүний үр дүнд манай аймгийн малын тоо 5-7 дахин хэтэрсэн тооцоо гарсан. Иймд малчдад эр сувай малыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, даацаас хэтэрсэн малыг зах зээлд борлуулах зэрэг арга хэмжээг авч байна. Энэ онд 1.1 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэнд оруулах тооцоо гарч байна.	100
	149	2.2.2.3. Усан хангамж дутагдалтай байгаа бэлчээрт худаг гаргах замаар бэлчээр усжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	ОНТөсө в 108,0 Улсын төсөв 360,0	25.0 мянган га-аас доошгүй бэлчээр усжуулагдсан байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7 худгийг “Монтего” ХХК, “Булган-Ус” ХХК-иуд 129.8 сая төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтаар “БИММ” ХХК, “Таширын хүрээ” ХХК-иуд 22 худгийг 340.0 сая төгрөгөөр, малчны санаачилгаар 1, нийт 30 худаг 16 суманд гаргаснаар 150 малчин өрхийн 135.0 мянган толгой малыг усаар хангаж, 42.0 мянган га бэлчээрийг усжуулах нөхцөл бүрдлээ.	100
132/ 2.2.3 Хөдөөгийн иргэдийн хөдөлмөр, хөрөнгөөрөө хоршин ажиллаж, орлогоо нэмэгдүүлэх, боломж нөхцлийг бүрдүүлнэ.	150	2.2.3.1. “Хоршоо хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр II”-ийг хэрэгжүүлж, “Хоршоо хөгжүүлэх сан” бий болгох замаар хоршоологчдыг дэмжих	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Хоршоодын үйл ажиллагаа сайжирч, 10-аас доошгүй хоршоо шинээр байгуулагдсан байна.	2018 онд Хоршоог биржийн арилжаанд оруулах ажлын хүрээнд ХХААХҮЯ-наас баталсан удирдамжийн дагуу 16 сум 1 тосгоны улсын бүртгэлд бүртгэлтэй 149 хоршоонд хөгжлийн үнэлгээ хийсэн. Хоршоо нь 6800 орчим гишүүнтэй байгаа бөгөөд үүнээс 2 нь тогтвортой өсөлттэй буюу загвар хоршоо, 30 нь хөгжиж байгаа, 32 нь идэвхжиж байгаа, 14 нь идэвхгүй, 54 хоршоо нь аж ахуйн нэгж болох, татан буугдах хүсэлт гаргасан байна. “ХАА-н хоршоологчдын холбоо”-ноос “ХАА-н тогтвортой хөгжилд хоршоодын оролцоо” сэдэвт улсын зөвлөгөөнийг хийсэн бөгөөд энэхүү арга хэмжээнд манай аймгаас 3 хоршооны төлөөлөл оролцсон. Арга хэмжээний үеэр ХАА-н биржийн холбогдох албан тушаалтан биржийн арилжаанд хоршоо хэрхэн оролцох талаар мэдээлэл хийсэн бөгөөд аймгийн ХАА-н хоршоологчдын холбоотой хамтран загвар	70

						хоршоодыг дэмжиж, биржийн арилжаанд оролцуулах боломж нөхцөлөөр хангахаар ажиллаж байна.	
151	2.2.3.2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн түүхий эдийн нөөцөд түшиглэсэн боловсруулах үйлдвэр, цехийг аймгийн төв, сумдад бүсчилж хөгжүүлэх /ноос угаах, арьс шир, сүү, сүүн болон мах, махан бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэр цех, айраг савлах, хөхүүр, суран эдлэл хийх, дотор мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах гэх мэт/	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Сүү,сүүн бүтээгдэхүүн, махны болон мах боловсруулах, айраг савлах, хөхүүр, суран эдлэл хийх, бусад бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр цехийг аймгийн төв болон сумдад бий болгосон байна.	-Хутаг-Өндөр суманд 1.5 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгөөр “Булган мах маркет” ХХК-ийн өдөрт 100 бод, 500 бог нядлах хүчин чадалтай махны үйлдвэр ашиглалтад орж, бүс нутгийнхаа малчдаас 2.7 тэрбум гаруй төгрөгийн мал худалдан авч, эдийн засгийн эргэлтэд орууллаа. -Булган сумын үйлдвэрлэлийн бүсэд Польшийн компанийн 20-30 сая еврогийн хөрөнгө оруулалтаар Мах боловсруулах цогцолбор аж ахуй байгуулахаар тохиролцоонд хүрээд байна. -Булган сумын улсын төсвийн хөрөнгөөр дутуу баригдсан мах бэлтгэх, хөргүүртэй зоорийг гүйцээж, ашиглалтад оруулах, зохицуулалт хийснээр аж ахуйн нэгж нь хашаа барьж, цахилгаан эрчим хүч татаж, цэвэр, бохир усны дэд бүтцийг шийдвэрлэж, өргөтгөлийн барилга барихаар бэлтгэж байна. -“Буман сүхэс” хиамны цехийг үйлдвэрлэлийн байраар хангаж дэмжлэг үзүүллээ. - Булган сумын “Бүрэн луу” ХХК сүү боловсруулах үйлдвэр байгуулахаар барилга объектод капитал засвар хийж дэд бүтцийг шийдвэрлэн, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэж, дулаан боловсруулалтын цехийн өргөтгөл барих ажлаа эхлүүлсэн. -Тэшиг суманд бяслагны үйлдвэрлэл эхлэлээ тавьж, Сэлэнгэ суманд Халзаадай тараг савлагдаж эхэллээ. -Хутаг-Өндөр сум “Монголын хуурай сүү” ХХК-тай хамтран хуурай сүүний үйлдвэр байгуулахаар үйлдвэрийн байрыг бэлтгэж, тоног төхөөрөмжийг суурилуулаад байна. Канадын элчин сайдын яамнаас тус сумын “Бялхам үндэс” ТББ-ын сүү цагаа идээ үйлдвэрлэлийн төсөлд 42.0 сая төгрөгийн дэмжлэг олгож, цехийн үйл ажиллагаа явж байна. - Булган Анар ХХК нь 2006 оноос эхлэн айраг савлах туршилт судалгааны ажлыг эхлүүлж, 2014 онд уламжлалт аргаар эсгэсэн “Булганы айраг” бүтээгдэхүүний CS63:23:2014 байгууллагын стандартыг боловсруулан батлуулж, 2017 онд жилд нийт 90 тн айраг савлах хүчин чадал бүхий 30 тн-ын багтаамжтай хөргүүртэй камер, сав үлээх цех ашиглалтад оруулж, 0.5, 1.5, 5 литрээр савлаж, дотоодын зах зээлд нийлүүлж байна.	70	

Мал эмнэлэг:							
/33/ 2.2.4 Мал эмнэлгийн үйлчилгээний олон улсын жишиг, стандартын шаардлагад нийцсэн, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг хангасан тогтолцоог бүх шатанд бүрдүүлж, мал эмнэлгийн нэгжүүдийг чадавхижуулж, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагыг өндөржүүлж, халдварт өвчингүй байх нөхцлийг хангана.	152	2.2.4.1. Малын халдварт, гоц халдварт өвчний тандалт, хяналтыг тогтмолжуулж эрсдэл бүхий бүс нутгийн мал сүргийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж, эрүүлжүүлэлтийн үр дүнг сайжруулах	2016-2020	ХХААГ, СЗД	Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдвал зохих мал, амьтдыг бүрэн хамруулна.	Аймгийн хэмжээнд жилд дунджаар 10-11 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 697.7 мянган мал, амьтан, паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 1688.0 мянган мал, амьтан хамруулж 122.6 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа. УМЭАЦТЛ-той хамтран шүлхий, бруцеллэз, гахайн мялзан өвчнийг тандах шинжилгээ хийхээр гэрээ байгуулан ажилласан. Шүлхий өвчнийг тандах шинжилгээнд Булган, Бугат, Орхон, Сайхан, Хишиг-Өндөр сумдаас санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэн нийт 66 өрхөөс 552 дээжинд болон бруцеллэз өвчний шинжилгээнд аймгийн хэмжээнд бух 603, үнээ 101, хуц 8138, хонь 150, ухна 4236, ямаа 150 нийт 13378 дээж авч тус тус шинжилгээ хийлээ. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 13 нэр төрлийн 303.4 сая төгрөгийн эм биобэлдмэлийг Биокомбинатаас хүлээн авч, сумдад олгосон. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 697.7 мян.тол мал хамруулж 78.2 хувийн, бруцеллэзын вакцинжуулалтад 656.5 мян.тол мал хамрагдаж 85.6 хувийн гүйцэтгэлтэй. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний 672000 тун вакциныг хүлээн авч, 553.6 мян толгой мал хамрагдаж, вакцинжуулалтын ажил технологийн дагуу явагдаж байна. Гахайн мялзан өвчнийг тандах шинжилгээнд Булган, Тэшиг, Сэлэнгэ сумдаас нийт 40 гахайн цус авч ийлдэсийг ялган УМЭАЦТЛ-д хүргүүлэн ажиллалаа.	70
	153	2.2.4.2. Малын бруцеллэз, адууны ям, халдварт цус багасах өвчин, үхрийн лейкоз, сүрьеэ өвчний тандах, эрүүлжүүлэх шинжилгээг чанартай зохион байгуулж халдвар тархахаас сэргийлж, улмаар халдварлалтын түвшинг бууруулах	2016-2020	ХХААГ, СЗД	Шинжилгээнд хамрагдвал зохих мал, амьтдыг бүрэн хамруулж, халдварт өвчний гаралтыг бууруулсан байна.	Бруцеллэз өвчний шинжилгээнд аймгийн хэмжээнд бух 603, үнээ 101, хуц 8138, хонь 150, ухна 4236, ямаа 150, үхэр 320 нийт 13698 дээж авч шинжлэгдсэн байна. Шинжилгээний дүнгээр Баяннуур, Булган, Тэшиг, Хангал сумдаас бусад 12 сумдад 63 хуц, 72 ухна эерэг дүн үзүүлсэн ба хариуг сумдад хүргүүлэн авах арга хэмжээг зөвлөсөн. Сайхан сумын адуунд ям, Тэшиг, Хутаг-Өндөр сумын үхэрт сүрьеэ өвчний сорил тавьж халдварлалт, тархалтыг илрүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгээд байна. Сайхан сумын 4 багт 2856 адуунд биокомбинатад үйлдвэрлэсэн ямлуураар сорил тавьсан. Мөн Тэшиг, Хутаг-Өндөр сумдад 937	100

							үхэрт сорил тавьсан. Сорилыг биокомбинатад үйлдвэрлэсэн сүрьеэ илүүрийг ашигласан байна.	
	154	2.2.4.3. Байгаль орчин, хүн малд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологи нэвтрүүлэн, халдварт өвчний голомтыг устгах, ариутгал халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулж, мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах	2016-2020	ХХААГ, СЗД		Ариутгал халдваргүйжүүлэлтийг чанартай зохион байгуулж, халдварт өвчний голомтыг цаг тухай бүрт нь устгаж мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл сайжирна.	Байгаль орчин, хүн малд сөрөг нөлөөгүй ариутгалын бодис болох Hi сор-оор ариутгал хийгдэж байгаа ба энэ онд шинээр ариутгалын дүк машинтай боллоо. Халдварт өвчний голомтыг устгаж, ариутгал халдваргүйжүүлэлт хийж 16 сумын хэмжээнд эхний хагас жилд 1087085 м2, сүүлийн хагас жилд 54873 м2 хашаа, хороо, худаг уст цэг, бэлчээрийн талбай ариутгаад байна.	100
	155	2.2.4.4. “Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан МЭҮТ-г сум бүрт бэхжүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр хангах	2016-2020	ХХААГ, СЗД		Сумдад мал эмнэлгийн ажил үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах, хяналт тавих ажил мэргэжлийн түвшинд чанартай хийгдэнэ.	2018 онд 16 сумын МЭҮТ-т 12 малын их эмч, улсын байцаагч, болон хувийн 41 МЭҮН-тэй гэрээ хийсэн. Шинээр Бүрэгхангай, Орхон, Хутаг-Өндөр сумдад тус бүр 1, нийт 3 хувийн мал эмнэлэг үржлийн нэгж байгуулагдсан. Хутаг-Өндөр, Бүрэгхангай, Сэлэнгэ сумдын МЭҮТасагт малын эмч дутагдалтай байна.	70
	156	2.2.4.5. Баг бүрт хувийн мал эмнэлэг, үржлийн нэгжийг үүсгэж, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, мэргэжилтний хүрэлцээ хангамж, чадавхийг сайжруулах	2016-2020	ХХААГ, СЗД		Мал эмнэлэг, үржлийн нэгжийн өрсөлдөөн үүсч, ажил, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна	2018 онд аймгийн хэмжээнд 47 хувийн мал эмнэлэг, МЭҮТ-т 12 малын их эмч, улсын байцаагч, 3.3 сая малд мал эмнэлгийн ажил, үйлчилгээг хүргэж байгаа бөгөөд нэг мал эмнэлэгт дунджаар 68.0 мянган толгой мал ноогдож мал эмнэлгийн арга хэмжээг хүргэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд жилд дунджаар 10-11 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 697.7 мянган мал, амьтан, паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 1688.0 мянган мал, амьтан хамруулж 122.6 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа.	70

	157	2.2.4.6. Олон улсын жишигт нийцсэн 2-р зэрэглэлийн шаардлага хангасан мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн өргөтгөл барих	2016-2020	ХХААГ	Улсын төсөв 35.5 сая.төг Улсын төсөв 20.3 сая.төг	Мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн багаж, тоног төхөөрөмжүүд ийг бүрэн суурилуулна.	Лабораторийн өргөтгөлийн барилга барихаар төлөвлөж, зураг төсвийн ажлыг 35.5 сая төгрөгөөр Орхон аймгийн “Вилл Конн” ХХК-аар хийлгүүлсэн. Барилгын геологийн хайгуулын ажлыг “Варнав” ХХК хийж, дүгнэлт гаргуулж, аймгаас хэрэгжүүлэх ажлыг бүрэн гүйцэтгээд байна. Энэ онд санхүүжилт шийдвэрлэгдээгүй.	40
	158	2.2.4.7. Мал эмнэлгийн ариун цэврийн лабораторийг MNS ISO 17025 стандартын дагуу итгэмжлүүлэх	2016-2020	ХХААГ	Улсын төсөв 35.5 сая.төг Улсын төсөв 20.3 сая.төг	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйн дагуу шинжилгээ хийж баталгаажуулна.	MNS ISO 17025 стандартын дагуу МЭАЦЛ-ийг 2017 оны 4-р улиралд 2 жилийн хугацаатай итгэмжлүүлсэн. Итгэмжлэл хийлгэхэд шаардагдах 3.1 сая төгрөгийн зардлыг ХХААХҮЯ-наас шийдвэрлүүлсэн.	70
	159	2.2.4.8. Мал эмнэлгийн ариун цэврийн лаборатори, хог хаягдлыг ариутган халдваргүйжүүлэх, устгах байр барьж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2016-2020	ХХААГ		Хүрээлэн буй орчинд хохирол учруулахаас сэргийлж био аюулгүй байдлыг хангана.	Байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр лабораторид ирсэн дээж материалыг халдваргүйжүүлэн устгах байр барих, түүнд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, хөрөнгийн эх үүсвэрийг хайж байна.	40
	160	2.2.4.9. Хутаг-Өндөр сумын Гуртын гүүрний дэргэдэх Мал эмнэлэг, хорио цээр хяналтын цэгийн материаллаг баазыг бэхжүүлж, ажиллах нөхцлийг сайжруулах	2016-2020	ХХААГ		Ажиллагсдын ажиллах нөхцөл сайжирч, ажлын чанар дээшилнэ.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “ХАА-н маркетинг” төсөл болон орон нутгийн төсвөөр цахилгаан татаж, авто замын дэргэд хурд сааруулагч, автомат хаалт, камер бүхий хяналтын байр, түр саатуулсан зорчигчдын байртай болсон. Албан ажлын байранд халаалт оруулж, ширээ сандал, компьютерийн иж бүрдлийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 77.3 сая төгрөг олгосон. Ажил үйлчилгээний зориулалттай автомашин шаардлагатай байгааг аймгийн Засаг даргад танилцуулж, 2019 оны төсөвт тусгуулах санал тавьсан.	100
Газар тариалан:								
/34/ 2.2.5 Газар тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт шинэ	161	2.2.5.1. Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй хослон эрхлэх бүс нутгийг тогтоох	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Эрчимжсэн суурин МАА-г хөгжүүлэх болон газар	АИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар Хутаг-Өндөр сумын 1, 2, 5-р багийг тариалангийн бүс нутгаар тогтоох асуудал Засгийн газрын хуралдаанаар дэмжигдэн ЗГ-ын 2018.05.16-ны өдрийн 131 дүгээр	70

техник, технологи нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, усалгаатай талбайг нэмэгдүүлэн, эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулах замаар тогтвортой ажлын байр бий болгоно.		Үүнд: Үр тариа бүхий сум, багийн бүс нутгийг хамруулах				тариаланд дэвшилтэт технологи нэвтрүүлэх нөхцөл бүрдэнэ.	тогтоолоор батлагдаж, ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй тариалангийн талбайг хашаажуулах тендер сонгон шалгаруулалтаар Хутаг-Өндөр суманд 100 км хашааг гүйцэтгэгч компани нийлүүлж барихад бэлэн болоод байна.	
	162	2.2.5.2. Услалтын системийн ашиглалтыг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Усалгаатай тариалангийн хэмжээг 3000 га-д хүргэнэ.	“Шинэ хөдөө” төслөөс 6 сумын чацарганы талбайд тус бүр 10 га-ийн дуслын усалгааны систем суурилуулах ажил хийгдэж байна.	40
	163	2.2.5.3. Төвлөрсөн ногооны талбай бүхий 10 суманд инженерийн хийцтэй, гүний худаг гаргахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Төсөл 498,0 сая төг	Төмс хүнсний ногоо тариалах талбайн хэмжээ, ургац нэмэгдэж хүн амын хэрэгцээ хангагдана	“Шинэ хөдөө” төслийн хөрөнгө оруулалтаар нарны үүсгүүрээр ажилладаг ус өргүүр бүхий гүний худгийг Баяннуур, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр, Орхон, Булган, Баян-Агт, Хангал, Бугат сумдын чацарганы талбайд гаргалаа.	70
	164	2.2.5.4. Тариалангийн зориулалтаар эзэмшүүлсэн талбайг бүрэн эргэлтэд оруулж, таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Аж ахуйн нэгж, иргэдийн эзэмшилд байгаа тариалангийн талбайн ашиглалтыг 100 хувьд хүргэнэ.	2018 онд 42.2 мянган га-д үр тариа 97.6 хувь, 323.9 га-д төмс буюу 83.0 хувь, 149.4 га-д хүнсний ногоо буюу 100 хувьтай тариалалт хийгдсэн. Нийт тариалангийн талбайн ашиглалт 99.6 хувьтай байна.	100
	165	2.2.5.5. Техник технологи, ажиллах хүч сайтай аж ахуй нэгжийг сонгож үрийн нөөцийн 2 аж ахуй байгуулах	2016-2020	ХХААГ		Үрийн аж ахуй бэхжиж, ганд тэсвэртэй, сайн чанарын нутагшсан үрээр дотоодын хэрэгцээгээ хангана.	УГТЭШХ-аас Хутаг-Өндөр сумын “Улаан буудайн Эх газар” ХХК-тай хамтран нутагшсан сортын үр үржүүлэх зорилгоор 2017 онд тариалалт хийж, нутагшсан сортын ургац бусад сортоос давуу байсан тул хураан авсан ургацаас үр нөөцлөн энэ онд тариалалт хийсэн. Мөн УГТХ-тэй хамтран Ингэттолгой ХХК 6 төрлийн сортыг шилэн сонгох туршилтын тариалалт хийсэн. Энэ онд ОХУ-аас орж ирсэн 5 сортын 1113.6 тн элит үрийг 7850 га-д тариалсан нь ургац өндөр байна.	70
	166	2.2.5.6. Үр тарианы үйлдвэрлэлийн	2016-2020	АЗДТГ, ХХААГ,		Үр тарианы таримлын парк	“Атрын 3” аяны хүрээнд энэ онд үр тарианы 9 аж ахуйн нэгж, 1 иргэн нийт 12 комбайн болон чиргүүл	100

		дэвшилтэт технологид нийцсэн өндөр хүчин чадлын техникийн хангамжийг нэмэгдүүлэх		СЗД		шинэчлэлийг 60 хувьд хүргэнэ.	дүүжин машин авч техникийн хангамжийг нэмэгдүүлсэн.	
	167	2.2.5.7. Өрхийн тариалан эрхлэгчдийг хоршоо, бүлгийн зохион байгуулалтад оруулж дундын үйлчилгээний техникээр хангах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийн 70 хувийг механикжуулна.	“Хүнсний ногоо хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд сумын өрхийн тариаланчдыг дундын техникээр хангах төсөл, тооцооллыг хийж, ХХААХҮ-ийн сайдын багцаас хөрөнгийн дэмжлэг авахаар саналаа хүргүүлсний дээр “Шинэ хөдөө” төслийн хүрээнд зарим санхүүжилтийг шийдэхээр тооцоолоод байна.	40
	168	2.2.5.8. Хүнсний ногоо, жимс жимсгэний нэр төрлийг нэмэгдүүлэн, боловсруулах цех, “Нарлаг” хүлэмж байгуулахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Хамгаалагдсан хөрснөөс хүнсний ногооны 10 хувийг хураана.	“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ-наас олгосон төмс, хүнсний ногооны үрийг нийт сумдад хуваарилав. ТЭДС-аас 32м2 нийлэг хальсан хүлэмжийг 3 иргэн, 120м2 зуны хүлэмжийг 1 иргэнд хөнгөлөлттэй зээлээр олгосон. Булган сумын 4-р багийн иргэн Б.Амгалан өөрийн хөрөнгөөр 120 м2-ийн нарлаг хүлэмж ашиглалтад оруулан тариалалт хийв.	100
	169	2.2.5.9. “Чацаргана” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ	Байгаль хамгаалах сан 994.3 сая.төг	Эдийн засгийн үр өгөөж дээшилж, ажлын байр нэмэгдэнэ.	2018 онд “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 15000 ширхэг үхрийн нүдний суулгац, ХХААХҮЯ-наас зарласан төсөл сонгон шалгаруулалтаар 490 ширхэг үхрийн нүд, 312 ширхэг бэсрэг алим, 303 ширхэг чавганы суулгацыг Улаанбаатар хотын ТЭДСангаас гэрээ байгуулан хүлээн авч Булган, Баяннуур, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг сумдын иргэдэд хөнгөлөлттэй зээлээр олгох, тариалалтад хяналт тавих, зөвлөмж өгөх ажлыг зохион байгууллаа. “Чацаргана” төслийн хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Хар хорин” ХХК-иас 13500 ширхэг, “Хаан жимс” ХХК-иас 22437 ширхэг, нийт 35937 ширхэг чацарганы суулгацыг шинээр авч сумдад захиалгаар нийлүүлсэн. 2017 онд тариалсан суулгацын нөхөн тариалалтаар “Хар хорин” ХХК-иас 50 хувиар буюу 14426 ширхэг, “Хаан жимс” ХХК-иас 25 хувиар буюу 18331 ширхэг, нийт 32757 ширхэг чацарганы суулгацыг сумдад олгож тариалалтыг хийж дуусгалаа. “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ-наас зарласан тендерээр Хутаг-Өндөр суманд 51200 ширхэг чацарганы суулгацыг шинээр хүлээлгэн өгч тариалалтанд хяналт тавин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 46200 ширхэг	100

						суулгацыг иргэд, ААНБ-уудад хүлээлгэн өгч тариалаад байна. Үлдэгдэл 5000 ширхэг суулгацыг Шинэ хөдөө төслийн дэмжлэгээр тариалахаар нүхийг нь ухах ажлыг эхлүүлээд байна. Тус суманд их хэмжээгээр тариалалт хийхтэй холбогдуулан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5 ширхэг нүх ухагч төхөөрөмжийг 5750000 төгрөгөөр ТЭДСангаас худалдан авч богино хугацаанд өртөг багатай тариалах нөхцөл боломжоор хангаад байна. 2018 онд аймгийн хэмжээнд шинээр нийт 87137 ширхэг чацарганыг 69.7 га-д, нөхөн тариалалтаар 32757 ширхэг чацарганыг 26.2 га-д тус тус тариалаад байна. “Шинэ хөдөө” төслийн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ХХААХҮЯ-наас тендер сонгон шалгаруулж Баяннуур, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр, Орхон, Булган, Баян-Агт, Бугат, Хангал гэсэн 9 суманд нарны эрчим хүчээр ажиллах ус өргүүр бүхий инженерийн хийцтэй худаг гаргаж ашиглалтанд хүлээн авахад бэлэн болоод байна. Мөн тус бүр 10 га услах хүчин чадалтай нийт 8 иж бүрдэл дуслын усалгааны системийг уг төслийн санхүүжилтээр сумдад хүлээлгэн өгсөн.	
	170	2.2.5.10. Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг механикжуулан, нэмэгдүүлж, баталгаажуулах Газар брэнд гарцыг	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Аймгийн газар тариалангийн брэнд бог будаа, арвай, хөх тарианы бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж импорт бууран, экспорт нэмэгдэнэ.	Аймгийн хэмжээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг 85 аж ахуйн нэгж, 747 өрхийн тариаланчид жилдээ 40-42 мянган га-д үр тариа, 600-800 гаруй га-д төмс, хүнсний ногоо тариалж байна. Энэ онд үр тариа 42259.1 га-д тариалж 56656.3 тн, буудай 38093 га-д тариалж 55715 тн, бусад үр тариа 667 га-д тариалж 941.5 тн ургац тус тус хураан авлаа. Төмс 323.89 га-д тариалж 4335 тн, хүнсний ногоо 152.4 га-д тариалж 1264 тн, тэжээлийн ургамал 4410.5 га-д тариалж 2533 тн, тосны ургамал 4801 га-д тариалж 1567 тн, эмийн ургамал 105 кг, жимс жимсгэнэ 26.1 тн-ыг тус тус хураан авсан. Хураан авсан ургацаар тооцоход аймгийн хүн амын гурил, төмсний хэрэгцээ 146 хувь, хүнсний ногооны хэрэгцээ 20.7 хувиар хангагдаж өмнөх оноос нэмэгдсэн, нэгжийн ургацын урьдчилсан дүнгээр улсынхаас 3.0 цн-ээр илүү, өмнөх оны ургацаас үр тариа 30926 тн, төмс 980 тн, хүнсний ногоо 263 тн-оор нэмэгдсэн нь эрсдлийг бууруулах зорилгоор ганд тэсвэртэй сортын тариалалт нэмэгдсэн, 6 дугаар сараас газар тариалангийн үйлдвэрлэлд таатай цаг агаарын	70

						нөхцөл бүрдсэн зэрэгтэй холбоотой байлаа. Аймгийн хэмжээнд хүн амын хэрэгцээт төмс нутагшсан сортоор 100 % хангагдаж, Хятад сортын үр бүрэн халагдсан бөгөөд хүнсний ногооны тариалалтад бөөрөнхий сонгины эзлэх хувь 15%-иар цагаан болон улаан хальстай сармисыг үржүүлэх, тариалах ажил нэмэгдэж тарих үр болон бэлтгэсэн уриншийн чанар сайжирч, дэвшилтэт технологид нийцсэн техникийн хангамж, үр тарианы үйлдвэрлэл 40-50 хувьд хүрч, тариалалт уринш, ургац хураалтыг 14-20 хоногт гүйцэтгэх хүчин чадалтай болсон эерэг үр дүнгүүд гарсан. Энэ онд Хутаг-Өндөр 47 га, Тэшиг 50 га, Хангал 45 га, Орхон 12 га, Сэлэнгэ 142 га, Бугат 40 га-д нийт 388 га-д овъёос, Хангал 8.5 га, Хутаг-Өндөр 142 га, сумдад арвай, Хангал 7 га, Рашаант 6 га-д хөх тариа буюу нийт 887.5 га-д тариалалт хийж, 5.0 мянган тн малын тэжээл хураан авсан. Энэ онд бог будаа 28 га-д, арвай 171.5 га-д, 7 га-д хөх тариа тариалж урьдчилсан дүнгээр арвай тн, бог будаа 80 тн, хөх тариа 15 тн-ыг хураан аваад байна. Бренд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор арвайн үрийг шинэчлэн “Алаг эрдэнэ” сортыг УГТЭШХ-ээс авч тариалсан.	
171	2.2.5.11. Хутаг-Өндөр суманд 15000 тонны багтаамжтай механикжсан элеватор барих	2016-2020	АЗДТГ, ХХААГ		Хутаг-Өндөр, Тэшиг, Баян-Агт сумын үр тариаг хадгалах боломж бүрдэнэ.	Хутаг-Өндөр суманд 15000 тонны багтаамжтай механикжсан элеватор барих асуудлыг “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрт хамруулах саналыг боловсруулж, ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.	үб
172	2.2.5.12. Худалдааны төвийг түшиглэсэн 500-1000 тн-ы багтаамжтай механикжсан зоорийг энэ чиглэлийн бизнесийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг түшиглэн Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Булган суманд байгуулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Төмс хүнсний ногоог боловсруулах хадгалах тээвэрлэх, борлуулах тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдал сайжирна	“Шинэ хөдөө” төслийн хүрээнд 180 тоннын 2 зоорийг Булган, Хутаг-Өндөр сумдад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулахаар шийдвэрлүүлсэн.	40

	173	2.2.5.13. Биологийн гаралтай бордоо, ургамал хамгааллын бэлдмэлийг дотооддоо үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Био бордоо үйлдвэрлэх цехийг хойд, урд бүсэд тус бүр нэгийг байгуулсан байна.	Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны хөтөлбөр, “Хүнсний ногоо” дэд хөтөлбөр, “Булган жимс, жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгч нарт зориулсан Чийгийн улаан хорхойгоор амин бордоо үйлдвэрлэх сургалтыг 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр Орхон аймгийн “МҮГЭЗ” хоршоотой хамтран зохион байгууллаа. Сургалтыг амин бордооны үйлдвэрлэл эрхлэгч, сургагч багш Я.Тоолой, Г.Батсүх нар батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу удирдан зохион байгууллаа. Тус сургалтанд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгч 25 иргэн хамрагдлаа. Сургалтанд хамрагдсан 25 иргэнд "Старатель" үүлдрийн чийгийн улаан хорхой тус бүр 1500 ширхэгийг хүлээлгэн өгснөөр тариаланчид тариалалтандаа амин бордоогоор ашиглаж ургацаа нэмэгдүүллээ.	40
	174	2.2.5.14. Хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, үржил шимийг сайжруулах зорилгоор сум бүрт тариалангийн талбайн 5-10 хувьд ойн зурвас байгуулах, тариалангийн талбайн хашааг сэргээн засварлах, шинээр барихад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Эрсдэл бүхий тариалангийн талбайн 40-60 хувийг хашаажуулж, 4-8 мянган га-д ойн зурвас байгуулсан байна.	Засгийн газраас Хутаг-Өндөр сумыг газар тариалангийн бүс нутгаар тогтоож, ХХААХҮЯ-наас 2018 онд 100 км тариалангийн талбайг хашиж хамгаалах зорилгоор гүйцэтгэгч компанийг шалгаруулж хашаагаа тус суманд хүргэж барихад бэлэн болоод байна. Тариалангийн талбайн 60 хувь буюу 22.2 мянган га талбайг хашаажуулсан.	70
	175	2.2.5.15. Мэдлэгт суурилсан, шинжлэх ухааны үндэслэлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	ХАА-н салбарын үйлдвэрлэл эрхлэгч нарын мэргэжлийн мэдлэг, ур чадвар нэмэгдэж, эрчимжсэн тариалан эрхлэх боловсон хүчнээр	Ургамал түүний гаралтай бүтээгдэхүүнд гарал үүсэл олгох сургалтыг Булган суманд 2 удаа, Хангал, Орхон сумд Хялганат тосгонд 1 удаа зохион байгуулж, нийт 156 өрхийн тариаланчид хамрагдав. Аймгийн Тариаланчдын зөвлөгөөнийг Бүрэгхангай, Хутаг-өндөр сумд, Хялганат тосгонд бүсчлэн зохион байгуулж, 250 гаруй тариаланч, ногоочин оролцсон. Зөвлөгөөний үеэр Дарханы УГТЭШХ-ийн эрдэмтэд, ЭША-нууд тариаланчдад зориулсан сургалт хийв.	100

					хангагдана.			
2.3 Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ:								
“Булган” үйлдвэрлэл, технологийн төвийг байгуулж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарыг төрөлжүүлэн хөгжүүлж, орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэх боломжийг бүрдүүлж, төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, аж ахуйн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.								
/35/ 2.3.1 Орон нутгийн түүхий эд, нөөцөд түшиглэсэн дэвшилтэт технологи бүхий нэмүү өртөг шингээсэн жижиг, дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	176	2.3.1.1. “Булган” үйлдвэрлэл, технологийн төв байгуулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, бизнес эрхлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	-	Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, шинэ дэвшилтэт техник, технологи бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болно.	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 75 дугаар тогтоолоор Булган, Орхон сумдын хилийн зааг “Домын дэвсэг”-д 140.4 га газарт Техник технологи, инноваци нутагшуулах үйлдвэрлэлийн бүсийг тогтоож, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Эс Ай Си Эй” ХХК-ийг шалгаруулж, 95.2 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр болсон. “Агар фүүдс” ХХК-ийн улсын төсвийн хөрөнгөөр дутуу барьсан "Мах бэлтгэх, хөргүүртэй зоорь"-ийн барилга болон тоног төхөөрөмж угсралтын ажлыг “Бүрэн луу” ХХК-аар гүйцэтгүүлж, ашиглалтад оруулахаар зохицуулалт хийлээ. Тус аж ахуйн нэгж нь цахилгаан эрчим хүчинд холбогдож, гүний худаг гарган, хашаа барих ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Шийдвэрлэсний дагуу 2 аж ахуйн нэгж ажлыг эхлүүлээд байна.	100
	177	2.3.1.2. Ойн нөөцөд түшиглэн мод боловсруулах, модоор эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эко үйлдвэр байгуулах санал санаачлагыг дэмжих	2016-2020	АЗДТГ, БОАЖГ	ОНТөсө в, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшлийн хөрөнгө	Ойг цэвэрлэж шахмал түлш, модон эдлэлийн үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжиж, ажлын байр нэмэгдэнэ	Сэлэнгэ сум 192.9 сая төгрөгийн өртөг бүхий шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин механизмд түшиглэж “Ингэт дөл” ОНӨААТҮГ байгуулж, орон нутгийн давсан орлогоор хувийн хэвшлийн ашиглалтгүй байсан барилга объектийг засаж, шахмал түлшний үйлдвэрийн байрыг бэлтгэж, цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбож, БНХАУ-аас мэргэжлийн хүмүүс ирж шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмжийг угсарч, технологийн тохиргоо хийж, туршилтын хугацаанд 5 тн шахмал түлш үйлдвэрлэж, 4 ажлын байр бий болгоод байна. Цаашид бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулах шаардлагатай байна. Мод боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж НҮБ-ын “Биологийн олон янз байдлыг хамгаалах, нүүрс хүчлийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх” төслөөс Булган аймгийн ойн нөхөрлөлүүдийн холбоонд ойн арчилгаанаас гарсан модыг /унанги/ ашиглан хорголжин түлш бэлтгэх болон хусны нүүрс үйлдвэрлэх бага оврын тоног төхөөрөмжүүд олгож, үйл ажиллагаа явуулж байна. “Намрын ногоон	70

						өдрүүд-Булганд үйлдвэрлэв 2018” үзэсгэлэн худалдаагаар Модыг хаягдалгүй үр бүтээлтэй ашиглаж, олон нэр төрлийн модны суулгац, модон сувнер үйлдвэрлэсэн Хутаг-Өндөр сумын Баян Улаан ойн нөхөрлөлд НҮБ-ын төслөөс 500 000 төгрөгийн төсөл хэрэгжүүлэх эрхээр шагнаж урамшууллаа. Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Сайхан, Булган зэрэг сумдад модон эдлэлийн үйлдвэрлэл эрхлэгчид тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.	
178	2.3.1.3. Аймагт түгээмэл тархсан барилгын материалын түүхий эдийг боловсруулах, цемент, барилгын бетон хийц, өнгөлгөөний тоосго, улаан тоосго, хөнгөн блок, зуурмагны үйлдвэр зэрэг барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх	2016-2020	АЗДТГ, ГХБХБГ, СЗД Хувийн хэвшил	ОНТөсө в, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшлийн хөрөнгө	Түгээмэл тархацтай ашигт малтмалын илэрцүүдэд хайгуулийн зөвшөөрөл авсан АА-н нэгжүүдэд ашиглалтын хэлбэрт оруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Бугат сумын 2 дугаар багийн нутаг Хүрэн булгийн овоо №2-д “Булган барилга” ХХК-нд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлээд байна. Ашиглалтын зөвшөөрөл олгосноор орон нутагт барилгын материалын үйлдвэрлэл хөгжих нөхцөлийг бүрдүүлж байна. Орхон сумын 3 дугаар багийн Хүрэмтэд “Дайрга уул” ХХК, 4 дүгээр багийн Оросын булгийн карьерт “Нарангийн бугат” ХХК-д барилгын материалын хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлээд байна. “Булган үйлдвэрлэл технологийн төв”-д 91.8 га газарт барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх ТЭЗҮ боловсруулах тендерт Эс Ай Си Эй” ХХК шалгараад байна. Тус ТЭЗҮ-ээр барилгын материалын үйлдвэр, цехүүдийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын түвшин, хүний нөөц, хөрөнгө санхүүгийн чадавхи, урт хугацаанд тогтвортой, үр ашигтай ажиллах нөхцөл, инженерийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдана.	70
179	2.3.1.4. Аймгийн төвд шахмал түлшний үйлдвэр байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, БОАЖГ		Ойг цэвэрлэж шахмал түлшний үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжиж, ажлын байр нэмэгдэнэ.	“Билгүүн дэлгэрэх” ХХК нь “Сум хөгжүүлэх сан”-аас 50.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, санхүүгийн чадавхиа дээшлүүлж, өдөрт 2-3 тн, жилд 45-50 тн шахмал түлшийг тогтвортой үйлдвэрлэж байна. “Байгаль хамгаалах сан”-ийн 416.7 сая төгрөгийн хөрөнгөөр авсан шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмжийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 48 дугаар тогтоолоор Сэлэнгэ, Баян-Агт сумд, Булган Мээж ХХК-д шилжүүлсэн. 192.9 сая төгрөгийн өртөг бүхий шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин механизмийг Сэлэнгэ	100

							суманд олгосон.	
	180	2.3.1.5. Аймгийн хэмжээнд орчин үеийн эко технологи бүхий ноос, ноолуур, арьс ширний анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр байгуулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо өссөн байна.	Булган сумын иргэн Дорждагвын арьс ширний үйлдвэрлэлийг дэмжиж, аймгийн 80 жилийн лого бүхий бүтээгдэхүүнийг хүндэтгэлийн гарын бэлгэнд худалдан авч дэмжлэг үзүүллээ. "Эрүүл идэвхитэй амьдрал клуб"-ийн залуучууд болон иргэд арьс ширээр аймгийн 80 жилийн лого бүхий цүнх, бүс, түрүүвч зэрэг бэлэг дурсгалын зүйлсийг шинээр үйлдвэрлэж эхлээд байна. Баян-Агт, Дашинчилэн сумд Сум хөгжүүлэх сангаас арьс шир боловсруулах, нэхий элдэх тоног төхөөрөмж авахад дэмжлэг үзүүлснээр цехийн үйл ажиллагаа эхэлж, хонины нэхийг үйлдвэрийн аргаар элдэж зах зээлд нийлүүлж эхэллээ. Уламжлалт аргаар суран эдлэл үйлдвэрлэх өв соёлыг өвлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Баяннуур, Булган сумын иргэдийг үзэсгэлэн худалдааны шилдэг бүтээгдэхүүнээр шалгаруулж шагнаж урамшуулж, Б.Нямганжав гуайг ТВ-9 телевизийн нэвтрүүлэгт оролцуулж уламжлалт аргаар суран эдлэл боловсруулдаг арга технологийг сурталчиллаа. Дашинчилэн сумын иргэн н.Булганбаатар арьс шир боловсруулах цех байгуулах, тоног төхөөрөмжөө худалдан авахад сум хөгжүүлэх сангаас 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.	40
	181	2.3.1.6. Орон нутгийн экологийн цэвэр брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэр төрлийг нэмэгдүүлэн, стандартын шаардлага хангасан улсын хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Үндэсний болон орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэх боломж бүрдэж, төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өргөжинө.	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас "Бүрэн луу" ХХК 674.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл авч Сүү боловсруулах үйлдвэр байгуулахаар үйлдвэрийн байранд капитал засвар хийж, өргөтгөл барихаар бэлтгэж байна. Хялганат тосгонд Сүргийн нуга ХХК нь Зөгийн аж ахуйдаа түшиглэж Зөгийн балны савлах үйлдвэрийг барьж ашиглалтад оруулах, 60.0 сая төгрөгийн савлагааны тоног төхөөрөмжөө суурилуулахаар ажиллаж байна. ХХҮГ-аас орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Тунамал Өгөөж ХХК-ийн цай үйлдвэрлэл, Сайхан харзтай ХХК-ийн Сэлэнгийн шим бог будаа үйлдвэрлэлийг дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлээд байна. Аймгийн 80 жилийн ойг угтаж орон нутгийн бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэгчдийг чадавхижуулах, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зөвлөх үйлчилгээний сургалт зохион байгуулж,	100

						стандартын салбар сангаар 370 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 540 стандартаар үйлчилгээ үзүүлж, 529 иргэн, аж ахуйн нэгжийн 75 нэрийн бүтээгдэхүүн, 12 нэрийн 593 үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгож ажил үйлчилгээг нь баталгаажууллаа. Үйлчилгээний ажилтнуудын мэргэжлийн түвшинг дээшлүүлж, үйлчилгээний стандарт хангалтыг сайжруулахад бодлого, үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх зорилгоор 27 удаагийн сургалт, мэдээлэл, хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 526 гаруй иргэнийг хамрууллаа. Сэлэнгэ сум Монголын Зөгийчдийн холбоотой хамтран Зөгий эрхлэгчдийн сургалт зохион байгуулж, аймгийн Зөгийчдийн холбоог байгуулж, зөгийн бал бүтээгдэхүүнийг Япон улсад лабораторийн шинжилгээнд оруулж, экспортод гаргахаар судалж байна. Хялганат тосгон, Сэлэнгэ сумын зөгийчид Казакстан улсаас Монголд үржүүлэхэд тохиромжтой зөгийн сүрэг авч үржүүлж байна. Хутаг-Өндөр сум “Монголын хуурай сүү” төсөлтэй хамтарч хуурай сүүний үйлдвэр байгуулахаар үйлдвэрийн байрыг шийдвэрлэж, тоног төхөөрөмжийг суурьлуулсан боловч, үйлдвэрийн байранд стандартын дагуу засвар тохижилт хийхэд хөрөнгө санхүү дутагдалтай байна. Бүрэгхангай сум нийгмийн хариуцлагын хүрээнд Монполимент ХХК-тай хамтран 2019 онд хуурай сүүний үйлдвэрийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна. “Сэлэнгэ сум ХАА-н “Ингэт толгой Үйлдвэр технологийн парк”-ийн ТЭЗҮ-ийг боловсруулж ХАА-н гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлэхээр хамтран ажиллах түнш, хөрөнгө оруулалт хайж байна. Сэлэнгэ сум Ойско ОУБ-тай хамтран Зөгийн балыг, Хялганат тосгоны “Сийлбэр броудерс” ХХК чацаргана хуурайшуулж тус тус Японд нийлүүлэхээр ажиллаж байна. “Буман сүхэс” ХХК-ийн хиамны цехийн үйл ажиллагааг дэмжиж, АЗДТГ-ын өмчид байсан хуучин сүүний үйлдвэрийн ашиглалтгүй барилга объектийг хүнсний үйлдвэрийн стандартын дагуу тохижуулж, хиамны цехийн үйлдвэрлэл эрхлүүлэхээр тус компанитай гэрээ байгуулж, засварын ажлыг эхлүүлээ.	
182	2.3.1.7. Орон нутагт	2016-	АЗДТГ,		Аж ахуйн нэгж	2018 онд “Сум хөгжүүлэх сан”-д 931.8 сая төгрөг	100

		жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдэд бизнесийн тэгш боломж олгох, зээл тусламжид хамруулах, бүтээгдэхүүний борлуулалтад дэмжлэг үзүүлэх	2020	Хувийн хэвшил		иргэд ажилтай, орлоготой байна.	эргэн төвлөрч, 15 сум 1 тосгон 148 төсөлд зээл олгосноор 185 ажлын байр хадгалагдаж, 66 шинэ ажлын байр бий боллоо. Тэшиг сум эх үүсвэрээ төвлөрүүлж, зээл олгох арга хэмжээг зохион байгуулахаар ажиллаж байна. Азийн хөгжлийн банк, Батлан даалтын сан, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилттэй төслийн танилцуулгыг арилжааны банк, холбогдох мэргэжлийн байгууллагууд иргэд, бизнес эрхлэгчдэд зохион байгуулж, зарим аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаатай танилцууллаа. Төслөөс 3 аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлсэн байна. “Цагаан сар-Булган түншлэл-80”, “Намрын ногоон өдрүүд -Булганд үйлдвэрлэл” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 1 хот 3 аймгийн 13 сумын 139 аж ахуйн нэгж, иргэн нийт 352 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 100.0 гаруй сая төгрөгийн борлуулалт хийж, үндэсний үйлдвэрлэгчдийн борлуулалтад дэмжлэг үзүүлээ. Мерси кор ОУБ-ын санхүүжилтээр Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран 90 гаруй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн чадавхийг дээшлүүлэх 5 өдрийн вакум сургалт зохион байгуулж, Булган сум жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийнхээ зөвлөгөөнийг зохион байгуулж, цаашид шийдвэрлэх асуудлуудаа тодорхойлсон. ХХААХҮЯ-ны ЖДҮДС-аас 30 зээлдэгч 295.1 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.	
	183	2.3.1.8. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалтад орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагууд, бизнес эрхлэгчдийг оролцуулах бодлого барьж ажиллах	2016-2020	АЗДТГ, ОНӨГ		Аж ахуйн нэгж бизнес эрхлэгчид чадавхижна.	2018 онд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дүгээр заалт орон нутгаас хамгийн их ажиллах хүч авсан байх гэсэн заалтын хүрээнд дотоодын давуу эрх тооцох нөхцөлийг тусгаж тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажилласнаар давхардсан тоогоор 26 тендерт орон нутгийн аж, ахуйн нэгжүүд шалгарч, орон нутгийн 270 гаруй ажилгүй иргэдийг түр ажлын байртай болгож, нийт 1859400.0 /нэг тэрбум найман зуун тавин есөн сая дөрвөн зуун мянга/ төгрөгийн ажил гүйцэтгэсэн байна.	100
	184	2.3.1.9. Булган, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Орхон сумдын гурилын үйлдвэрүүдийг	2016-2020	АЗДТГ, ХХААГ		Аймгийн хүн амын болон бүсийн аймгуудын	Энэ онд гурилын үйлдвэрүүдэд чиглэсэн дэмжлэг, хөтөлбөр зарлагдаагүй. Хангайн гурил ХХК нь гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмж, технологийг сайжруулж, дээд гурил үйлдвэрлэх дамжлагатай	100

		тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх				гурилын хэрэгцээг хангаж, мал, амьтны тэжээлийн үйлвэрүүдийг байгуулна.	болж үйлдвэрлэл жигдэрсэн. Хонгор Агро ХХК-ний гурилын үйлдвэрээс бусад үйлдвэрүүд нөөцөлсөн будааны хэмжээгээрээ үйлдвэрлэл явуулж байна.	
185		2.3.1.10. Хүн, амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор “Мах”, “Сүү” аяныг зохион байгуулах	2016- 2020	АЗДТГ, ХХААГ		Аймгийн хүн амын болон бүсийн аймгуудын мах, сүүний хэрэгцээг хангаж, үйлдвэрүүд, цахууд бий болно.	“Мах сүүний анхдугаар аян”-ыг өрнүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу “Сэлэнгэ үүлдрийн үхрийг өсгөн үржүүлэх” дэд хөтөлбөрийн төслийг боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ИТХ-аар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна. “Шинэ хөдөө” төслийн хүрээнд “Сэлэнгэ” үүлдрийн үхэр үржүүлэх бүс нутаг болох Тэшиг, Хутаг-Өндөр, Хангал, Бугат сумдад 100 “Сэлэнгэ” үүлдрийн бух, Сэлэнгэ суманд 25 “Герефорд” үүлдрийн бухыг тус тус хүлээлгэн өглөө. Уг төслийн хүрээнд ирэх жил Сэлэнгэ үүлдрийн үхэрт зохиомол хээлтүүлэг хийхээр Герефорд үүлдрийн бухнаас 6000 тун үр авч хадгалсан. “Мерси Кор” ОУБ-ын байгууллагын буцалтгүй тусламжаар эрүүл бүс болох Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал, Сэлэнгэ сумын 13 МЭҮН-д малын тарилга, туулга, үзлэг ангилалт хийх зориулалттай тус бүр 8.0 сая төгрөгийн нийт 104.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай зөөврийн хашааг олгож, “Зана дура зурбак” ХХК-д “Герефорд” үүлдрийн 10 бух олгож үхэр сүрэгт сайжруулалт хийж махны гарцыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүллээ. Улсын болон орон нутгийн төсвөөс мал эрүүлжүүлэхэд 1.13 тэрбум төгрөг зарцуулсан байна. Мөн Мерси кор ОУБ-ын санхүүжилтээр “Махны бизнесийг амжилтад хүргэх орчин үеийн аргачлалууд” 5 хоногийн 4 удаагийн сургалтад махны салбарт ажиллаж буй цаашид ажиллах сонирхол бүхий иргэн, аж ахуйн нэгжүүдийг хамрууллаа. Малын эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон төрийн бодлого, хууль тогтоомжийг таниулан сурталчлах талаар илтгэл мэдээлэл тавьж, малчдын санал хүсэлтийг сонсож, 3000 -аад малчид, тариаланч иргэдэд хүргэлээ. Монголын фермерийн холбоотой мах сүүний чиглэлийн 4 аж ахуйг цогцоор нь дэмжиж хамтарч ажиллах санал солилцож, БНСУ-ын Жоннам мужтай эрчимжсэн аж ахуйг	70

						хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах санал хүргүүллээ. “Мах сүүний анхдугаар аян”-ы хүрээнд Хутаг-Өндөр сум “Монголын хуурай сүү” төсөлтэй хамтарч хуурай сүүний үйлдвэр байгуулахаар үйлдвэрийн байрыг шийдвэрлэж, тоног төхөөрөмжийг суурилуулсан боловч, үйлдвэрийн байранд стандартын дагуу засвар тохижилт хийхэд хөрөнгө санхүү дутагдалтай байна. Тус үйлдвэр нь орон нутгийн нөөцийг ашиглах, алслагдсан малчдын сүүг эдийн засгийн эргэлтэд оруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготой тул аймгийн хойд бүсийн малчдын дунд малаа саалинд хамруулах хөдөлгөөн өрнүүлж, үйлдвэрийг түүхий эдээр хангахад анхаарч байна. “Булган мах маркет” ХХК-ийн мах боловсруулах үйлдвэр ашиглалтад орж, орон нутгийн 70 гаруй иргэд ажлын байраар хангагдсан. Махны үнэ тогтворжуулах орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөгийн хөрөнгөөр Булган сум 20 тн мах нөөцлөн бэлтгүүлж, 9 дэлгүүрээр нийлүүлж, 2019 оны нөөцийн мах бэлтгэлийн тендер зарлаж нийт үхрийн мах 14.0 тн, хонины мах 6.0 тн-ийг нөөцлөх гэрээ хийгээд байна. Үхрийн мах-5800 төгрөг, хонины мах 4900 төгрөгөөр худалдаалагдсан нь зах зээлийн ханшаас 1300 орчим төгрөгөөр хямд байна.	
/57/ 4.1.1. Зөв бодлогыг үр дүнд хүргэхийг зорьж ажиллана.	301	4.1.1.1. Иргэдийн санал, санаачлагаар дэмжигдсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулах төслийн баг томилж ажиллуулах	2016-2020	АЗДТГ	-	Иргэдийн санал, санаачлагыг байнга сонсдог түүнийг хэрэгжүүлдэг төслийн баг ажиллаж, үр дүн гаргасан байна.	Аймгийн Засаг даргын А/607 тоот захирамжаар аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах зорилгоор гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, төсөл боловсруулах ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж “Мерси Кор” Олон улсын байгууллагатай хамтран малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, орон нутгийн малчид, ХАА-н салбарын ажилтнуудыг чадавхжуулах чиглэлээр эхний төслийг боловсруулж байна. Мөн ХАА-н ахмад мэргэжилтнүүдийн, төрийн захиргааны ахмад ажилтнуудын зэрэг зөвлөх багуудыг байгуулан хамтран ажиллаж байна.	70
	302	4.1.1.2. Орхон аймагтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, үр дүнг тооцож ажиллах	2016-2020	АЗДТГ		Гэрээнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна.	Орхон аймагтай 2016-2020 онд хамтран ажиллах гэрээ 2016 онд байгуулагдсан. Тус гэрээнд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, Засаг даргын Тамгын газрын зүгээс нэмэлт өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг томилон аймгийн Засаг даргын харьяа агентлаг, хэлтэс, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газарт хүргүүлээд байна.	70
	303	4.1.1.3. Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	2016-2020	АЗДТГ		Тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, ой тэмдэглэн өнгөрүүлсэн байна.	Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд бэлтгэх аймгийн хороог Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2016 оны 107 дугаар тогтоолоор байгуулан иргэд олон нийт, төр, төсвийн байгууллагуудын ажилтнуудаас 80 бүтээлч ажлын саналыг авч хэрэгжүүлэн ажиллалаа. Ойн арга хэмжээ хүртэлх 2 жилийн хугацаанд 80 бүтээлч ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө гарган ажилласны үр дүнд аймгийн төвийн барилга байгууламж, гэрэлтүүлэг, зам, зогсоол, ногоон байгууламж зэрэг Булган сумын өнгө төрхийг нь нэмсэн олон ажлууд хийгдэж төлөвлөсөн ажлаа 85 хувьтай гүйцэтгэлээ. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 70 дугаар	100

							тогтоолоор баяр наадмыг зохион байгуулах аймгийн хороог 11 салбар хороотойгоор байгуулан Монгол улсын Засгийн газрын 2018 оны 167 дугаар тогтоолоор 7 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд аймгийн ойгоо тэмдэглэн өнгөрүүллээ.	
	304	4.1.1.4. Анхдагч алдартнуудын ойг тэмдэглэн өнгөрүүлэх /Чин ван Ханддорж-150, мэргэн сайд А.Амар-130, Төр, нийгмийн зүтгэлтэн Д.Дамба-110 жил, Ардын Хатанбаатар Магсаржав-140 жил г.м/	2016-2020	АЗДТГ	-	Анхдагч алдартнуудаар бахархсан ажил зохион байгуулагдсан байна.	2016 онд Монгол улсын Дархан аварга, Үндэсний спортын ууган гавьяат мастер Б.Түвдэндоржийн мэндэлсний 100 жилийн ойг Булганхангай бөхийн дэвжээ, Улаанбаатар дахь нутгийн зөвлөлтэй хамтран, 2017 онд Монгол улсын баатар хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн мэндэлсний 105 жилийн ой, 2018 онд Ардын Хатанбаатар Магсаржавын мэндэлсний 140 жил, Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Д.Дамба-110 жилийн ойг улс, аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүллээ.	100
/58/ 4.1.2. Төрийн албанд, ахмад үеийнхээ мэдлэг чадвар, дадлага туршлага, арга барил, хандлагыг тусган авч, ахмад, дунд, залуу үеийн 3 цагийн хэлхээсэнд хамтран ажиллана.	305	4.1.2.1. Төрийн албанд ажиллаж байсан ахмад, дунд үе, залуучуудын төлөөллийн уулзалтыг жил бүр хийж, гарсан санал зөвлөмжийг хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ, ТАЗ		Мэдлэг чадвар, арга туршлага нэмэгдсэн байна	Булган аймгийн “Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн”-өөс гарсан уриалгын дагуу Төрийн албанд ажиллаж байсан ахмад, дунд үе, залуучуудын төлөөллийн уулзалтыг 2 удаа зохион байгуулж, төрийн байгууллага бүр “Зөвлөн туслагч-Өвлөн суралцагч” аяны хүрээнд ахмад төрийн албан хаагчаас суралцах, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэхээр хэлэлцүүлэг өрнүүлж, “Хөгжилд хөтлөхөд миний оролцоо” эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг зохион байгууллаа. 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлаж, төрийн албанд үр дүнд чиглэсэн хандлагыг төлөвшүүлэн, төрийн албан хаагчдын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт, шударга байдал, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, үр дүнд суурилсан хяналт, шинжилгээ, үнэлгээг хэвшүүлж Монгол улсын Засгийн газрын “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
	306	4.1.2.2. Төрийн албанд шинэ бүтээлч санаачлагыг уламжлалт арга барилтай хослуулан хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ		Төрийн албан хаагчийн шинэ бүтээлч санааг дэлгэрүүлж орон нутагт хэрэгжүүлсэн байна	Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар нь Иргэдэд үйлчлэх нэгдсэн байр нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж, иргэдэд хүргэх үйлчилгээг боловсронгуй болгох, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Угтах үйлчилгээ”-г бий болголоо. Сумдын төр, төсвийн байгуулагуудын үйл ажиллагаатай танилцахад чиглэсэн “НҮҮДЛИЙН ТАМГЫН ГАЗАР”-ыг Баяннуур, Дашинчилэн,	70

							Рашаант, Гурванбулаг, Орхон сумдад ажиллуулж, аймаг орон нутгийн цаг үеийн ажлын талаарх мэдээллийг сумын иргэдэд хүргэж, тэдний санал хүсэлтийг сонсож, тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэснээс гадна сумдын төрийн албан хаагчдын ур чадвар, ажлын чанарыг дээшлүүлэх, нутгийн захиргааны бодлого шийдвэрт иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн “Зөвлөн туслах” ажлын хэсгийнхэн Сэлэнгэ, Булган, Бүрэгхангай сумд, Хялганат тосгонд ажиллаад байна.	
	307	4.1.2.3. Аймгийн Засаг даргын дэргэд орон тооны бус ахмадын зөвлөлийг байгуулах	2016-2020	АЗДТГ		Ахмадуудын санаа бодлыг үйл ажиллагаандаа тусгасан байна	Аймгийн Засаг даргын шийдвэрээр О.Мэдэхгүй, П.Дамба нарыг орон тооны бус зөвлөхөөр томилон ажиллуулж байна. Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд зориулсан “Бага нэвтэрхий толь”, “Булган аймгийн түүх” 1, 2 дугаар боть “Төрд зүтгэсэн он жилүүд” номын боловсруулалтад орон тооны бус зөвлөх П.Дамба, БСУГ-ын даргаар ажиллаж байсан Л.Эгиймаа нар болон төр захиргааны ахмад ажилтан Ц.Дагдааш, Ж.Мөнх-Очир, С.Даваасамбуу зэрэг ахмадуудаас зөвлөгөө авч, саналыг тусган ажиллалаа.	70
/59/ 4.1.3. Засаг, захиргааны анхан шатны нэгж багийн хөгжлийг бүх талаар дэмжиж, бэхжүүлнэ.	308	4.1.3.1. Хангал, Баяннуур, Рашаант, Булган сумын зарим багийг “Багийн хөгжлийн төв”-тэй болгох	2016-2020	Аймаг, сумын ЗДТГ	ОНТ	Иргэдийн саналыг сонсдог, гарсан санал хүсэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг болно	Булган сумын багийн иргэдийн нийтийн хурлуудад аймгийн удирдлагууд оролцож тэдний санал бодлыг сонсож зарим асуудлыг газар дээр шийддэг, Булган сумын удирдах бүрэлдэхүүнтэй сарын бүрийн 1 дэх 7 хоногийн мягмар гарагт уулзаж ажлаа ярилцдаг хэлбэрт шилжиж хэвшсэнээс гадна тус сумын 1, 4, 6-р багууд, Могод, Тэшиг, Бүрэгхангай сумдууд шинээр багийн хөгжлийн төвтэй болж 2019 онд Рашаант суманд багийн хөгжлийн төвийг шинээр барихаар 2019 оны аймгийн төсөвт тусгагдаад байна.	70
	309	4.1.3.2. Багийн ИНХ-ыг жилд 4-өөс доошгүй удаа зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	2016-2020	Сумын ЗДТГ		Иргэдийн саналыг сонсдог, гарсан саналыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Сумдын ЗДТГ-аас төсөвт байгууллагуудтай хамтран иргэдийн идэвх, санаачлагыг нэмэгдүүлэх мэдээ мэдээллийг түгээх зорилгоор улирал тутам багийн ИНХ-ыг зохион байгуулж байна. Багийн Иргэдийн нийтийн хурлуудад аймаг, сумын удирдлагууд, холбогдох агентлаг, хэлтсийн мэргэжилтнүүд оролцож асуудлыг газар дээр шийдвэрлэх, цаашид үйл ажиллагаандаа тусгах талаар анхааран ажиллаж байна. Нийт сумд БИНХ-ыг зохион байгуулж 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад саналаа хүргүүлээд байна	100

	310	4.1.3.3. Багийн Засаг дарга, эмч, ИНХ-ын дарга, байгаль хамгаалагч нарын зөвлөгөөнийг жил бүр хийж, гарсан санал, уриалгыг анхан шатанд хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллах	2016-2020	АЗДТГ	ОНТөсө в	Зөвлөгөөнөөр гарсан саналыг хэрэгжүүлж үр дүнд хүрнэ	Аймгийн ИТХ-ын ажлын алба, цэргийн штаб, Статистикийн хэлтэс, БОАЖГазар зэрэг байгууллагуудтай хамтран багийн ИНХ-ын дарга, Засаг дарга, байгаль хамгаалагч нарын сургалтыг аймгийн төвд зохион байгуулж, бүх багийн Засаг дарга нарыг албан хэрэгцээний notebook-р хангалаа. Сумдын багийн Засаг дарга, эмч, байгаль хамгаалагч нар хамтран сар бүрийн 20-нд, зарим сумдад долоо хоногийн баасан гариг бүр мэргэжилтнүүдийг хэсэг тус бүрт хуваарилан өрх нэг бүрээр орж уулзаж, иргэдийн санал хүсэлтийг авч, ажлын байран дахь сургалтыг тухай бүр зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлж байна.	70
/60/ 4.1.4. Төрд тангараг өргөж, хариуцлага хүлээсэн бүх шатны төрийн албан хаагчдаа үнэнч шударга, ёс зүйтэй, тогтвор суурьшилтай, сэтгэл хангалуун ажиллаж, амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж, хүний нөөцийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, байгууллагын соёл, хандлагыг төлөвшүүлнэ.	311	4.1.4.1. Төрийн албан хаагчдын “Хүний нөөцийн бодлого”-ыг боловсруулан, хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ		Бодлогын боловсруулан батлуулна	Шинэчлэн найруулагдсан Төрийн албаны тухай хууль, түүнийг дагалдан гарах журмуудтай уялдуулан "Төрийн албан хаагчдын хүний нөөцийн бодлого"-ын төслийг шинэчлэн боловсруулж байна. Бодлогын төслийн боловсруулалтад шаардлагатай судалгаа, мэдээллийг нэгтгэж 2019 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна.	70
	312	4.1.4.2. Төрийн албанд мэргэшсэн албан хаагчдыг бүрдүүлэх зорилгоор ажлын байрны үзлэг шалгалт хийж, ажил үүргийн хуваарийг оновчтой болгох	2016-2020	АЗДТГ		Төрийн албаны үйл ажиллагааны үр нөлөө нэмэгдсэн байна	Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу агентлаг, байгууллагуудад ажлын байрны үзлэг шалгалтыг зохион байгуулж, төрийн ажлын зохион байгуулалтыг сайжруулах, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр зөвлөмж өгч ажиллалаа. Үзлэг шалгалтын дүнд төрийн байгууллагуудын эмх цэгц, хууль тогтоомжийн хэрэгжилт өмнөх оныхоос сайжирсан үзүүлэлттэй байна. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд түр орлон гүйцэтгэгч ажиллуулсан зөрчил бүрэн арилсан. Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын 21 сул орон тоог төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнд үндэслэн нөхсөн. Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар гаргасан Монгол улсын Засгийн газрын 01 тоот албан даалгавар, 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлаж үр дүнг тооцон ажиллалаа.	70
	313	4.1.4.3. Төрийн байгууллага ажил, үйлчилгээний онцлогт	2016-2020	АЗДТГ		Төрийн байгууллагын үйлчилгээний	Аймгийн Засаг даргын 2018 оны А/125 дугаар захирамжаар 2018 оныг "Хариуцлагын жил" болгон зарлаад байна. Жилийн ажлын хүрээнд "Ёс зүйг	100

		тохирсон соёл, хандлагыг тодорхойлох				соёл тодорхойлогдс он үйлчилгээг эрхэмлэсэн төрийн алба бий болсон байна	дээдэлсэн хамт олон шалгаруулах болзол"-ыг зарлаж, дүгнэсэн. Үүнтэй холбогдуулан төрийн байгууллага бүр төрийн албан хаагчдын хувцаслалт, харилцаанд тавигдах шаардлагын стандартын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шинэчлэн боловсруулж байна. Төрийн албан хаагчдад зориулсан ёс зүйн сургалтын хөтөлбөрийг боловсруулан сургалтыг үе шаттайгаар зохион байгууллаа.	
	314	4.1.4.4. Алслагдсан сумдад ажиллаж байгаа мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор, суурьшилтай ажиллуулах үүднээс гэрээ байгуулж, ажиллах нөхцөл боломжийг ханган, ажлын байр болон дотоод, гадаадын сургалтад хамруулж, мэдлэг боловсролоо дээшлүүлэх боломж нөхцлийг дэмжих	2016-2020	АЗДТГ		Чухал шаардлагатай мэргэжлийн судалгаатай болж, гэрээ байгуулах нөхцлийг бий болгосон байна	Алслагдсан сумдад ажиллаж буй төрийн албан хаагчдын судалгааг салбар тус бүрээр гарган ажиллаж байна. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, сургах асуудлыг "Төрийн албан хаагчдын хүний нөөцийн бодлого"-ын төсөлд тусгаад байна. Судалгааны дүнгээс харахад Булган аймгийн алслагдсан Тэшиг, Рашаант зэрэг сумдад төрийн тусгай болон төрийн захиргаа, эрүүл мэнд, боловсролын салбарт нийт 400 гаруй албан хаагч ажиллаж байгаагаас дээрх албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор аймаг, орон нутгийн зүгээс 7.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого тусгагдсан зорилтын хүрээнд Рашаант, Тэшиг сумдын их эмч нарыг гэрээний дагуу мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан. Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын "Нийгмийн хамгааллыг дэмжих сарын аян"-ы хүрээнд алслагдсан сумдын Эрүүл мэндийн төвийн 17 албан хаагчийг хөнгөлттэй нөхцөлөөр рашаан сувилалд амраасан. Боловсрол, соёл урлагийн газар нь алслагдсан сумдын багш, ажилтнуудыг ажлын байранд сургах нөхцөлийг бүрдүүлэн зайн сургалтын тоног төхөөрөмжийг байрлуулан, сургалтыг улирал тутам зохион байгуулж байна. Төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах талаар бусад сумдын зүгээс анхааран ажиллаж байна.	70
	315	4.1.4.5. Сумдын Засаг даргын Тамгын газрын барилгад урсгал болон их засварыг үе шаттайгаар хийх	2016-2020	АЗДТГ, ГХБХБГ		Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирна	Сумдын Засаг даргын Тамгын газруудаас Булган сумын ЗДТГ хэсэгчилсэн дотор засал, Хялганат тосгон 5.5 сая төгрөгийн урсгал засвар хийснээс гадна Бүрэгхангай сумын ЗДТГ 36.0 сая төгрөгийн их засварын ажлыг хийж гүйцэтгээд байна. Хутаг-Өндөр	70

						сумын ЗДТГ-ын 9.0 сая төгрөгийг байгууллагын төсвөөс, ажилчдын хандиваар 4.8 сая төгрөгийн урсгал засвар хийж, Хангал сумын 1, 2, 3-р багийн Засаг дарга нар, галч нарын өрөөнд урсгал засвар хийсэн.	
/61/ 4.1.5 Нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, иргэдэд хүргэх мэдээллийг өргөжүүлж, цахим хэлбэрээр мэдээлэл, үйлчилгээ авах бололцоо, нөхцлийг сайжруулна.	316	4.1.5.1. Төрийн байгууллагуудын цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, цахим мэдээллийг иргэдэд хүргэдэг шинэ арга барилыг бий болгох	2016-2020	ХМОНХ А		Иргэд мэдээллийг түргэн шуурхай авдаг болно	100
	317	4.1.5.2. Төр, захиргааны байгууллагын удирдлагууд иргэддээ улирал тутам хийсэн ажлаа тайлагнаж, санал хүсэлтийг сонсдог графикт тогтолцоог хэвшүүлэх	2016-2020	ХМОНХ А		Төр иргэддээ ажлаа тайлагнадаг тогтолцоо хэвшинэ нь	70

							айл нэг бүрээр орж иргэдийн ажил амьдралтай танилцаж санал бодлыг сонсох ажлыг хийлээ.	
	318	4.1.5.3. Аймгийн албан ёсны цахим хуудсыг шинэчилж, баяжуулах журмын хэрэгжилтийг сар бүр хангаж ажиллах	2016-2020	ХМОНХ А		Мэдээллийн хүртээмж сайжирна	Аймгийн албан ёсны цахим хуудасны баяжилт шинэчлэлтийг тухай бүр хийж цаг үеийн мэдээ болон фото мэдээ, видео мэдээ бэлтгэн байршуулж байна. Сум агентлагуудаас ирсэн онцлох мэдээ, цаг үетэй холбоотой зөвлөмж, үйл ажиллагааны тайланг www.bulgan.gov.mn хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлж байна.	100
	319	4.1.5.4. Төрийн үйлчилгээний “Нэг цэг”-үүдийг тогтворжуулж, Угтах үйлчилгээг нэвтрүүлэх	2016-2020	ХМОНХ А		Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэнэ	Аймгийн хэмжээнд 11 сум, 13 агентлаг “Нэг цэг”-ээр иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна. Сум, байгууллагууд угтах үйлчилгээг нэвтрүүлэн тогтмолжуулж эхэлсэн. Аймгийн ЗДТГ-т Угтах үйлчилгээний ажилтантай болсноор иргэд төрийн үйлчилгээний мэдээллийг шуурхай авч аймгийн удирдлагууд, аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй уулзах хүсэлт, хүлээлт багасч байна.	100
	320	4.1.5.5. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын үүсэл санаачлагыг дэмжин хамтран ажиллаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлж, сурталчлах мэдээллийн багтаамж, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	2016-2020	ХМОНХ А		Мэдээллийн хүртээмж нэмэгднэ	“Сайхан Монгол” телевиз Юнивишн IPTV, ДДИШ ТВ-ээр орон даяар сувгаа цацаж иргэд аймгийнхаа мэдээллийг аймгийнхаа телевизээр хүлээн авч үздэг боллоо. "Сайхан Монгол" телевизийн үйл ажиллагааг дэмжих, иргэдэд төрийн мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.	100
/62/ 4.1.6. Аливаа шийдвэр гаргахдаа иргэд, олон нийтийн саналыг авч, нийгмийн бүлгүүдийн оролцоонд тулгуурлаж, олонхийн эрх ашгийг дээдэлсэн зөв бодлого гаргаж, хэрэгжүүлнэ.	321	4.1.6.1. Хөтөлбөр, төсөл боловсруулахдаа иргэний танхимаар хэлэлцүүлж хэвшүүлэх	2016-2020	АЗДТГ, Төрийн байгуулл агууд		Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	Сумдын ИТХ-ын албанаас Иргэний танхимын үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор төсөл хөтөлбөр, дүрэм, журам боловсруулахад иргэдийн оролцоог идэвхжүүлэх зорилгоор нээлттэй байдлаар иргэний танхимаар хэлэлцүүлж иргэдийн саналыг тусгаж байна.	70
	322	4.1.6.2. Иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, иргэдийн сайн дурын нөхөрлөл, бүлгүүдийн үүсгэл	2016-2020	Төр, иргэний нийгмийн байгуулл агууд		Төр, иргэний түншлэл сайжирсан байна	Иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх 59 ажлын жагсаалтыг батлан гаргаж ТББ-уудад хүргүүлсэн. Булган аймгийн хэмжээнд төрийн зарим чиг үүргийг нийт 9 ТББ-ууд төлөөлөн гүйцэтгэж байна. ИНБ-ын төлөөллүүд аймгийн удирдлагуудтай уулзаж санал бодлыг нь сонсож зарим нэг санал	70

		санаачилгыг дэмжиж, төрийн зарим чиг үүргийг тэдгээрээр төлөөлүүлэн гүйцэтгүүлэх замаар төвлөрлийг сааруулах					санаачлагыг дэмжиж орон нутгийн бодлого шийдвэрт тусган ажиллаж байна.	
/63/ 4.1.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг бодлого боловсруулах, төлөвлөлтийн явцад тусгах, ашиглах чадавхийг бүх шатны байгууллагад бий болгон олон нийтийн оролцоог хангах, санхүүжүүлэх арга замыг тодорхойлон, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулж, үр нөлөөг дээшлүүлнэ.	323	4.1.7.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг бодлого төлөвлөлтийн шатанд тусгах, бодлогын нөлөөллийн үнэлгээ хийх, ашиглах чадавхийг бүх шатны байгууллагад бий болгох	2016-2020	АЗДТГ, Төрийн байгуулл агууд	ОНТөсө в	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, төлөвлөсөн бодлогын хэрэгжилт сайжирна.	Сумын ЗДТГ болон газар, хэлтэс, байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнгийн талаар сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга, байгууллагуудын дарга нарт танилцуулж тайлангийн бүтэц, агууллагад анхаарч цаашид төлөвлөлтийн шатанд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлж, гүйцэтгэл, үр дүнд ач холбогдол өгч ажиллахыг зөвлөв. Аймгийн Засаг даргын 2017 оны А/280 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж байна. 2018 оны 09 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд “Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтээс явуулсан “Бодлогын хэрэгжилтийг үнэлэх арга зүй” сэдэвт сургалтад аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтнүүд хамрагдлаа.	70
	324	4.1.7.2. Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга ажиллагааг төр, төсвийн байгууллагуудад нэвтрүүлэх, цахим тайлангийн үйл ажиллагааг жигдрүүлэх	2016-2020	АЗДТГ, Төрийн байгуулл агууд	ОНТөсө в	Төрийн бодлогын чанар хүртээмж сайжирна.	Бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сум, байгууллагуудаас АБЛЕ программаар авч хэвшиж байна. 2018 оны 6 сард хугацаатай тайлан мэдээ ирүүлэхтэй холбогдуулан Сумдын Засаг дарга, агентлагийн дарга нарт Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн мэдээ тайлан ирүүлэх тухай аймгийн Засаг даргын албан тоотыг хүргүүлж, зохих заавар журмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон сургалтуудыг төрийн байгууллагуудад хийлээ.	100
	325	4.1.7.3. Бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын бүх үе шатанд олон нийтийн оролцоог	2016-2020	АЗДТГ, Төрийн байгуулл агууд	ОНТөсө в	Төрийн бодлого олон нийтэд нээлттэй болж,	Аймгийн хэмжээний бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулахдаа иргэний танхимаар хэлэлцүүлж иргэдийн саналыг тусгаж байна. Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	70

/64/ 4.1.8. Гадаад харилцааг өргөжүүлж шинэ шатанд гарган, бизнес эрхлэгчдийг холбож өгнө.	328	4.1.8.1. ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хот, Закамень аймагтай боловсрол, эрүүл мэнд, спорт, хөдөө аж ахуй, байгаль орчин, нийгмийн аюулгүй байдлын чиглэлээр хамтран ажиллах	2016-2020	АЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХААГ		Эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ.	Закамень аймгийн даргын урилгаар аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга тэргүүтэй төлөөлөгч 2018 оны 6 дугаар сард тус аймгийн "Сур харбаан" наадмын арга хэмжээнд оролцлоо. ОХУ-ын Буриад улсад хөгжмийн болон биеийн тамирын багш мэргэжлээр 23 хүүхэд суралцуулж байгаагаас гадна 2018-2019 оны хичээлийн жилд суралцахаар 25 сурагч хүсэлтээ өгч бүгд энэ хичээлийн жилээс суралцаж байна. Улан-Үдэ хотын ХАА-н жимс жимсгэний хүрээлэнтэй суулгац үржүүлэх талаар хамтран ажиллаж, тус аймгийн ХАА-н Агропаркид 8 нэр төрлийн жимс, жимсгэний суулгац үржүүлсэн.	100
	329	4.1.8.2. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Улаанхад хоттой Хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт хамтран ажиллах	2016-2020	АЗДТГ, ХХААГ	-	Хамтын ажиллагааны үр дүн дээшилсэн байна.	Улаанхад хоттой явуулж байсан хуучин харилцааг сэргээхээр аймгийн төлөөлөгчид 12 дугаар сард Улаанхад хотод айлчлахаар төлөвлөж байна. ӨМӨЗО-ны Засгийн газар болон Монгол улсын Засгийн газрын хамтарсан “Хэт талхлагдсан бэлчээрийг зайнаас тандан судлах ба нөхөн сэргээлт хийх туршилт” төслийн хүрээнд Булган аймгийн Засаг даргын орлогч О.Гантулгаар ахлуулсан төрийн байгууллагын мэргэжилтнүүд, мал зүйч, малчдын төлөөллөөс бүрдсэн төлөөлөгчид ӨМӨЗО-ы Хөх хотод ажилласан. Тус айлчлалын үеэр Өвөр Монголын Мал аж ахуй-Газар тариалангийн хүрээлэнд туршлага судалж, хамтарсан төслийн үр дүнг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө боловсруулсан. Төслийн хөрөнгө оруулалтаар Булган аймгийн Гурванбулаг сумын Авзага багт бэлчээрийн менежментийн суурин судалгааны байрыг байгуулахад дэмжлэг үзүүлж эхлээд байгаа бөгөөд туршилтын талбайг сонгож, хашаажуулан, цаг уурын тоног төхөөрөмжөөр хангаад байна. 2 орны хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагддаг салбарын ажилчдыг мэргэшүүлэх “Хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэл”-ийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад ХХААГ-ын 1 мэргэжилтэн хамрагдсан.	100
	330	4.1.8.3. БНСУ-ын Дэгү хотын Дунгу дүүрэгтэй боловсрол, эрүүл мэнд, спорт, хөдөө аж ахуй, байгаль орчны чиглэлээр	2016-2020	АЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХААГ	-	Хамтын ажиллагаа хөгжсөн байна.	БНСУ-ын Дэгү хотын Дунгу дүүрэгтэй тогтоосон хуучин харилцааг сэргээхээр судалж байна. БНСУ-ын Жоннам муж болон бусад мужуудтай хамтын ажиллагаа тогтоохоор судалж, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын чиглэлээр	70

		хамтран ажиллах					харилцаа тогтоохоор санал хүргүүлсэн. Жоннам мужийн захиргааны байгууллагын төлөөллүүд 2018 оны 8 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Булган аймагт ажилласан. Уулзалтын үеэр талууд малын чанар, үүлдэр угсааг сайжруулах, малын эрүүл мэндийг хамгаалах, эрчимжсэн аж ахуй, туслах аж ахуй эрхлэлтийг нэмэгдүүлэх, бэлчээрийн талхлалтыг сааруулах зэрэг хөдөө аж ахуйн асуудлаар харилцан санал солилцож, цаашид хамтран ажиллах чиглэлээ тодорхойлов.	
	331	4.1.8.4. Турк улстай эдийн засаг, нийгэм, хөдөө аж ахуй, байгаль орчны салбарын чиглэлээр хамтран ажиллах	2016-2020	АЗДТГ, БСУГ, ЭМГ ХХААГ	-	Хамтын ажиллагааны түвшин тодорхой шатаар ахисан байна.	Монгол улсаас БНТУ-д суугаа Ерөнхий консул Э.Мөнх-Очирын урилгаар аймгийн Засаг дарга З.Батзориг тэргүүтэй төлөөлөгчид 2018 оны 11 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд Турк улсад ажлын айлчлал хийлээ. Тус айлчлалаар мах, сүүний чиглэлийн үхрийн ферм, мал нядалгаа, боловсруулах үйлдвэр, үхэр үржүүлэх, зохиомол хээлтүүлэг хийх, малын вакцин, эм үйлдвэрлэлийн компани зэрэг хөдөө аж ахуйн чиглэлийн үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагчидтай уулзалт хийж, туршлага судалсан. Айлчлалын үр дүнд аймагт мах боловсруулах үйлдвэр, сүү боловсруулах үйлдвэр байгуулах зэрэг ажлын эхлэл тавигдсан. Турк улстай ХАА-н чиглэлээр хамтран ажиллах хүрээнд “ТИКА” байгууллагын тусламжаар тус аймгийн 14 суманд 325 тн буюу 13000 шуудай 136.5 сая төгрөгийн тэжээлийг малчдад үнэгүй олгож хаваржилтыг даван туулсан. Мөн Хангал сумын “Эко хан буян” хоршоонд даршны ургамлын хөнгөлөлттэй үр олгож тариалалт хийгдсэн. Туркийн олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай /ТИКА/ хамтран ажиллаж Булган сумын 6-р цэцэрлэгийн барилгад 76.0 сая төгрөгийн их завсар, соёлын чиглэлээр Баяннуур сумын Шороон Бумбагар түүхийн дурсгалт газрыг тохижуулахаар хамтран ажиллаж байна.	100
	332	4.1.8.5. Гадаад харилцааг өргөжүүлэх чиглэлээр Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбоотой хамтран ажиллах	2016-2020	АЗДТГ	-	Хамтын ажиллагаа хөгжсөн байна.	Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбоотой нягт хамтран ажиллаж байна. 2018 оны 6 дугаар сард БНСУ-д зохион байгуулагдсан “Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал 2018”-д аймгийн ЗДТГ-аас 1 төлөөлөгч, 8 дугаар сард БНСУ-д зохион байгуулагдсан "Залуу удирдагч-форум"-д Булган аймгаас 1 оюутан, 1 залуу бизнес эрхлэгч, 9	100

							дүгээр сард БНХАУ-д зохион байгуулагдсан "Боловсон хүчний хорооны хурал"-д аймгийн ЗДТГ-аас 2 төлөөлөгч оролцсон. Тус холбооноос 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ирүүлсэн.	
Шинээр харилцаа тогтоох								
	333	4.1.8.6. ОХУ-ын Красноярск мужтай эдийн засаг, нийгэм, хөдөө аж ахуй, байгаль орчны салбарын чиглэлээр хамтарч ажиллах	2016-2020	АЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХААГ	-	Эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ.	ОХУ-ын Красноярск хотын ХАА-н их сургуультай хамтран 3 бүсэд Сибирийн сортуудыг турших гэрээ хийгдэж, Сэлэнгэ сумын "Ингэттолгой" ХК, Тэшиг сумын "Шинэ амжилт" ХХК-иуд ОХУ-аас орж ирсэн 5 сортын 1113.6 тн элит үрийг 7850 га-д тариалж га-с авах ургацын хэмжээ өндөр тогтоогдож манай хөрсөнд тохирох талаар мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт гараад байна. Красноярск хотын ХАА-н их сургуульд оюутан элсүүлэх талаар сургуулиудад мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.	70
	334	4.1.8.7. Европын өндөр хөгжилтэй Холбооны бүгд найрамдах Герман, Бүгд найрамдах Австри улсуудтай эдийн засаг, нийгэм, байгаль орчны салбарт хамтран ажиллах, нөхцлийг судлах	2016-2020	АЗДТГ, ХХААГ	-	Эдийн засаг, нийгмийн салбарын хамтын ажиллагаанд ахиц гарсан байна.	Тус арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид 2018 оны 11 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд БНПУ-д ажиллалаа. Айлчлалын хүрээнд мах, махан бүтээгдэхүүн, даршилсан ногоо, жимс жимсгэнэ, механикжсан зоорь үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагчидтай уулзалт хийж, туршлага судалсан бөгөөд айлчлалын үр дүнд Булган суманд Польшийн хөрөнгө оруулалтаар махны үйлдвэр барих, махны нөөц хамтран бэлтгэхээр харилцан тохиролцов.	100
	335	4.1.8.8. Азийн өндөр хөгжилтэй Япон улстай хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, байгаль орчны салбарын чиглэлээр хамтарч ажиллах	2016-2020	АЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХААГ	-	Эдийн засаг, нийгмийн салбарын хамтын ажиллагаанд ахиц гарсан байна.	Япон улсын "IN Partners" ХХК, "Public Interest Foundation Of South Asia Friendship Association"-уудтай эрүүл мэндийн чиглэлээр хамтын ажиллагаа тогтоохоор ажиллаж байна. Тус компаниудын удирдлагууд 2018 оны 12 дугаар сарын 3-5-ны өдрүүдэд Булган аймагт ажиллахаар төлөвлөж байна. Аймгийн зөгий үржүүлэгчдийн холбоо Япон улсад туршлага судлан зөгийн балаа нийлүүлэх гэрээ хэлэлцээр байгуулсан. "Осака тоёото" компанийн хөрөнгөөр 2 жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн чацаргана хуурайшуулах тоног төхөөрөмж Хялганат тосгонд байгуулагдаж, бүтээгдэхүүний дээжийг шинжилгээнд хүргүүлсэн. Япон улсын "Халуун сэтгэл" ТББ-аас сумын ЭМБ-уудад Е70 тариурын зүү устгагч аппарат, хүүхдийн	100

							жин хэмжигч хандивласан. Япон улсын Азийн эмч нарын холбоо “AMDA”, Монголын нүдний эмч нарын холбоотой хамтран хүүхдийн харааны гажиг заслын үзлэг оношилгоог Булган суманд зохион байгуулж, 212 хүүхдэд үзлэг хийсэн	
	336	4.1.8.9. АНУ-тай боловсрол, эрүүл мэнд, байгаль орчны салбарын чиглэлээр хамтарч ажиллах	2016-2020	АЗДТГ, БСУГ, ЭМГ	-	Эдийн засаг, нийгмийн салбарын хамтын ажиллагаанд ахиц гарсан байна.	АНУ-ын Юта мужтай тогтоосон хуучин харилцааг сэргээж, аймгийн Засаг даргын орлогч О.Гантулгаар ахлуулсан 4 төлөөлөгч Юта, Айдоха мужуудад ажил хэргийн уулзалт хийж, хөдөө аж ахуй, боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхээр санал солилцсон. Айлчлалын үр дүнд Престон хоттой харилцаа тогтоож, Ютагийн Их Сургууль, Вашингтоны Их Сургууль, Монтаногийн Их Сургуулиудад аймгийн төрийн албан хаагчдаас мэргэжил дээшлүүлэх сургалт, хэлний бэлтгэлд сургахаар судалж байна. Хамтын ажиллагааны хүрээнд аймгийн ИТХ, ЗДТГ-ын төлөөлөгчдөөс бүрдсэн баг энэ оны 12 дугаар сар болон ирэх оны эхээр АНУ-д айлчлал хийж, хамтын ажиллагааг улам бүр өргөжүүлэхээр төлөвлөж байна.	100

ТАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БАТЛАН ХАМГААЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

5.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, нийтийн албаны ёс зүйг өндөржүүлэн, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх замаар төрийн албаны сахилга хариуцлагыг дээшлүүлнэ. Хууль хяналтын болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлж, иргэний аюулгүй АМЬДРАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ зорилгоор эрсдэлд суурилсан удирдлага, шуурхай бэлэн байдлыг хангана.

/65/ 5.1.1. “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сум байгууллагад эрх зүйч мэргэжилтэн, иргэний эрх зүйн хөтөч бэлтгэн, хууль зүйн тусалцааг иргэд, байгууллагад үзүүлэх	337	5.1.1.1. Сум, байгууллагуудад төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтнийг эрх зүйн ажилтнаар, багийн иргэдийн нийтийн хурлын дарга нарыг “Эрх зүйн хөтөч”-өөр бэлтгэх	2016-2020	ХЭЗХ	0.3 /ОНТ/	Эрх зүйн хөтөч нарт жилд 2 доошгүй удаа зөвлөмжөөр хангаж, сургалтыг зохион байгуулсан байна.	Сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг эрх зүйн хөтөчөөр бэлтгэж арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллаж байна. 2018 онд дээрх эрх зүйн хөтөч нарт сургалтыг 2 удаа зохион байгуулж, эрх зүйн мэдээллийн чанар хүртээмжийг хэрхэн нэмэгдүүлэх, иргэдийн оролцоог сайжруулах чиглэлээр 16 сум, 1 тосгоны 17 албан хаагчид 2 удаа зохион байгуулсан. Төрийн захиргааны ажилтнаас багийн Иргэдийн нийтийн хурлын дарга буюу эрх зүйн хөтөч нарт мэдээлэл бэлтгэн өгч, малчин өрхүүдэд эрх зүйн мэдээллийг хүргэж байна. Эрх зүйн ажилтан нар сумандаа эрх зүйн сургалтыг сард 2 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж 10000 иргэнд хүрч зөвлөмж, мэдээлэл өгсөн байна.	100
	338	5.1.1.2. Тусгайлан бэлтгэсэн гарын авлага, сэдвийн дагуу сум, баг,	2016-2020	Сумын ЗДТГ, ХЭЗХ	2/ОНТ/	Төвөөс алслагдсан иргэдэд болон	Хууль зүй, дотоод хэргийн яам болон холбогдох агентлагуудтай хамтран зайны сургалтын сэдвийг сумдад хүргэж сургалтыг зохион байгуулж байна.	100

		байгууллагад эрх зүйн зайны сургалтыг зохион байгуулах				олон нийтэд эрх зүйн мэдээлэл хүрсэн байна.	2018 онд иргэдэд зориулж шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон 26 төрлийн хуулийн гарын авлагыг Швейцарийн хөгжлийн агентлагийн дэргэдэх “Иргэдийн оролцоо-2” төслийн санхүүжилтээр хийлгэж сургалтад ашиглаж байна. Мөн дээрх гарын авлагыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран дахин хэвлэж, эрх зүйн баг сумдад зохион байгуулах сургалтадаа ашигласнаар 10000 гаруй иргэдэд дээрх хуулиудын мэдээллийг хүргээд байна.	
	339	5.1.1.3. Сонин, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинг ашиглан хууль сурталчлах	2016-2020	ХЭЗХ	2/ОНТ/	Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжийн мэдээлэл иргэдэд хүрсэн байна.	“Булганы мэдээ” сонин, Гэр бүлийн радио 102.5, Булган аймгийн Засаг даргын Тамгын газар, Булган аймгийн Цагдаагийн газар гэсэн цахим хуудсаар дамжуулан иргэдэд эрх зүйн мэдээллийг хүргэж байна. 2018 оны байдлаар “Булганы мэдээ” сонинд 12 удаа, гэр бүлийн радиогоор долоо хоногт 2 удаагийн давтамжтай 30 минутын хугацаатайгаар нийт 100 гаруй удаагийн давтамжтайгаар 40 гаруй хуулийн шинэчлэл, нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэсэн байна.	100
	340	5.1.1.4. “Хэрэглэгчийн боловсрол” төвийн үйл ажиллагааг дэмжин, хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэх	2016-2020	ХЭЗХ, ТББ	0.372	Иргэдийн гомдол шийдвэрлэгдэж, иргэдэд мэдээлэл хүрсэн байна.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдэд Шударга өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны хуулийг сурталчилж 600 орчим иргэнд мэдээлэл хүргэсэн байна. Мөн эрх зүйн багтай хамтран хөдөөгийн сум, багт хүрч сургалтыг хийж байна. 2018 оны байдлаар “Хэрэглэгчийн боловсрол” төвд 2 гомдол мэдээлэл ирснийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлсэн байна. Хэрэглэгчийн боловсрол төвийн үйл ажиллагааг дэмжих, сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс орон нутгийн төсвөөс 372000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100
	341	5.1.1.5. Хуульчийн мэргэжлийн холбоо, өмгөөлөгчдийн зөвлөлтэй хамтран, иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй тусалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах	2016-2020	Сумын ЗДТГ ХЭЗХ		Иргэд үнэ төлбөргүй зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ авсан байна	Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтран иргэдэд хууль зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгөх “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээг иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор аймгийн Өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн тусалцааны төвтэй хамтран Булган сумын зах, олон нийтийн үйлчилгээний төвд 2 удаа зохион байгуулж 100 гаруй иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн Хууль зүйн тусалцааны төвийн	100

						өмгөөлөгчийг хөдөөгийн иргэдэд эрх зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үүднээс эрх зүйн багтай хамтруулан 16 сум, 1 тосгонд 2 удаа ажиллуулж 350 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүллээ. Дээрх арга хэмжээний үеэр иргэдэд өргөдөл бичих, өмгөөллийн үйлчилгээ авах, шүүхэд хандах, эрхээ сэргээлэх, иргэдийн эрхийн талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.	
	342	5.1.1.6. Хүний эрхийн боловсрол олгох сургалт, судалгаа, мэдээллийн арга хэмжээг төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулах	2016-2020	ХЭЗХ		Орон нутагт хүний эрхийн зөрчил буурч, иргэд мэдээлэлтэй болсон байна.	100
/66/ 5.1.2. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулж хяналт тавих, байгууллагын шударга түвшний үнэлгээг нэмэгдүүлэх	343	5.1.2.1. Сум, байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлтүүдийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх	2016-2020	ХЭЗХ		Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	100
	344	5.1.2.2. Сум, байгууллагын шударга түвшний үнэлгээг олон нийтийн оролцоотой хийх	2016-2020	ХЭЗХ	1.5	Шударга түвшний үнэлгээг журмын дагуу хийгдэж дүн танилцуулагдс	70

						ан байна.	төрийн бус байгууллага санал ирүүлснээс “Булганы өнгө” төрийн бус байгууллага шалгарч ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна. Дээрх төрийн бус байгууллага нь Гурванбулаг, Бугат, Хутаг-Өндөр, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газруудын үйл ажиллагаанд үнэлгээ өгөхөөр ажиллаж байна. Төрийн байгууллагын шударга түвшний үнэлгээг хийлгэх ажлын хүрээнд орон нутгийн төсвөөс үйл ажиллагааны зардалд 1500000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн Олон нийтийн дэд зөвлөл, Иргэний зөвлөл, Лиос сангийн Булган аймаг дахь салбартай хамтран төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоонд үнэлгээ хийж дүнг 11 дүгээр сарын 30-ны өдөр танилцуулахаар бэлтгэж байна.	
	345	5.1.2.3. Олон нийтэд авлига, ашиг сонирхлын зөрчил болон авлигын шалтгаан нөхцөлд хийсэн судалгааны дүнд үндэслэсэн сургалт мэдээллийг хийх	2016-2020	ХЭЗХ	3.2	Иргэдэд авлигаас урьдчилан сэргийлэх мэдээлэл хүрсэн байна	Авлигын эсрэг төлөвлөгөөний дагуу зарим сум, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээг хийлгэж эхлээд байна. Төрийн байгууллагын ил тод байдал, шударга түвшний үнэлгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлын урилгыг нээлттэйгээр олон нийтэд хүргэж 3 төрийн бус байгууллага санал ирүүлснээс “Булганы өнгө” төрийн бус байгууллага шалгарч ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна. Дээрх төрийн бус байгууллага нь Гурванбулаг, Бугат, Хутаг-Өндөр сумд, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газруудын үйл ажиллагаанд үнэлгээ өгөхөөр ажиллаж байна. Төрийн байгууллагын шударга түвшний үнэлгээг хийлгэх ажлын хүрээнд орон нутгийн төсвөөс үйл ажиллагааны зардалд 1500000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн Олон нийтийн дэд зөвлөл, Иргэний зөвлөл, Лиос сангийн Булган аймаг дахь салбартай хамтран төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоонд үнэлгээ хийж дүнг 11 дүгээр сарын 30-ны өдөр танилцуулахаар бэлтгэж байна.	100
	346	5.1.2.4. Нутгийн удирдлагын байгууллагын шийдвэрт судалгаа хийж, шийдвэрийн системчлэл хийх	2016-2020	ХЭЗХ		Мэдээллийн сан бүрдсэн байна.	2018 оны байдлаар аймгийн Засаг даргын 740 захирамж, 10 сумын 800 гаруй захирамж, 540 тушаал шийдвэрийн үндэслэлийг хянаж, зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа. Мөн 2015, 2016, 2017, 2018 оны нийт 131 захирамжийн эх хувьд өөрчлөлтийг хийж цахим санд орууллаа.	100

/67/ 5.1.3. Нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагын оролцоонд түшиглэн зохион байгуулж, хяналт, хамгаалалтын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэхийн зэрэгцээ тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	347	5.1.3.1. Булган сумын нийтийн эзэмшлийн зам талбай, уулзвар гарц болон улсын чанартай авто замын хяналтын постуудыг камераар тоноглох	2016-2020	ХЭЗХ, ЦГ	2.7	Нийтийн эзэмшлийн болон замын гарц, улсын чанартай авто замын постууд бүрэн камержсан байна.	Улсын чанартай авто зам дагуух 5 постод 2700000 төгрөгөөр нарны гэрлээр ажиллах туузан гэрлийг байршуулан хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавьж ажиллаж байна. Улсын чанартай авто зам дагуу Рашаант, Баяннуур сум, Булган сумын зоон давааны хяналтын постуудыг 2017-2018 онд бүрэн камержуулж, Тээврийн цагдаагийн албаны шуурхай удирдлагын төвтэй шууд холбогдож замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн хянаж, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Булган сумын нийтийн эзэмшлийн зам, талбайд ажиллаж буй 82 ширхэг хяналтын камераас 30 ширхэг нь эвдэрч, ашиглах боломжгүй байсныг 10200000 төгрөгөөр засварлаж, Цагдаагийн газарт хүлээлгэн өгсөн.	100
	348	5.1.3.2. Шатахуун түгээх станц болон онцгой барилга объектууд, олон нийтийн үйлчилгээний заал бүхий аж ахуйн нэгжүүд, төр, төсвийн байгууллагуудын дунд орчин тойрноо хяналтын камераар тоноглох хөдөлгөөн өрнүүлэх	2016-2020	ЦГ, СХЗХэлт эс, иргэн, ААН		Аян өрнөж, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гаднах талбай камержсан байна.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 34 шатахуун түгээх станцуудын үйл ажиллагаанд дотоод аюулгүй байдлын шалгалт хийсэн. Шалгалтын явцад зөрчилтэй 8 шатахуун түгээх станц байгааг илрүүлэн албан мэдэгдэл өгч зөрчлийг арилгуулан камержуулалтыг хийсэн байна. Цагдаагийн газрын камерын системийг бүрэн ашиглах, теле хяналтыг бүрэн хийх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгжийг татан оролцуулах, өнөөгийн нөхцөл байдлын талаарх танилцуулгыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулсан.	100
	349	5.1.3.3. Зарим сумдыг хяналтын камерын системтэй болгох	2016-2020	ЦГ, Сумын ЗД	12.0 /Хандив /	Сумд бүрэн хяналтын камерийн системтэй болсон байна.	Аймгийн хэмжээнд хяналтын камерт холбогдоогүй Рашаант, Тэшиг, Бугат зэрэг сумд, Хялганат тосгоны удирдлагуудад сум, тосгоны төвийг камержуулах санал хүргүүлсэн. Түүнчлэн сумын төвдөө хяналтын камергүй сумдын судалгаа, хяналтын камерт холбоход шаардлагатай тооцоог гаргаж Цагдаагийн ерөнхий газрын Холбооны төвд санал хүргүүлээд байна. 2018 онд Гурванбулаг сумын төвийг иж бүрэн камержуулахад 30.0 сая төгрөг, Булган сумын төвийн камерыг бүрэн засварлахад 10.0 сая төгрөгийг зарцуулж ашиглалтад оруулсан байна. Мөн Булган сумын төвийн 18, Зоон давааны постын 4, аймгийн 16 сумын болон гүүрэн гарцын хяналтын камеруудыг бүрэн засварлаж ашиглалтад оруулсан байна. Орхон сумын 3, Орхон голын гүүрэн гарцын 3, Гурванбулаг	100

							сумын 18, Хялганат тосгоны Сэлэнгэ голын гүүрэн гарцын 3, Хутаг-Өндөр сумын гүүрэн гарцын 3, Баян-Агт сумын Хануйн голын гарцын 2 нийт 70 камерыг засварлаж ашиглалтад оруулсан. Тэшиг сумын Эгийн голын гүүрэн гарцын хяналтын камерын тог хувиргагч шатсантай холбогдуулж, гүйцэтгэгч компанид баталгаат хугацаа дуусаагүй байгаа тул засварлуулах саналыг хүргүүлээд байна.	
	350	5.1.3.4. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хөршийн хяналт”, “Урамшилт эргүүл” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх	2016-2020	ЦГ, Сумын ЗД	2.31	Гэмт хэргийн гаралт буурсан байна	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн ИТХ-ын 2016 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Сайн хөрш” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс 16 сум, 1 тосгоны бүх багуудад сургалтыг 56 удаа зохион байгуулсан. Олон нийтийн эргүүлд 218 иргэнийг ажиллуулж, Цагдаагийн газраас мэргэжлийн удирдлагаар ханган ажилласан байна. Олон нийтийн эргүүлд ажилласан алба хаагчид 86 зөрчил илрүүлж холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, 177 аж ахуйн нэгж, байгууллага, 184 иргэнд зөвлөгөө өгч, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн хуудсыг иргэдэд тараан ажилласан байна. Архидан согтуурах, гэр бүлийн хүчирхийлэл, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 төрлийн 650 ширхэг санамж зөвлөмжийг 2310000 төгрөгөөр хэвлүүлж аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран санхүүжүүлсэн. Аймгийн хэмжээнд эхний 10 сарын байдлаар 284 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26 хэргээр буюу 8.3 хувиар буурсан байна.	100
	351	5.1.3.5. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Хяналт шийдвэрлэлт” арга хэмжээ болон бүсийн хамтарсан	2016-2020	ХЭЗХ, ГХУСАС 3, сумын Засаг дарга	13.841	Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан байна.	Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хил залгаа аймгуудын хамтын ажиллагааг сайжруулах үүднээс хангайн бүсийн аймгуудын хамтарсан зөвлөгөөн Архангай, Өвөрхангай аймгуудад, Хууль зүй, дотоод хэргийн яам, Тээврийн цагдаагийн албанаас хамтран “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг сайжруулах нь” сэдэвт зөвлөгөөний Булган, Орхон, Хөвсгөл аймгийг хамруулан Орхон аймагт зохион байгуулагдаж холбогдох албаны хүмүүс оролцсон. Мөн аймгийн	100

		уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулах				малчдын зөвлөгөөнийг хамтран зохион байгуулж малчдад зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамж 4 удаа гаргаж аймгийн Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Тагнуулын хэлтэс хамтран хяналт шалгалтыг зохион байгуулж байна. Дээрх хяналт шалгалтын дүнд холбогдох хууль тогтоомж зөрчсөн аж ахуй нэгжид улсын байцаагчийн албан шаардлага өгөх, зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авснаас гадна Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 6 аж ахуйн нэгж иргэний үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоож, зарим этгээдүүдэд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Хяналт шалгалтыг суманд хийж байгаа бөгөөд байгаль хамгаалах сангаас 13841000 төгрөгийг зарцуулсан байна. Дээрх нэгдсэн арга хэмжээг шат дараатайгаар аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулснаар 2018 оны жилийн эцсийн байдлаар хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг өмнөх оныхоос 14 хэргээр буюу 116 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1 хэргээр буюу 3.5 хувиар, мал хулагайлах гэмт хэрэг 5 хэргээр буюу 16.6 хувиар тус тус буурсан байна.	
352	5.1.3.6. Мал хулгайлах гэмт хэрэг, Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн эрсдэл ихтэй “Нэг сум”, “Нэг баг”-ийг сонгон иргэд, малчдын оролцоотой урьдчилан сэргийлэх аргачлалыг нэвтрүүлж үр дүнг тооцох	2016-2020	ХЭЗХ		Малчдын бүлэг байгуулагдаж үйл ажиллагаа жигдэрсэн байна. Малчдад зориулсан гарын авлага гаргаж тараасан байна.	2018 оны 5 дугаар сард Архангай, Төв аймагт зохион байгуулагдсан Мал хулгайлах гэмт хэрэг, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүсийн аймгуудын зөвлөгөөнд Цагдаагийн газрын дарга, дэд дарга, холбогдох албан хаагч нар оролцож өөрсдийн аймгийн талаарх мэдээллийг танилцуулсан байна. Мөн 2018 онд Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малчдын бүлэг байгуулах талаар аймгийн малчдын зөвлөгөөний үеэр Дашинчилэн, Могод, Гурванбулаг, Рашаант, Баяннуур, Хишиг-Өндөр, Орхон, Бүрэгхангай зэрэг сумын малчдад мэдээлэл өгч бүлэг байгуулах, хэрхэн хамтарч ажиллах талаар чиглэл өгсөн. 2018 оны байдлаар малчдын бүлэг байгуулах ажлын	100

						хүрээнд Гурванбулаг сумын Тогоо 1-р багт малчдын бүлгийг байгуулж багийн Засаг даргад зааварчилгаа өгч Төв аймгийн Баянчандмань сумын малчдын бүлгийн туршлагыг судлуулан хамтран ажиллаж байна. 2018 онд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг ихээр үйлдэгддэг, үйлдэгдэх эрсдэл бүхий Бүрэгхангай сумын 3-р багийг сонгон авч сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран тус багт оршин суудаг, алт олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжийн 84 иргэнд яриа, таниулга хийж гарын авлага материал өгсөн байна. 2018 оны 10 дугаар сарын байдлаар Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 4-ийг илрүүлж, 2 гэмт хэргийг яллагдагчаар татаж хэргийг прокурорт шилжүүлсэн байна. Одоогийн байдлаар 63 малчны бүлэг байгуулагдсан.		
	353	5.1.3.7. Хутаг-Өндөр суманд Замын хяналтын постыг барьж, шаардлагатай сумдыг хурд хэмжигч багажтай болгох	2016-2020	ЦГ		Замын хяналтын пост баригдсан байна.	Хутаг-Өндөр суманд баригдах замын хяналтын постны зураг төсвийг бэлэн болгож, хөрөнгийг улсын төсөвт тусгуулах саналыг хүргүүлээд байна. 2017 онд Тээврийн цагдаагийн албанаас 1 ширхэг, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 1 ширхэг хурд хэмжигч олгосон.	40
	354	5.1.3.8. Орон нутгийн чанартай авто замын уулзваруудад тэмдэг, тэмдэглэгээ тавьсан ажлыг үргэлжлүүлэх, боловсронгуй болгох	2016-2020	ЦГ, Сумын Засаг дарга	127.4/УТ, ОНТ/	Замын тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийгдсэн байна.	Орон нутгийн болон хатуу хучилттай замын тэмдэг, тэмдэглэгээ, замын байгууламжид үзлэг шалгалтыг аймгийн Засаг даргын захирамжаар мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан ажлын хэсэг томилон шалгалтыг зохион байгууллаа. Сайхан суманд орон нутгийн төсвөөр 18 тэмдгийг шинээр хийлгэж 1800000 төгрөг зарцуулсан байна. Мөн Баян-Агт сумын төвд 2 цэгт хурд сааруулагч байрлуулсан, Булган сумын 5-р баг Спортын ордны баруун талаас Нэгдсэн эмнэлгийн баруун талын авто замтай холбох замд 20 ширхэг тэмдэг, 3-р багийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн эгц арагшаа өгссөн авто замыг гэр хорооллын хөндлөн авто замтай холбоход 10 ширхэг замын тэмдэг, тэмдэглэгээг "Булган АЗЗА" ТӨХК шинээр тавихаар болоод байна. Мөн Булган сумын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран Булган сумын замын тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг зохион байгуулж сумын төвд шаардлагатай 60 ширхэг тэмдэгний судалгааг	100

							гаргаж сумын ИТХ-д санал хүргүүлээд байна. Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан 5.6 сая төгрөгийн 33 ширхэг тэмдэг, 20 түмбэ шинээр авч тэмдэгжүүлсэн. "Булган АЗЗА" ТӨХК-тай хамтран улсын чанартай авто замын тэмдэг, тэмдэглэгээнд нэгдсэн шалгалт явуулж тэмдгийн бүрэн бүтэн байдал, стандарт шаардлага хангасан эсэхийг шалгаж Зам тээврийн хөгжлийн яаманд санал хүргүүлж 757 ширхэг тэмдгийг шинээр хийлгэн байршуулж, дахин 89 тэмдгийг хийлгэлээ. Рашаант суманд “Эрдэнэсант АЗЗА”-тай хамтран 52 тэмдэг, 2 анхааруулах самбар, Дашинчилэн, Баяннуур, Гурванбулаг чиглэлийн замд “Дашинчилэн АЗЗА”-тай хамтран 245 тэмдэг шинээр хийлгэж тус тус байрлуулан хөдөлгөөнийг зохицуулан ажиллаж байна.	
	355	5.1.3.9. Булган сумын 6-р баг дахь Шунхлайн ШТС-ын гурван замын уулзварт хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио суурилуулах	2016-2020	ЦГ	2.0/хна див/	Гурван замын уулзварт гэрлэн дохио тавигдсан байна.	Шунхлай ШТС-ын уулзварт хандивын 2.0 сая төгрөгийн хөрөнгөөр хяналтын камерыг шинээр авч суурилуулсан. Мөн дээрх тойрог замыг 10 м өргөтгөж, хөдөлгөөнийг 3.1 /гол зам/, 3.4 /зам тавьж өг/ тэмдэг байрлуулан зорчих дарааллыг тогтоож өгч хөдөлгөөнийг зохицуулж байна.	70
	356	5.1.3.10. “Эрүүл ирээдүй” дэд хөтөлбөрийг баталж, ТББ-ын оролцоотойгоор хэрэгжүүлнэ. Гүйцэтгэгчийн урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлын үр дүнг хөндлөнгийн үнэлгээгээр үнэлэх	2016-2020	ХЭЗХ	10.2	Хөтөлбөрийн зорилтын дагуу сургалт, нөлөөллийн ажлууд хийгдсэн байна.	“Эрүүл ирээдүй” дэд хөтөлбөрийн хэрэгжлтийг зохион байгуулан ажиллаж байна. 2018 оны гүйцэтгэлийг 11 дүгээр сард аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулахаар бэлтгэж байна. Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад зан үйлд нөлөөлөх сургалтыг “Ухаарлын жимээр” ТББ, “Гэрэлт ирээдүй оршихуй” ТББ-даар гүйцэтгүүлж 400 гаруй сурагчийг хамруулсан. Мөн цагдан хоригдож байгаа иргэдэд зан үйл, сэтгэл заслын сургалтыг “Гэрэлт ирээдүй оршихуй” ТББ-аар хийлгэж байна. Мөн архины хамааралтай, хорт зуршлаас татгалзах эрмэлзэлтэй 15 хүнийг хордлого тайлах, зан үйлд нөлөөлөх эмчилгээнд хамруулж, гэр бүлийн гишүүдийг гар урлалын сургалтад хамруулж цаашид жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамруулахаар зохион байгуулж байна.	70
	357	5.1.3.11. Гэр бүлийн хүчирхийллээс	2016-2020	ХЭЗХ		Төрийн бус байгууллагата	“Монгол төрх” төрийн бус байгууллагатай хамтран “Эрүүл ирээдүй” хөтөлбөрийн хүрээнд сургагч багш	100

		урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг ТББ-аар гүйцэтгүүлэх				й хамтран ажиллах гэрээ байгуулж сургалтууд хийгдсэн байна.	нарыг бэлтгэж арга зүйгээр ханган ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон эрсдэл бүхий иргэдэд ГБХЗХГ-ын сэтгэл зүйчтэй хамтран зөвлөгөө, хамгааллын үйлчилгээг үзүүлж байна. Мөн “Гэрэлт ирээдүй оршихуй” төрийн бус байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх сургалтыг хийлгэж байна.	
	358	5.1.3.12. Хүний эрхийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, арилгах арга хэмжээг зохион байгуулах	2016-2020	ХЭЗХ		Хүний эрх хангагдаж, иргэдэд мэдээлэл хүрсэн байна.	Орон нутаг дахь хүний эрхийн мэргэжилтэнтэй хамтран Эрүүл мэндийн салбарт хүний эрх зөрчигдөж байгаа талаар судалгааг цахимаар болон цаасаар, газар дээр нь амаар авч нэгтгэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан Хүний эрхийн үндэсний комисст хүргүүлсэн. 2018 оны байдлаар аймгийн Прокурорын газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран цагдан хорих байр, эрүүлжүүлэх баривчлах байрны нөхцөл байдал, баривчлагдсан иргэдийн эрхийн зөрчлийн талаарх шалгалтыг 2 удаа хийсэн. Шалгалтын явцад хүний эрхийн ноцтой зөрчил илрээгүй бөгөөд Цагдаагийн газрын эрүүлжүүлэх баривчлах байр стандарт шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гарч орчин нөхцөлийг сайжруулах 2 албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Цагдаагийн ерөнхий газарт дээрх шалгалтын дүн, саналыг албан тоотоор хүргүүлээд байна	100
/68/ 5.1.4 Хууль хяналт, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг хуулийн дагуу дэмжиж /шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, ажиллах	359	5.1.4.1. Хууль зүйн салбарын байгууллагуудын нээлттэй хэлэлцүүлэг, хамтарсан эрх зүйн сургалтыг сум, багт зохион байгуулах	2016-2020	ХЭЗХ		Хамтарсан сургалтууд хийгдсэн байна.	2018 оны 10 дугаар сарын байдлаар Эрх зүйн багаар дамжуулан хамтарсан сургалтыг 2, 4-р улиралд сум, багийн түвшинд зохион байгуулж 16 сум, 1 тосгоны 3460 иргэнд хүрч ажилласан. Сургалтаар 2018 онд шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон 26 төрлийн гарын авлагыг иргэдэд тарааж өгсөн байна. Шүүх, Прокурор, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний алба хамтран Эрүүгийн хуулийг нэг мөр хэрэглэх, Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.	100

нөхцөл/, хууль сурталчлах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж иргэдийн “АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧИН”-ыг бүрдүүлнэ.	360	5.1.4.2. Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг тогтмол хянаж шалгах	2016-2020	МХГ	Байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгана	Тайлант хугацаанд төлөвлөгөөт шалгалтыг 17 объектод хийхээр төлөвлөснөөс 5 объектод хяналт шалгалтыг хийсэн. 2.6 кодтой “Ил уурхайн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас” –аар шалгахад дунд эрсдэлтэй-4, бага эрсдэлтэй 1, 2.24 кодтой “Маркшейдерийн ажлыг шалгах хяналтын хуудсаар шалгахад бага эрсдэлтэй 1, дунд эрсдэлтэй-4 шалгагдсан. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай 5 албан шаардлага өгөгдсөн. Уул уурхайн олборлолтын дараах техникийн нөхөн сэргээлтийн явцыг шалгахад хагас жилийн байдлаар төлөвлөгдсөн талбайд 20%-ийн гүйцэтгэлтэй, ихэнх уурхай дотоод овоолгоор гүйцэтгэж байна. Байгаль орчин газрын харилцаа геодези зураг зүйн хяналтаар 60 объектод хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 42 объектод хяналт шалгалтыг хийсэн. 2.5 кодтой “Ой ашиглалтын мэргэжлийн байгууллагын мод бэлтгэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-аар 7 объект, 2.4 кодтой “Шатахуун түгээх станц, агуулахын байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-аар 8 объект, 2.23 кодтой үйлдвэр үйлчилгээ үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх хяналтын хуудас”-аар 6, 2.10 кодтой Газар олголтыг шалгах хяналтын хуудас”-аар 10, 2.12 кодтой газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн болон аж ахуйн нэгж байгууллагыг шалгах хяналтын хуудас”-аар 5, 3.15 кодой хог хаягдлын менежментийг шалгах хяналтын хуудас”-аар 4 объектод хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 120 заалт бүхий 30 албан шаардлага өгөгдсөн. Албан шаардлагын 96 заалт бүхий 26 нь биелсэн байна. Хууль сурталчлах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагууд, олон нийтийн оролцоог сайжруулан ажиллаж байна. Зөвлөн туслах үйлчилгээг 3 объектод үзүүлж ажилласан. 2 объектод 8 заалттай зөвлөмж өгсөн. Хадгалах хугацаа дууссан чанар байдлаа алдсан, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл байхгүй. Байгаль орчин газрын харилцаа геодези зураг зүйн	100
--	-----	--	-----------	-----	--	---	-----

							хяналтаар 23 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөснөөс 15 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж 65 заалт бүхий 15 зөвлөмж өгсөн. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 онд баталсан “Ой, ан, байгалийн ургамал түүж бэлтгэж байгаа байдалд цаг үеийн шинжтэй болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай”, “Бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн усанд шинжилгээний хяналт хийх тухай”, “100 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуухны ашиглалтаас хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тогтоох хяналт хийх”, “Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, тээвэрлэлтэнд хяналт тавих тухай” удирдамжуудаар хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулахаар 35 заалт бүхий 8 албан шаардлага өгч хууль бусаар ан амьтан агнасан 6 иргэнд 1500000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулсан байна. Хууль бусаар мод бэлтгэх, ан амьтан агнах, барих, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх зөрчил буурсан. Нийтийн эзэмшлийн газарт хог хаягдал хаях зөрчил буурахгүй байна.	
--	--	--	--	--	--	--	--	--

	361	5.1.4.3. Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, орон тооны бус зөвлөлийг чадавхжуулж, үйл ажиллагааг өргөжүүлэх	2016-2020	МХГ		Хүнсний аюулгүй байдал хангагдна	Сумдын “Хүнсний аюулгүй байдлын орон тооны бус зөвлөл”-ийн ажлыг эрчимжүүлэх, үйл ажиллагааг жигдрүүлэх чиглэлээр зөвлөлийн ажлын чиг үүрэг, тайлан мэдээний загварыг 01/132 албан тоотгоор хүргүүлж, мэдээ тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, цаг хугацаанд нь тогтмол ирүүлж байхыг мэдэгдэв. Хүнсний аюулгүй байдлын орон тооны бус зөвлөлийн ажлын тайланг хагас жилээр Булган, Баяннуур, Баян-Агт, Бугат, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Орхон, Сайхан, Хишиг-Өндөр, Хангал, Рашаант сумд, Хялганат тосгон ирүүлсэн бөгөөд Бүрэгхангай, Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр сумдууд тайлангаа огт ирүүлээгүй байна. Ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлын талаар санал хүргүүлэх ажил хийгдэж байна. Орон тооны бус зөвлөлийг сум бүрт шинэчлэн байгуулж ажиллах заавар журмыг баталсан аймгийн Засаг даргын захирамж гарч хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Ирэх 2019 онд сумдын орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, тайлан мэдээг тогтсон хугацаанд авч ажиллахаар төлөвлөөд байна.	100
	362	5.1.4.4. Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааг бэхжүүлж, лабораторийн байр, шуурхай албанд хэрэглэгдэх тусгай зориулалтын техник хэрэгсэлтэй болоход дэмжлэг үзүүлэх	2016-2020	ХЭЗХ, ШША	38 сая	Автомашинаар хангаж, шинэ байр барих газрыг шийдсэн байна.	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 38875000 төгрөгний үнэ бүхий бүрэн тоноглогдсон дунд оврын автомашиныг Шүүхийн шинжилгээний албанд авч өгсөн. Дээрх автомашин нь туузан гэрэл, дуут дохио бусад зориулалтын хэрэгслээр тоноглогдсон Grand Starex авто машин 1, зөөврийн асар 1 ш, титанаар хийгдсэн зөөврийн задлан шинжилгээний ширээ 1 ш, дугуйтай носилк, тог баригч, тод тусгалтай, хамрах хүрээ ихтэй прожектор, хэргийн газрын үзлэгийн цүнх /иж бүрэн/, шүүх эмнэлгийн задлан шинжилгээний цүнх /иж бүрэн/, нисдэг камер /дрон/, зургийн аппарат 1ш, биологийн гаралтай ул мөр, эд мөрийн баримт шинжилгээний дээж авах, хадгалах зөөврийн шүүгээ 1 ширхэг, эвхэгддэг ширээ, сандал 1 ком, биологийн гаралтай ул мөр эд мөрийн баримт, шинжилгээний дээжний нэг удаагийн хэрэглээний сав, хөвөн бамбар, мөр илрүүлэх нунтаг, тос, бодис, урвалж, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болох нэг хэрэглээний битүү комбинзон, цогцосны уут, бохир, хог хаягдал зайлуулах тусгай	100

						тэмдэглэгээ бүхий нийлэг уут зэргийг шаардлагатай тоо хэмжээгээр орон нутгийн төсвөөр бэлтгэн албаны материаллаг баазыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж хүлээлгэн өгсөн. Шүүхийн шинжилгээний албаны конторын барилгыг аймгуудад нэгдсэн зураг төсвийн дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс барьж эхлэхтэй холбоотойгоор уг конторыг барих газрын асуудлыг шийдвэрлэсэн.	
363	5.1.4.5. Хаягжуулалтын тухай хуулийг хэрэгжүүлж, иргэний бүртгэлийн хаягийн өөрчлөлт хийх	2016-2020	УБХ		Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Хаягжуулалтын хуулийн дагуу иргэний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хаягийн хөдөлгөөнийг тухай бүр хийж байна. Иргэний хаягийн бүртгэлийн хөдөлгөөнийг 2018 оны 10 дугаар сарын байдлаар 4800 иргэнд хийсэн.	100
364	5.1.4.6. Зарим байгууллагуудын байрны асуудлыг шийдвэрлэж, үйлчилгээний нөхцлийг сайжруулах	2016-2020	УБХ, ШША, ЦГ, МХГ,	УБХ, ШША, ЦГ, МХГ	Албан байраар хангагдаж ажиллах нөхцөл сайжирсан байна.	Улсын бүртгэлийн хэлтсийн байрны асуудлыг шийдсэн. Шүүхийн шинжилгээний албаны конторын шинэ барилгыг улсын төсвөөр барихтай холбоотойгоор шинэ байр баригдах газрын асуудлыг шийдэж холбогдох материалыг яам болон дээд газарт хүргүүлсэн. Цагдаагийн газрын засварын ажилд орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Цагдаагийн газрын байрны их засвар болон өргөтгөл барих зураг төсвийг хийлгэж, шаардагдах санхүүжилтийг 2019 оны улсын төсөвт тусгахаар санал хүргүүлсэн.	70
365	5.1.4.7. Улсын бүртгэлийн үйлчилгээнд мэдээллийн технологи, программ хангамжийг нэмэгдүүлж, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивыг цахим архивт шилжүүлэх	2016-2020	УБХ		Улсын бүртгэлийн үйлчилгээ бүрэн цахимжсан байна.	Засгийн газрын "Ухаалаг засаг" төслийн хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн архивыг цахимжуулах ажлыг "ЭС ТИ ЭКС СИТИНЕТ" ХХК хариуцан Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран ажиллаж 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 2018 оны 3-р сарын 01-ний хооронд 13815 хувийн хэргийн 365884 хуудас материалыг цахимжуулан мэдээллийн нэгдсэн санд оруулж дууссан. Төслийн хүрээнд эд хөрөнгийн ажилтнуудын техник, тоног төхөөрөмж шинэчлэгдэж ажиллах нөхцөл сайжирсан болно. Эд хөрөнгийн бүртгэл цахим бүртгэлд шилжиж "Eprs" программаар бүртгэлийн үйлчилгээ хийгдэж байгаа нь бүртгэлийн үйл ажиллагаа сайжирч, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ хүнд сурталгүй, түргэн шуурхай болж байна.	100
366	5.1.4.8. Цагдаагийн газрын төв, хөдөөгийн	2016-2020	ЦГ, Сумын	улсын төсөв	Шаардлагатай автомашинаар	2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 29.28 сая, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 38.0 сая	100

		тасгуудыг ажлын шаардлага хангасан автомашинаар хангахад дэмжлэг үзүүлэх		Засаг дарга	297800 00 /орон нутгийн төсөв 43 сая/	хангагдсан байна.	төгрөгийн өртөг бүхий иж бүрэн тоноглолтой автомашин худалдан авч хүлээлгэн өгсөн. Мөн Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын төвөөс 500000 төгрөгийн үнэ бүхий суурин станцыг ирүүлж парк шинэлэл хийсэн. Хангал сумын Хялганат тосгон дахь Захирагчийн албанаас цагдаагийн албанд 5.0 сая төгрөг шийдвэрлэж тус албанд Приус-11 маркийн автомашин худалдан авч өгсөн байна.	
	367	5.1.4.9. Цагдаагийн газрын өргөтгөл, гадна фасад, сантехникийн их засвар, нийтийн байрны сантехникийг засварлах ажлыг дэмжих	2016-2020	ЦГ	орон нутгийн төсөв 10 сая	Их засварын ажил бүрэн хийгдэж ажиллах нөхцөл сайжирсан байна.	2018 онд орон нутгийн төсвөөс 10.0 сая, Цагдаагийн газар өөрсдийн урсгал зардлаас 6732000 төгрөгийн хөрөнгө оруулалт шийдэж гадна фасадыг засварласан. Нийтийн байрны их засварын ажил 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр туссан.	100
	368	5.1.4.10. Цагдаагийн хэсгийн байцаагч болон мөрдөн байцаагч нарыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах	2016-2020	ЦГ	Орон нутгийн төсөв 32,5 сая Улсын төсөв 850463 0 сая	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Гэрч хохирогчийг хамгаалах, мэдүүлэг авах өрөөг шинээр байгуулан орон нутгийн төсвөөс 15.0 сая, цагдаагийн албан хаагчдын хувцасны гадуур өмсдөг хантааз, албан хэрэгцээний автомашины дуут дохио зэргийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2.7 сая төгрөгөөр худалдан авч өгсөн. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар мөрдөн байцаагч нарын хэргийн газрын үзлэгт ажиллах нөхцөлийг сайжруулан иж бүрэн үзлэгийн цүнх, шаардлагатай багаж хэрэгсэл, зөөврийн компьютероор хангасан. Мөн ЦЕГ-аас 4 суурин компьютер, принтерийн хамт олгосон. Булган аймаг дахь Хас банктай хамтран Мэдүүлэг авах өрөөг 4.7 сая төгрөгөөр тохижуулсан. Бугат, Хангал, Тэшиг, Сайхан сумдад бэлэн бус торгуулийн машин, драйвер, компьютер зэрэг 14.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж хэсгийн төлөөлөгч нарт гардуулан өгсөн байна. Мөн Цагдаагийн газрын 80 жилийн ойг тохиолдуулан ЦЕГ-аас 5 ширхэг компьютер 6812500, зөөврийн компьютер 1389630, принтер 302500 төгрөгөөр нийт 8504630 төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.	100
	369	5.1.4.11. ШШГБ-уудад хүмүүжиж байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор	2016-2020	ХЭЗХ, ШШГА, Хорих анги		Ажлын байр нэмэгдсэн байна	Аймгийн хаалттай хорих 439-р ангид үйлдвэрлэлийн бүсэд 173 гаруй хоригдогсод ажиллаж гар урлал, арьсан эдлэл, сүлжмэл болон оёдлын чиглэлээр үйлдвэрлэл явуулж байна. 2018 оны 10 дугаар	100

		дэмжих, үйлдвэрлэлд ажиллуулах					сарын байдлаар дээрх хоригдогсдод цалин 10.5 сая төгрөг олгож, дотоод орлого 196.0 сая төгрөг олсон байна. Тус хорих анги нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Эрдэнэт үйлдвэрт баяжмалын уутыг дотооддоо үйлдвэрлэж нийлүүлж байна.	
	370	5.1.4.12. Хилчдийн ажиллах нөхцлийг сайжруулах, хил хамгаалалтын үйл ажиллагааг дэмжих	2016-2020	ХЭЗХ	улсын төсөв 25 сая	Хилчдийн нийгмийн баталгаа хангагдаж ажиллах нөхцөл бүрдсэн байна.	Хилчдийн амьдрах нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд заставын хүн эмнэлгийн байрыг шинэчлэн засварлаж, мөн хүүхдийн тоглоомын талбайг шинээр байгуулж ашиглалтад оруулсан байна. Дээрх зардалд орон нутгийн болон өөрсдийн зардлаар 25.0 сая төгрөг зарцуулсан. Хил хамгаалах байгууллагын алба хаагчид, хилчдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аймгийн ЭМГазар болон сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 2 удаа зохион байгуулж алба хаагчид болон тэдний ар гэрийнхнийг бүрэн хамруулсан.	100
	371	5.1.4.13. Төрийн архивын тасгийн байрыг стандартад нийцүүлэн тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах	2016-2020	Төрийн архивын тасаг		Ажиллах нөхцөл, хөмрөгийн аюулгүй байдал хангагдана	Аймгийн Төрийн архивын тасаг нь зориулалтын шинэ байранд орж, стандарт шаардлага хангасан нягтруулсан шүүгээ, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Төрийн архивын тасгийн үйл ажиллагаа жигдэрч архивын сан хөмрөгийн аюулгүй байдлыг бүрэн ханган ажиллаж байна.	100
	372	5.1.4.14. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж, цахим архивт шилжүүлэх	2016-2020	Төрийн архивын тасаг		Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлж дуусгана	Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд “Мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн дөрөвдүгээр үе шатанд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 2018 онд Архивын 2 хөмрөгийн 13 дансны 888 хадгаламжийн нэгжийн /хн/ 51695 хуудас баримтыг хөмрөгийн түвшинд нягтлан шалгаж, дахин боловсруулалт хийлээ. Архивын 329 хадгаламжийн нэгжийн 20255 хуудас баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийлээ. Архивын 3 хөмрөгийн 14 дансны 349 хадгаламжийн нэгжийн 22170 хуудас баримтыг шинээр үдэж хавтаслан нүүр бичилтийг үйлдэв. Архивын 2 хөмрөгийн 13 дансны 329 хадгаламжийн нэгжийн 20255 хуудас баримтыг скайнердан мастер буюу анхны хувийг үйлдэн тусгай файл үүсгэн хадгалах ажлыг зохион байгуулав. Архивын 3 хөмрөгийн 14 дансны 347 хадгаламжийн нэгжийн 22102 хуудас баримтыг фотошоп программаар засварлан	100

							ашиглалтын хувийг үйлдэн тусгай файл үүсгэн хадгалав. 3 хөмрөгийн 14 дансны 347 хадгаламжийн нэгжийн 22102 хуудас бүхий баримтнаас 18886 заалтыг PDF хэлбэрт хувирган шилжүүлж цахим холболт хийв. Архивын 3 хөмрөгийн 6 дансны 164 хадгаламжийн нэгжээс 13352 заалт, 72542 хүний нэр, 4832 байгууллагын нэр, 3134 газар зүйн нэр бүхий 15719 хуудас баримтыг AMS программд шивж цахим хэлбэрт шилжүүллээ.	
/69/ 5.1.5. Төрийн цэргийн бодлогын хүрээнд батлан хамгаалах бодлого, зорилтыг орон нутагт хэрэгжүүлж, эцэг-эх, цэрэг-дайчид, төр захиргааны байгууллагын холбоог нэмэгдүүлж, ирээдүй болсон хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлнэ.	373	5.1.5.1. Цэргийн жинхэнэ алба болон гэрээт цэрэг, цэргийн дүйцүүлэх албаны үйл ажиллагааг зохион байгуулах	2016-2020	ЦШ	ОНтөсө в 476800 0	Монгол Улсын Үндсэн Хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлнэ.	2017 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг халах, 2018 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татах ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон цэрэг татлагын товчоо, эмч нарын комиссын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж 16 сум, 1 тосгоны нийт 800 шахам цэргийн насны залуучуудыг урьдчилсан болон төвийн комиссын үзлэгт хамруулж 260 шахам хүнийг цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэн Хилийн болон Ерөнхий зориулалтын цэргийн ангиудад хуваарилан өгч, хугацаат цэргийн албыг хаалгаж байна. “Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам”-ын дагуу 6 иргэнийг гэрээт цэргийн албанд сонгон шалгаруулалтаар тэнцүүлэн Зэвсэгт хүчний ангид албыг нь үргэлжлүүлэн хаалгаж байна. Зэвсэгт Хүчний Жанжин Штабаас өгсөн гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдын хяналтын тоог 100% биелүүллээ. Батлан хамгаалахын Сайдтай, аймгийн Засаг даргын 2018 онд хамтран ажиллах гэрээний дагуу Булган аймагт цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж буй иргэдийн цэргийн анхан шатны бэлтгэлийн нэгдсэн сургалтыг аймгийн Засаг даргын 2018 оны А/504 дугаар захирамжийн дагуу 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 09 дүгээр сарын 23-ны өдрүүдэд 14 хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн сургалтын төвд төвлөрүүлэн зохион байгууллаа.	100
	374	5.1.5.2. Аймгийн дайчилгаа удирдлагын байрыг тохижуулж, дайчилгааны даалгаврыг хэрэгжүүлэн, бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний	2016-2020	ЦШ	Улсын Төсөв 483875 0	Аймгийн дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжих нөхцөл бүрдэнэ.	Булган аймагт 2018 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг 12 дугаар сарын 10-наас 1 дүгээр сарын 10-ны хооронд цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журмын дагуу явуулж, дүнг 1 дүгээр сарын 10,12-ны өдрүүдэд нэгтгэж, сумдын ЗДТГ-ын дарга нарт 2 өдрийн сургалт семинарыг зохион байгуулав.	100

		сургалтыг орон нутагт зохион байгуулах					БХЯ-аас зохион байгуулсан Цэрэг-стратегийн бэлтгэл сургалтад аймгийн Засаг дарга, АЗДТГ-ын дарга нарыг оролцуулсан. Аймгийн дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжих нөхцөлийг хангах зорилгоор 16 суманд цэрэг, техникийн тодотголыг 3 дугаар улиралд багтаан явуулж, дайчилгааны даалгавар бүхий цэргийн ангитай шинэчилсэн тодотголыг хийлээ. Батлан хамгаалахын Сайдтай, аймгийн Засаг даргын 2018 онд байгуулсан гэрээ, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2018 оны н/14 тоот тушаалын дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнээс түрүүч, байлдагч 40 хүнийг шинээр мэргэжил эзэмшүүлэх сургалтыг 2018 оны 05 дугаар сарын 14-нөөс эхлэн 14 хоногийн хугацаатай дайчилгааны даалгавар бүхий ЗХ-ний 186-р ангийн “Сургалтын төв”-д төвлөрүүлэн зохион байгууллаа. Оюутан-цэрэг хөтөлбөрийг Булган аймагт хэрэгжүүлэн ХАА-н МСҮТ-ийн 15 оюутанд цэргийн ерөнхий бэлтгэлийн сургалтыг Цэргийн штабын офицерууд явуулж тусгай бэлтгэлийн сургалтыг Зэвсэгт хүчний 186 дугаар анги удирдан зохион байгуулж цэргийн албыг нь хаалгасан байна.	
	375	5.1.5.3. Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлж, хүүхэд залуучуудын дунд цэрэгжсэн тоглолт, спорт урлагийн тэмцээн зохион байгуулж, цэрэг, эх оронч үзэл төлөвшүүлэх	2016-2020	ЦШ	ОНТөсө в 219400 0	Цэрэг эх оронч үзэл төлөвшиж, цэргийн алба хаах сонирхол нэмэгдэнэ.	Зэвсэгт хүчний болон хилийн цэргийн анги байгууллагуудад цэргийн албаа үлгэр жишээ, нэр төртэй хааж байгаа нэр бүхий 10 цэргийн албан хаагчдын ар гэрт талархлын захидал, тавгийн идээ гардуулан өгсөн. Цэрэг татлагын товчоо, Хил Хамгаалах Ерөнхий газартай хамтран иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд ХЦ-ийн 0243-р анги дээр эцэг-эх, цэрэг-дайчид, төр захиргааны байгууллагын гурвалсан уулзалтыг зохион байгууллаа. “Монгол цэрэг-дэлхийн цэрэг” сэдэвт Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, Энхийг сахиулах ажиллагааны зорилго, ач холбогдлыг сурталчлах ажлыг хөтөлбөрийн дагуу Бугат, Сэлэнгэ сум, Хялганат тосгонд зохион байгуулан ажиллалаа. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд “Марш тактик-тусгай бэлтгэл”-ийн аварга тасаг шалгаруулах тэмцээнийг ХЦ-ийн 0286 дугаар ангитай хамтран зохион байгуулан явуулсан. Монгол төрийн цэргийн нэрт жанжин, тусгаар тогтнолын төлөө цогтой тэмцэгч, ардын Хатанбаатар Сандагдоржийн	100

							Магсаржавын мэндэлсний 140 жилийн ойд зориулж ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэг-спортын “Дөл” тэмцээнийг зохион байгуулж, түүний алдар гавьяа, түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, нөлөөг сэргээх, өсвөр үе, хүүхэд багачууддаа түгээн таниулж, цэрэг, эх оронч хүмүүжил олгох, бие бялдрыг өв тэгш хөгжүүлж, өсвөр үеийнхэнд цэргийн алба хаах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор 2018 оны 10 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Булган суманд зохион байгуулсан.	
/70/ 5.1.6. Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх тогтолцоог орон нутагт бүрдүүлж, гамшгийн эрсдэл, эмзэг байдал, хохирлыг бууруулах зорилгоор олон нийтэд тулгуурласан удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлнэ.	376	5.1.6.1. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулж сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах	2016-2020	ОБГ	2	Гамшгаас хамгаалах бэлэн байдал хангагдна	- Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулах зорилгоор 2018 онд аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээнд 5 асуудлыг тусган хэрэгжүүлээд байна. - 2018 оны 01 дүгээр сард сумын ИТХ, Засаг дарга нарт гамшгаас хамгаалах чиглэлээр 2017 онд зохион байгуулсан ажил, гарсан хүндрэл, дутагдал, 2018 онд зохион байгуулах ажил, цаашид анхаарах асуудлын талаар танилцуулан, Онцгой байдлын газрын даргын зөвлөмжийг өгч хэрэгжилтийг хангууллаа. - Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг тус тус хэрэгжүүлэх 2017 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд 2018 оны 3 дугаар сард “Сургалт, дадлага зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2011 оны А\132 тоот захирамж, “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, бэлтгэл бэлэн байдлыг хангах тухай” аймгийн Засаг даргын 2018 оны 03-р сарын 13-ны өдрийн 01/303, 01/304 тоот албан бичиг, заавар зөвлөмжийн хамт 16 сум, 1 тосгон, 75 байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн, алба хаагчдыг хуваарилан биелэлтийг нь хангуулан сургууль дадлагад Булган сумын төвд 70 аж, ахуйн нэгж, байгууллагын 1539 ажилтан албан хаагч, 10 техник, Хөдөөгийн 15 сум, 1 тосгоны 171 байгууллагын 3024 том хүн, 1864 хүүхэд 161 машин техник хамрагдаж, нийт 6427 хүн, 241 байгууллага, аж ахуйн нэгж, 171 техник оролцуулан хийгдлээ. 2018 оны 3 дугаар сард 16 сум, 1 тосгоны хэмжээнд Газар	100

						хөдлөлтийн гамшгийн үед амжиж анхааруулах зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага сургууль зохион байгуулагдаж 171 байгууллага, аж ахуй нэгж, 242 техник, 6427 хүн хамрагдсан байна. -Аймгийн удирдах ажилтны шуурхайд Онцгой байдлын газраас 14 хоног тутам гамшиг, аюулт үзэгдлийн нөхцөл байдлын мэдээлэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх, анхаарах асуудлын талаар танилцуулан санал хүсэлтийг хүлээх авах, аймгийн удирдлагаас өгсөн үүргийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна. - Монгол Улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2018 онд байгуулсан гэрээний дагуу 2018 оны 09-р сарын 05-ны өдрийн “ажлын хэсэг байгуулах тухай” А/519 тоот захирамжаар аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан аймгийн Онцгой комиссын хурлыг зохион байгуулж үүрэг чиглэл өгөн хэрэгжилтийг хангуулан ГХ-лах аймгийн алба, тусгай зориулалтын мэргэжлийн анги, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд аймгийн Засаг даргын сургууль дадлага зохион байгуулах, идэвхтэй оролцох талаар үүрэг өгөн бэлэн байдлыг “Яаралтай цуглар дохио”-гоор 6 удаа цуглуулан бэлтгэл ажлыг хангуулж 2018 оны 09-р сарын 10-14-ны өдрүүдэд Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгуулан явуулсан. Гамшгаас хамгаалах команд штабын сургуульд 14 гамшгаас хамгаалах алба, 19 мэргэжлийн анги, 19 сум, 1 тосгоны захирагч, Засаг дарга, Аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нийт 653 хүн, 34 техник оролцож “Дүүрэн хангалттай” үнэлгээ авсан. - 2018 оны 01 дүгээр сард “Эрсдэлээс хамтдаа сэргийлье” сэдэвт сарын аяныг Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газруудтай хамтран төлөвлөгөө гаргаж зохион байгууллаа. Тус аяны хүрээнд орон байрны галын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр айл өрхөөр хяналт шалгалт хийж сэрэмжлүүлэг, зөвлөгөө өгөх, Ерөнхий боловсролын	
--	--	--	--	--	--	---	--

						сургуулийн орчин дахь гар утасны хэрэглээнд хязгаарлалт тавих, ахлах ангийн сурагчдад нөхөн үржихүй, эрүүл мэндийн чиглэлээр мэдээлэл өгч эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах “Цахим тоглоом” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж цахим тоглоомын газруудад аюулгүй байдлын үзлэг шалгалт хийж, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах Эрсдэлтэй гудамж талбайн гэрэлтүүлгийг сайжруулах талаар сумын удирдлагуудад танилцуулан шийдвэрлүүлэхээр тус тус ажлыг зохион байгуулсан. - Гал түймэр унтраах, аврах 20-р анги, Эрэн хайх, аврах салбарын бие бүрэлдэхүүн Булган сумын 5-р багийн нутаг дэвсгэрт байрлах “Булган мээж” ОНӨХХК-тай хамтарсан Газар хөдлөлтийн улмаас гарсан гал түймрийг унтраах, нурангинд дарагдаж бэртэсэн иргэдийг эрэн хайх аврах ажиллагааны "Тактик"-ийн сургуулийг зохион байгуулж, ажилтан албан хаагч нарт гал унраагуураар хэрхэн ажиллах талаар дадлага сургууль хийлээ. - Аймгийн Засаг даргын “Үзлэг сургалт зохион байгуулах тухай” 2018 оны 04-р сарын 02-ны өдрийн А/204 тоот захирамж, “Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт” зохион байгуулах удаирдамжийн дагуу ОБГ, БОАЖГ-тай хамтран 2 ажлын хэсгийг 16 суманд ажиллуулж сумын Засаг даргаас холбогдох хуулийн хэрэгжилт, байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдал, ангиллын сургалт, сурталчилгаа, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах, сурталчилах, иргэдийн санал хүсэлтийг авах, сум, баг, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулж чадавхижууллаа. Уг шалгалтын хүрээнд аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран гамшиг ослоос урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны материал хэвлүүлэн А-3 календартай плакат, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх багц нугалбар, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх А-5 санамж, жижиг санамж хэвлүүлэн иргэд, байгууллагуудад	
--	--	--	--	--	--	---	--

						тараасан. - 2018 оны 06 дугаар сарын 03-10-ны өдрүүдэд Булган аймгийн Хууль зүйн хэлтэстэй хамтран хууль эрх зүйн багийн бүрэлдэхүүнд орж Булган аймгийн 16 сум 1 тосгоны нийт 816 иргэн ажилчин, албан хаагчдад байгууллагын үйл ажиллагааг танилцуулан сурталчилж, гамшгаас хамгаалах тухай, галын аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох гамшгаас хамгаалах эрх зүйн талаар сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан. - 2018 оны 04-р сард Булган сумын Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар хамтран Булган сумын байгууллага, аж ахуйн нэгжийн ой, хээрийн түймэрт дайчилгаагаар ажиллах томилгоот 1, 2, 3 дугаар ээлжийн бие бүрэлдэхүүний, Яаралтай цуглар дохиогоор Цогт хунтайжийн талбайд цуглуулж, хувийн бэлтгэл болох хувцас, аранз, багаж зэвсэглэмжийн бэлэн байдлын үзлэг хийж илэрсэн зөрчилд арилгуулах үүрэг өгөн Булган сумын Соёлын ордонд ой, хээрийн галын түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах арга зүй, бэлэн байдлаа хангах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын хангах зэрэг сэдвээр сургалт хийж аюулгүй ажиллагааны зааварчлага өгч гарын үсэг зуруулан, аймгийн баяр наадмын цэнгэлдэх хүрээлэнд түймэр унтраах дадлага сургууль хийгдлээ. Сургалт, дадлагад Булган сумын 323 иргэн хамрагдсан. - 2018 оны 02 дугаар сард аймгийн Цагдаагийн газрын 39 албан хаагчдад орон байрны галын аюулгүй байдлыг хангах, гал гарсан нөхцөлд авах арга хэмжээ болон гал унтраагуур түүнийг ашиглах талаар 1 удаа 1 цагийн сургалт хийсэн. Булган сумын 2-р цэцэрлэгийн багш ажилчдад “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 2 цагийн сургалтад 12 хүнийг хамруулж, ахлах болон дунд бүлгийн 34 хүүхдэд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар видео бичлэг үзүүлэн сургалт хийсэн. - 2018 оны 4-р сард Булган аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас зохион байгуулж буй сумдын БОХУБайцаагч, Байгаль хамгаалагч нарын нэгдсэн цугларалт сургалтанд Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай	
--	--	--	--	--	--	---	--

						хууль, Ойн тухай хууль болон гал түймрээс учирч буй хохирлыг тооцож байгаа эрхзүйн баримт бичгийн талаар сургалт хийгдэж, санал хүсэлтийг сонсож ажилласан. - Булган аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ирсэн хүсэлтийн дагуу Булган аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа Ус, Дулаанаар хангах аж ахуйн нэгжийн удирдлагуудад Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрмээр сургалт хийлээ. Сургалтад нийт 14 хүн хамрагдсан. - Булган сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа “ТЭС ПЕТРОЛУМ” ХХК-ийн 2 ШТС, “МАГНАЙ ТРЭЙД” ХХК-ийн 2 ШТС, “ШУНХЛАЙ” ХХК, “ГИГ ГАЗ” ХХК, “ЖАСТ ОЙЛ” ХХК, “НИК ПЕТРОВИС” ХХК зэрэг ШТС-уудын 17 ажилтан албан хаагч, Эрчим хүч үйлдвэрлэгч, түгээгч байгууллагуудын ажилтан албан хаагч, Булган сумын 4-р цэцэрлэгийн ажилтан нарт объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал унтраагуулыг хэрхэн ашиглах, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулах талаар 2 удаа 30 хүнд, Булган аймгийн Гурванбулаг, Рашаант, Могод, Тэшиг, Сэлэнгэ, Бугат Хишиг-Өндөр, Хангал сумдад ажилчдын сургалтыг 8 удаа 349 хүнд сургалт хийсэн.	
377	5.1.6.2. Сумдын объектын гал унтраах техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, галын сайн дурын бүлгэмийг томилгоожуулан ажиллах	2016-2020	ОБГ	1	Орон нутаг гарсан объектын гал түймрийн хохирлын хэмжээ багасна	- Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулахын тулд 2018 оны 03-р сард аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран төслийг боловсруулан аймгийн Онцгой комисс, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар 04-р сард оруулан хэлэлцүүлж 2018 оны 65 дугаар тогтоолоор батлагдан холбогдох алба, сумдад хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажиллалаа. - Түймрийн аюултай улиралд аюулын ангиллыг харгалзан хуурайшилт ихэссэн үед ойд мод бэлтгэх, аялах зугаалах, дагалт баялагийг ашиглахыг хориглож хязгаарласан аймгийн Засаг даргын “Ой, хээрт аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг түр хориглох тухай” 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн аймгийн Засаг даргын А/174 тоот захирамжийг гарган Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумдын Засаг дарга нарт үүрэг өгөн биелэлтийг хангуулан 2	100

						удаа хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан. - Сумдын гал унтраах чадавхийг дээшлүүлж 2018 оны аймгийн ой, хээрийн түймэртэй тэмцэх төлөвлөгөөнд сум, онцгой байдлын газарт гал түймэр унтраах багаж, тоног төхөөрөмж, техник авахад “Байгаль хамгаалах сан”-гаас 30 сая төгрөгийг тусган 25 сая төгрөгний 83 ширхэг үүргийн ус шүршигчийг худалдан авалт хийж түймэр гардаг сум, багуудад олгоод байна. 2018 оны 04-р сард Булган сумын Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар хамтран Булган сумын байгууллага, аж ахуйн нэгжийн ой, хээрийн түймэрт дайчилгаагаар ажиллах томилгоот 1, 2, 3 дугаар ээлжийн бие бүрэлдэхүүний, Яаралтай цуглар дохиогоор Цогт хунтайжийн талбайд цуглуулж, хувийн бэлтгэл болох хувцас, аранз, багаж зэвсэглэмжийн бэлэн байдлын үзлэг хийж илэрсэн зөрчилд арилгуулах үүрэг өгөн Булган сумын Соёлын ордонд ой, хээрийн галын түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах арга зүй, бэлэн байдлаа хангах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын хангах зэрэг сэдвээр сургалт хийж аюулгүй ажиллагааны зааварчлага өгч гарын үсэг зуруулан, аймгийн баяр наадмын цэнгэлдэх хүрээлэнд түймэр унтраах дадлага сургууль хийгдлээ. Сургалт, дадлагад Булган сумын 323 иргэн хамрагдсан. - 16 сум, 1 тосгоны хэмжээнд объектын гал унтраах тоног төхөөрөмжтэй болсон бөгөөд түүний хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар төсөл боловсруулан сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга нарт 1 дүгээр сард танилцуулсан. Сэлэнгэ сум өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан гал унтраах үндсэн албаны автомашинтай болсон. Онцгой байдлын газраас Хутаг-Өндөр, Могод, Хангал, Тэшиг суманд гал унтраах зориулалтын автомашин хүлээлгэн өгч байршуулж 5 дугаар сард дадлага сургалт хийгдлээ. Баян-Агт сум автомашин авахаар 8 сая төгрөг төсөвлөсөн. Рашаант сум 16 сая төгрөгөөр автомашинтай болсон байна. Сайхан, Тэшиг, Сэлэнгэ суманд 50 хүний бүрэлдэхүүнтэй галын сайн дурын бүлгэм байгуулж хөдөлмөр хамгааллын хувцсаар төслөөс хангуулсан. 2018 оны 5 дугаар сард ОБГ-аас 2 ажлын хэсгийг сумдад ажиллуулж	
--	--	--	--	--	--	---	--

						галын сайн дурын бүлгэмийг томилгоожуулах ажил зохион байгууллаа. Гамшгаас хамгаалах болон галын сайн дурын бүлгэмийг сумдад зохион байгуулахаар сумдад ОБГ-ын тоот хүргүүлж томилгоожуулах ажлыг хийж байна.	
378	5.1.6.3. Гал сөнөөгч, аврагч нарын ажил үүрэг гүйцэтгэх нөхцлийг сайжруулах зорилгоор спорт, сургалтын төвийн барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	ОБГ	15	Гал сөнөөгч, аврагч нарын ур чадвар сайжирч, бэлэн байдал сайжирна	- Газрын хэмжээнд албаны бэлэн байдлыг дээшлүүлэх, алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах талаар Гал түймэр унтраах, аврах 20, 50 дугаар анги, Эрэн хайх, аврах салбарын дарга, захирагч, Газрын техник, хэрэгсэл, хөдөлмөр хамгаалал хариуцсан мэргэжилтэн нар бие бүрэлдэхүүний аврах, гал унтраах машин техник, багаж хэрэгслийн бэлэн байдлыг 60 удаа шалган, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдээс ирсэн дуудлагуудад шуурхай арга хэмжээг авч ажилласанаар ямар нэг гомдол санал гараагүй ажиллаж байна. - Алба хаагчдын ажиллах нөхцөл, аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг угтаж анги, салбар, газрын өрөөнүүдэд засвар тохижолтыг ажлыг хийлээ. Ангийн гадна талд явган хүний автозамыг өөрсдийн нөөц бололцоогоор хийлээ. 3 замын уулзарын баганыг засварлаж шинэчиллээ. Газрын гадна талын хашааг шинээр хийлээ. Явуулын удирдлагын байрны зориулалтаар шуурхай дуудлагын ГАЗ-66 машинд засвар хийлээ. Жаргалант зусланд Сургалтын төвийн байрыг тоосгоор өнгөллөө. 3 нохионы байр барьлаа. Газар, анги, салбар, спорт заалны гадна талд гэрэлтүүлэг хийлээ. ОБГ-ын түүхэн музей байгууллаа. Онцгой байдлын газрын нийт албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор спорт, сургалтын төвийн барилга байгууламжийг 2016 онд эхлүүлэн 70 хувийн гүйцэтгэлийг хийж 2017 оны 6 сарын байдлаар барилгын дотор засвар, гадна пасадны ажлыг гүйцэтгэж, алба хаагчдын хувцас солих болон ариун цэврийн өрөөг шинээр барих ажил явагдаж 09-р сард ашиглалтанд өглөө. - Аймаг, орон нутгаас 80 жилийн ойн арга хэмжээтэй холбогдуулан зохион байгуулсан бэлтгэл ажилд тухай бүр Онцгой байдлын газраас идэвхтэй оролцож ирсэн.	100

						- Цэнгэлдэх хүрээлэнгийн засварын ажилд нийт бие бүрэлдэхүүн 2 өдөр ажиллаа. - “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяны хүрээнд хуваарийн дагуух орчны цэвэрлэгээг хийж тогтмол гүйцэтгэсэн - “Шарилжгүй-Булган” аяны хүрээнд хуваарийн дагуух орчны цэвэрлэгээг тухай бүр хийж хүлээлгэн өглөө. - 2018 онд гар бөмбөгийн зориулалтын шал суурьлуулсан. 7 хоног бүр бусад байгууллаганд заалны дэмжлэг үзүүлэн спортын арга хэмжээнд хамруулж байна. - “Эвийн өргөө-Энхийн гүйлт-2018” гүйлтийн Галт бамбарыг Булган аймгийн төвөөс 15 км зайд байрлах Зоон даваанаас хүлээн авч Онцгой байдлын газрын дарга, албан хаагч нар болон Булган аймгийн марафон гүйлтийн шигшээ багийн тамирчид Олон Улсын гүйгч нартай мөр зэрэгцэн галт бамбарыг тосон авч буухиалан гүйлээ. - Булган аймгийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд хамтран Зэвсэгт хүчин үүссэний 97 жилийн ой, Монгол цэргийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд "Марш тактик" тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээнд Онцгой байдлын газрын баг тамирчид амжилттай сайн оролцож 2-р байранд шалгарч, мөнгөн медалиар шагнууллаа. - ОБЕГ-аас зохион байгуулж буй Архангай аймагт болсон бүсийн урлагийн наадамд бэлтгэн оролцож 3-р байранд шалгарч, хүрэл медалиар шагнууллаа. - Онцгой байдлын газрын даргын 2018 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн А/14 тоот “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх” тушаалын дагуу Гал түймэр унтраах, аврах 20, 50 дугаар ангиуд, Эрэн хайх аврах салбарын автомашин техник, багаж зэвсэглэмжид сард 2 удаа түргэн авч үзлэг шалгалт хийж Гал унтраах үндсэн албаны автомашинуудын шанзны багажуудыг байршуулан тогтоон бэхлэж, шуурхай дуудлагын автомашинуудад хатуу холбоо, тросс, хүрз байршуулан бэлтгэл бэлэн байдлыг хангуулан, Ой, хээрийн түймэр унтраах багаж троссон шүүр 40 ширхэг, цохиур 50 ширхэгийг салаа бүлгүүдээр хийлгэж бэлтгэл бэлэн байдлыг ханган	
--	--	--	--	--	--	--	--

						ажилласан. - Газар, Гал түймэр унтраах, аврах 20, 50 дугаар анги, Эрэн хайх, аврах салбарт ашиглагдаж байгаа шуурхай дуудлагын автомашин, техник, тоног төхөөрөмжүүдэд графикийн дагуу техникийн засвар үйлчилгээг сар бүр хийлгэн салаа, бүлгүүдийн техник, багаж зэвсэглэмжийн бэлэн байдлыг хангуулж, “Нэгдсэн арга хэмжээ”-гээр 2 удаа түймрийн дуудлагаар гарч ажиллах бүлгүүдэд зайлшгүй байх техник, багаж зэвсэглэмж, хувийн бэлтгэлийн жагсаалт гарган шалгаж илэрсэн зөрчлийг засуулж ажилласан. - Орон нутгаас ой, хээрийн гал түймэрт дайчилагдан ажиллаж байгаа иргэдийг тухайн сумаас нь шаардагдах шатахуун, багаж хэрэгсэл, хоол хүнсийг гэрээ хийгдсэн байгууллага, аж ахуйн нэгжээс тасралтгүй үүрэг гүйцэтгэх боломжийг ханган ажиллаж хэвшээд байна. Онцгой байдлын газарт гамшгаас хамгаалах сангаас 5 сая төгрөгний шатахуун, 1,6 сая төгрөгний хоол, хүнсний нөөц бүрдүүлэн зарцуулсан. - 2018 оны 04-р сард Онцгой байдлын газрын алба хаагчид болон гэрээт ажилчдыг нэгдсэн эмнэлэгтэй хамтран нийт 92 ажилчдыг “цусны ерөнхий шинжилгээ, биохими, шээсний ерөнхий шинжилгээ”, ЭХО, Рентген шинжилгээнд 1 удаа үнэ төлбөргүй хамруулж, эрүүл мэндийн газарт өгсөн захиалгын дагуу хачиг, томуугаас сэргийлэх вакцин 3 удаа хийлгэлээ. - Аймгийн “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны хөтөлбөрт 11 алба хаагч хамрагдан тус бүр 0,75 га талбайд хүн бүр 200 ширхэг чацарганы суулгац тариалан хашаа, худаг усны асуудлыг шийдвэрлэн арчилж байна. 2018 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн бүх нийтийн мод тарих өдрөөр тус газрын алба хаагчид 100 ширхэг үхрийн нүд, Хялганат тосгон дахь ГТУА-50 дугаар ангийн бие бүрэлдэхүүн 10 ширхэг нарс модыг тарьж ургуулж байна.	
--	--	--	--	--	--	---	--

	379	5.1.6.4. Аймгийн Онцгой комиссын чадавхийг сайжруулж, хүч хэрэгслийн нөөцөд техник тоног төхөөрөмж авч, болзошгүй гамшгийн үед бэлэн байдлыг хангах	2016-2020	ОБГ	0	Аймгийн Онцгой комиссын болзошгүй эрсдлийн ажиллах чадвар сайжирна үед	-2018 онд гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, үүссэн нөхцөл байдлын хор уршгийг арилгах зорилгоор аймгийн Онцгой комиссыг 35 удаа хуралдаж мал аж ахуйн болон төв суурингийн өвөлжилт, малын гоц халдварт өвчин, хүчтэй салхи шуурга, ой, хээрийн болон объектын гал түймэр, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сэргээн босгох, сум, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлт зэрэг асуудлуудыг хэлэлцэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол 1, аймгийн Засаг даргын захирамж 19, Онцгой комиссын даргын тушаал 26, албан бичиг 28, Онцгой комиссын албан даалгавар 3 гаргуулан хэрэгжилтийг хангуулан гамшгаас хамгаалах сангаас 184 сая төгрөг, аймгийн Засаг даргын нөөц, бусад санхүүжилтээс 300 сая төгрөг зарцуулан ажилласан байна. - Гамшгийн эрсдлийн бууруулах чиглэлээр ОБЕГ-аас өгөгдөж байгаа үүрэг чиглэлийн дагуу бодлого барьж 2018 оны 02-р сарын 26-ны өдрийн “Эрсдлийн үнэлгээний баг томилох тухай” А/113 тоот захирамжаар холбогдох албадуудыг оруулан 17 хүний бүрэлдэхүүнтэй эрсдлийн үнэлгээний багийг томилон, эрсдлийн үнэлгээний багийн ажил үүргийн хуваарийг гарган эхний ээлжинд мал амьтны гоц халдварт шүлхий өвчний үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг гарган хэрэгжүүллээ. - 2018 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн “Гамшгийн эрсдлийг бууруулах орон нутгийн зөвлөл байгуулах тухай” А/486 тоот захирамжаар зөвлөлийг 19 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, орон нутгийн зөвлөлийн ажиллах журмыг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж эхлээд байна. - Мал аж ахуй, төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг чанартай хангуулахын тулд аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу Сэлэнгэ, Хангал суманд Онцгой байдлын газрын дарга ахалж, ХХААГ, БОАЖГ-ын мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй 2018 оны 9, 10 дугаар сард шалган зааварчилж, бэлтгэлийг хангуулж ажилласан. - Болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдлыг хангуулах зорилгоор аймгийн гамшгаас хамгаалах албад болох Булган “АЗЗА” ТӨХК, “ЭТ-БУЦТС” ТӨХК, “Булган мээж” ОНӨХК,	100
--	-----	---	-----------	-----	---	--	--	-----

							“Авто тээврийн үндэсний төвийн Булган салбар”-ын захирал, дарга нарт албаны бэлтгэл бэлэн байдлыг хангаж болзошгүй аюул эрсдэлийн үед ажиллах хүн хүч, техник хэрэгсэлийн тодотголыг хийж ажиллах талаар Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагчийн мэдэгдэлийг хүргүүлэн хяналт тавьж ажилласан. - Булган аймгийн нэгдсэн судалгаа сум, багийн тоо, сумын удирдах албан тушаалтан, хүн ам, мал амьтан, ургамал, зам даваа, гол нуур, цөөрөм, өндөр уул толгод, хил залгаа аймаг, сумд, улсын онц чухал объект, уур амьсгалын нөхцөл байдал, дэд бүтэц, үйлдвэр аж ахуй, ил далд уурхай, онцгой байдлын газрын хүч хэрэгслийн болон өвөлжилтийн нөхцөл байдлын судалгааг гарган гамшгаас хамгаалах аймгийн төлөвлөгөөнд тодотгол хийлээ. - Булган сумын 2, 3, 4-р цэцэрлэг, 12 жилийн 3 дугаар бүрэн дунд сургууль, Цагдаагийн газрын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж 2 төлөвлөгөөг газрын даргаар баталгаажуулсан. Нүүлгэн шилжүүлэлт, түр байрны мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгож зөвлөмж өгсөн. - Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Төв аймгуудын Онцгой байдлын газруудтай гамшиг осол гарсан тохиолдолд хамтран ажиллах төлөвлөгөөг гарган харилцан ажиллах гэрээг аймгуудын Засаг нараар 2017 оны 1 сард батлуулан /3 жил/ ажиллаж байна. - Аймгийн Онцгой комиссын нөөцөд 27 нэр төрлийн 206 ширхэг 95.2 сая төгрөгний эд зүйл бэлэн байдалд хадгалагдаж байна. Байгал хамгаалах сангаас 25.0 сая төгрөгний 83 ширхэг үүргийн ус шүршигчийг сумдад олгоод байна.	
--	--	--	--	--	--	--	---	--

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

/Д.ЭРДЭНЭБИЛЭГ/

ЗӨВШӨӨРСӨН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

/Б.ОДХҮҮ/

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

/Д.БАТЦОГТ/

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

/Д.БУМАНБАЯР/

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА	/Э.ТҮВШИНМӨНХ/	
ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА, ХУРАНДАА	/Х.ЗОЛЗАЯА/	
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБА	/О.УНДРАХ/	
ҮНЭЛГЭЭ ӨГСӨН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА		/Ш.БОЛДБААТАР/
ХЯНАСАН: АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА	/О.НАРАНЖАРГАЛ	
ТАНИЛЦСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ	/Ц.БАТ-ӨЛЗИЙ/	
	/О.ГАНТУЛГА/	
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА	/З.БАТЗОРИГ/	